СЭХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

**ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК**

Монгол улсын, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Гутал оффис, 3-р давхар

# ЭРЧИМ БОНД

| | |
|---|---|
| Нийт гаргах бондын тоо: | **50,000 ширхэг** |
| Бондын нэрлэсэн үнэ: | **10,000 төгрөг** |
| Нийт үнийн дүн: | **500,000,000 төгрөг** |
| Бондын хугацаа: | **6 сар** |
| Бондын жилийн хүү: | **18.50 %** |
| Бондын төрөл: | **Хямдруулсан үнэтэй бонд** |
| Хүү төлөх хугацаа: | **Хугацааны эцэст нэг удаа** |
| Бондын баталгаа: | **Даатгалын баталгаатай** |

## Андеррайтер

**ГОЛОМТ БАНК**

*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 5.
Утас: +976-70111646 И-мейл: ibd@golomtbank.com Веб: www.golomtbank.com

**ГОЛОМТ СЕКЮРИТИЗ**

Монгол Улс, Улаанбаатар 14200,
СБД-8, Их Эзэн Чингис хааны нэрэмжит талбай-2,
Сэнтрал Тауэр 606В тоот
Утас: +976-70121530 И-мейл: info@golomtsecurities.com Веб: www.golomtsecurities.com

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ТТН320 2571676
УЛААНБААТАР ХОТ

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДЫН МЭДЭЭЛЭЛ

**Үнэ цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 42, 43 дугаар зүйл, Үнэт цаасны тухай хуулийн 4, 5 дугаар зүйлсийг үндэслэн олон нийтэд нээлттэй бонд гаргаж байгаа болно.**

| | |
|---|---|
| **Бондын төрөл** | Хямдруулсан үнэтэй бонд |
| **Нэгж бондын нэрлэсэн үнэ** | 10,000 төгрөг |
| **Нийт ширхэг** | 50,000 ширхэг |
| **Нийт үнийн дүн** | 500,000,000 төгрөг |
| **Бондын хугацаа** | 6 сар |
| **Хүүгийн хэмжээ** | Жилийн 18.50% (сарын 1.54%) |
| **Хүү төлөх хугацаа** | Хугацааны эцэст нэг удаа |
| **Бондын эргэн төлөлт** | Хугацааны эцэст нэрлэсэн үнээр |
| **Бонд гаргах зорилго** | Тендерийн ажлын гүйцэтгэл, төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| **Бондын баталгаа** | Бондын Даатгалаар 100% даатгагдсан Даатгагч “Соёмбо Даатгал” ХХК |
| **Үндсэн андеррайтер** | “Голомт Банк” |
| **Туслах андеррайтер** | “Голомт Секюритиз” ҮЦК |
| **Бонд эзэмшигчдийн бүртгэл, төлбөр тооцооны хадгаламж** | “Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжын төв” ТӨХК |
| **Бонд арилжих зах зээл** | Монголын Хөрөнгийн биржийн арилжаагаар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаална. |

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРЫН АНХААРАЛД

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН "КОМПАНИЙ ТУХАЙ ХУУЛЬ" ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ БОНД ГАРГАН ТЕНДЕРИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖЛЫГ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

**ҮНЭ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ ОЛОН НИЙТЭД ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НЬ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ, АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү үнэт цаасны танилцуулгад, хөрөнгө оруулагч танд бонд худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйлийг Үнэт цаас гаргагч компани болон Андедрайтер Голомт банкинд хандаж авна уу.

Андеррайтерийн компани нь энэхүү үнэт цаасны танилцуулгыг бэлдэхдээ "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 28 дугаар зүйлд заасан мэргэжлийн компаний хариуцлага, ёс зүйн журмыг баримтлан аудитын компанид шалгуулсан санхүүгийн тайлангийн мэдээллийг алдаа, зөрүүгүйгээр авч ашигласан болно.

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГЫН ХУРААНГУЙ

Үнэт цаас гаргагч нь эрчим хүчний тоног төхөөрөмжийн зураг төсөл бэлтгэх, тоног төхөөрөмж борлуулах, зуучлах, засвар үйлчилгээ үзүүлэх, угсрах, зөвлөх, туршилт, тохируулгын чиглэлээр 1999 оноос хойш үйл ажиллагаа эрхэлж байна. 2015 оны 6 дугаар сарын байдлаар нийт 73 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагч нь байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл Эрчим хүч, Уул уурхай, Нийтийн аж ахуй, Барилгын чиглэлд өөрийн үйл ажиллагаагаа явуулж Дэлхийн банк, Азийн Хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн төслүүд болон орон нутаг, тухайн байгууллагын санхүүжилтээр хийгдсэн 100 гаруй төсөл, гэрээт ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнээс дурдвал:

- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн баруун 5 аймгийн нийтийн аж ахуйг сайжруулах төсөл
- Бороогийн алтны уурхайн үйлдвэрийн болон 110кВ-н ЦДАШ, дэд өртөөний угсралтын ажил
- 330кВ-н габарит бүхий хос дамжуулагчтай 95км урттай 220кВ-н ЦДАШ-н зураг төсөл, барилга угсралтын ажил
- БНХАУ-ийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 110кВ-н ЦДАШ, 110/35/10кВ-н дэд өртөө, 10кВ-н хорооллын гадна цахилгаан хангамжийн төслүүд
- ДЦС-4 н шинэчлэлийн төслүүд
- ДЦС-3 н шинэчлэлийн төслүүд
- ЦДҮС ТӨҮГ-н шинэчлэлийн төслүүд
- УБЦТС ТӨҮГ-н шинэчлэлийн төслүүд
- УБДШС ТӨҮГ-н шинэчлэлийн төслүүд
- УБ-МГ-ОТ 220кВ-н ЦДАШ-н ТЭЗҮ
- Хөвсгөл аймгийн Мөрөн хотын Дулаан станц болон дулааны шугамын ТЭЗҮ-н зураг төсөл
- Шивээ Овоогийн уурхайг түшиглэн барих 750МВТ-н цахилгаан станцын ТЭЗҮ

**Өрсөлдөгч**

Эрчим хүчний зөвлөх үйлчилгээ, барилга угсралтын чиглэлээр зах зээлд “Эрчим Инженеринг” ХХК–аас гадна “Эм Си Эс Интернейшнл” ХХК, “Эрчим Хүчний Барилга Угсралтын Трест” ХХК, “Илч Хангай” ХХК, “Алтай Трест” ХХК, “Цагаан Хорол” ХХК, “Мон Энержи Консалт” ХХК, “МонХорус” ХХК болон бусад байгууллага, компаниуд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр байгууллагуудтай зарим төсөл хөтөлбөр, тендерүүдэд өрсөлдөгч болж байгаа боловч хөгжлийн шатанд яваа манай улсын хувьд томоохон төслүүдийг нэг компани дангаараа гүйцэтгэх хүчин чадал дутмаг үй байдагтай холбоотойгоор хүн, хүч, машин механизм, хөрөнгө оруулалт ихээр шаардсан төслүүд дээр өрсөлдөхөөс илүү хамтран ажиллах нь элбэг байдаг.

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

**Үнэт цаас гаргагчийн бий болгосон давуу талууд**

- Байгуулагдсан цагаасаа хойш осол, аваар гаргаж байгаагүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын найдвартай тогтолцоог бий болгосон.
- Бондын эргэн төлөлтийг Соёмбо даатгалаар бондын нэрлэсэн дүнгийн хэмжээгээр бүрэн даатгуулсан.
- Төсвийн санхүүжилтээр хийгдэх тендер, төслийн ажлыг оновчтой санхүүжүүлэх шийдлийг нэвтрүүлсэн.
- Үнэт цаас гаргагч нь зах зээл дээр урьдчилан үйлдвэрлэсэн дэд өртөөг Франц улсын SCHNIEDER ELECTRIC компанитай хамтран нэвтрүүлж сүүлийн үеийн дэвшилтэт, зай талбай бага эзэлдэг, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, ухаалаг бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгохоор ажиллаж байна.
- 10 гаруй орны 20 компанитай эрчим хүчний тоног төхөөрөмжийн чиглэлээр хамтран ажилладаг. Мөн дотоодын 10 гаруй томоохон төрийн өмчийн болон хувийн хэвшлийн томоохон компаниудад тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байсан туршлагатай.

Үнэт цаас гаргагч нь 2014 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээр нийт 4.570 тэрбум төгрөгийн богино хугацаатай өр төлбөртэй байна. Үүнээс 800 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор Чингис хаан банкнаас 2 жилийн хугацаатай жилийн 21.6%-ийн хүүтэй 2014 оны 8 дугаар сарын 4-ны өдрийн 1133/01/CL-2014 дугаартай гэрээгээр зээлийн шугам нээн санхүүжүүлсэн. Мөн 1 тэрбум төгрөгийн дансны өглөгтэй байна. Эрчим Инженеринг ХХК нь 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Зээлийн мэдээллийн сангийн лавлагааны мэдээллээр 9 удаа зээл авч байсан ба хугацаа хэтэрсэн зээлийн түүхгүй, одоогоор зээлийн шугамын 565 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

## ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

Тус арилжаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн /МХБ/ ТУЗ-ын 2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 2014/05 тоот тогтоолоор баталсан "Бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-н 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "МХБ ТӨХК-ийн арилжааны журам"-ын дагуу явагдана.

Нийтэд санал болгон гаргаж буй 50,000 ширхэг бондыг 6 сарын хугацаатай анхдагч зах зээлд байршуулна. Нэгж бондыг 9,155 төгрөгөөр худалдаж хугацааны эцэст нэгж бондыг нэрлэсэн үнээр буюу 10,000 төгрөгөөр эргүүлэн худалдан авна.




Бондын арилжааг хэрэгжүүлэх үйл явц:

- 50,000 ширхэг, 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 500 сая төгрөгийн бондыг Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрөл гарч, Монголын Хөрөнгийн биржид бүртгэгдсэнээс хойш 2015 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн дотор анхдагч зах зээлд нэрлэсэн үнээр арилжаалаахаар төлөвлөж байна.
- Бондыг анхдагч зах зээлд байршуулснаас хойш ажлын 15 хоног дотор анхдагч зах зээлийн арилжаанд амжилттай хэрэгжүүлсэн тухай тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

**АГУУЛГА**

Хүснэгтийн жагсаалт ..... 7

Зургийн жагсаалт ..... 7

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ..... 8

Нэг. Үнэт цаас гаргагчийн талаарх мэдээлэл ..... 14

1.1. Үнэт цаас гаргагчийн танилцуулга ..... 14

1.2. Компаний хаяг, хариуцсан захирал, холбоо барих утас ..... 14

1.3. Үнэт цаас гаргагчийн түүх ..... 14

1.4. Зах зээлийн мэдээлэл ..... 18

1.5. Эрчим хүчний салбарт төрөөс баримталж буй бодлого ..... 24

1.6. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт ..... 29

1.7. Үнэт цаас гаргагчийн удирдах албан тушаалтнуудын мэдээлэл ..... 30

1.8. Ажилтан, албан хаагчдын мэдээлэл ..... 33

1.9. Гэрээ хэлцэл, тендер ..... 33

1.10. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандарт ..... 35

1.11. Чанарын хяналт ..... 39

1.12. Компанийн санхүүгийн мэдээлэл ..... 40

1.13. Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн талаар ..... 41

1.14. Хараат бус аудиторын тайлан ..... 42

1.15. Санхүүгийн тайлангийн шинжилгээ ..... 44

1.16. Үнэлгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлангийн дүгнэлт ..... 48

1.17. Үнэт цаас гаргахтай холбогдуулан гаргасан хуульчийн дүгнэлт ..... 50

1.18. Хууль эрх зүйн орчин ..... 58

Хоёр. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ..... 60

2.1. Олон нийтэд санал болгох бондын танилцуулга ..... 60

2.2. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр ..... 60

2.3. Бондын баталгаа ..... 60

2.4. Үнэт цаас эзэмшигчийн эрх ..... 65

2.5. Үнэт цаас гаргагчийн үүрэг ..... 66

2.6. Даатгагчийн хүлээх үүрэг ..... 66

2.7. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бондын хүүгийн түвшин ..... 66

2.8. Анхдагч зах зээлд байршуулах арилжаа ..... 69

2.9. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулах хөрөнгийн зарцуулалт, эдийн засгийн үр ашгийн тооцоо ..... 72

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

2.10. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчдад учирч болох эрсдэлийн хүчин зүйлс ........ 75

ГУРАВ. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД ........ 78

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Эрчим хүчний яамны 2015 оны хөрөнгө оруулалтын төсөв ........ 21
Хүснэгт 2: Дэд станц, ЦДАШ, Зураг төсөлд хувиарилсан төсөв ........ 21
Хүснэгт 3: Улсын төсвийн мэдээлэл 2009-2014 ........ 25
Хүснэгт 4: Улсын төсвийн хураангуй 2009-2014 ........ 26
Хүснэгт 5: ХАБЭМС-ийн үүрэг хариуцлагын хүснэгт ........ 36
Хүснэгт 6: Хөдөлмөр, хамгааллын хэрэгсэл ........ 38
Хүснэгт 7: Сүүлийн 3 жилийн компанийн баланс ........ 40
Хүснэгт 8: Орлогын тайлан ........ 41
Хүснэгт 9: Санхүүгийн шинжилгээ ........ 44
Хүснэгт 10: Балансын шинжилгээ ........ 45
Хүснэгт 11: Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн задаргаа ........ 46
Хүснэгт 12: Орлогын тайланд гүйцэтгэсэн босоо шинжилгээ ........ 46
Хүснэгт 13: Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ ........ 47
Хүснэгт 14: Эргэцийн шинжилгээ ........ 48
Хүснэгт 15: Цэвэр хөрөнгийн дүн ........ 49
Хүснэгт 16: Даатгалыг компаний санхүүгийн үзүүлэлт ........ 62
Хүснэгт 17: Түлхүүр үзүүлэлт ........ 62
Хүснэгт 18 Бондын баталгааны схем ........ 65
Хүснэгт 19: Засгийн газрын үнэт цаасны хүү ........ 67
Хүснэгт 20 Тендерийн ажлын гүйцэтгэл ........ 73
Хүснэгт 21 Эрчим Инженеринг ХХК-н 2015 оны ашгийн таамаглал ........ 74
Хүснэгт 22: Мөнгөн урсгалын таамаглал ........ 75

## Зургийн жагсаалт

Зураг 1: Хийж гүйцэтгэсэн ажлууд 2011 - 2014 он ........ 16
Зураг 2: БИОСКО-Б120Т дэд өртөө ........ 17
Зураг 3: GIS дэд өртөө ........ 18
Зураг 4: Дэд станц, ЦДАШ-ийн насжилт ........ 19
Зураг 5: Урт хугацаанд эрчим хүчний салбарт төсвөөс хийх хөрөнгө оруулалтын зарцуулалт 27
Зураг 6: Эрчим хүчний салбарт ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон эх үүсвэр, дамжуулах шугамын төслүүд ........ 28
Зураг 7: Компаний бүтэц ........ 29
Зураг 8: Компанийн хүний нөөц ........ 33
Зураг 9: Үйл ажиллагааны зардлын задаргаа ........ 47
Зураг 10: Төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ ........ 47
Зураг 11:ЗГҮЦ-ны хүү ........ 67
Зураг 12: Бондын хүүгийн харьцуулалт ........ 68
Зураг 13: Бондын нийтэд санал болгох хуваарь ........ 70

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

**Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан нэр томьёонууд нь дараах утгыг агуулна.**

| | |
|---|---|
| ЦДШ | Цахилгаан дамжуулах шугам |
| ЦДАШ | Цахилгааны дамжуулах агаарын шугам |
| Ам.доллар | Америкийн Нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт |
| Андеррайтер | Уг үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажлыг гүйцэтгэж буй “Голомт Банк” болон “Голомт Секюритиз ҮЦК” |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| Валютын ханш | Монгол Банкны тухай өдрийн төгрөгийн бусад валюттай харьцах мөнгөн нэгж |
| Зуучлагч | Үнэт цаасны зуучлагч андеррайтерийн компани |
| Төгрөг | Монгол улсын мөнгөн тэмдэгт |
| Үнэт цаас гаргагч | Үнэт цаасаа олон нийтэд санал болгон санхүүжилт татан төвлөрүүлж буй “Эрчим-Инженеринг” ХХК |
| ҮЦТТТХТ | Монгол улсын 100 хувийн төрийн өмчит “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжын төв” ХХК |
| ХАБЭА | Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуй |
| ХОБГ | Голомт банкны хөрөнгө оруулалтын банкны газар |
| ОУҮС | Олон Улсын Үнэлгээний стандарт |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| МХБ | Монголын Хөрөнгийн Бирж |
| ЗГҮЦ | Засгийн Газрын Үнэт Цаас |
| Даатгагч | Бондын даатгалын баталгааг гаргагч Соёмбо Даатгал ХХК |
| СХЗЗ | Санхүү Хөрөнгийн Зах зээл |

СЭХ БҮРТГЭВ №01

## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

### ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР: ГОЛОМТ БАНК

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

Голомт Банк ХХК нь 2011 оноос хойш андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тус эрхийн хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд /шинэчилсэн найруулга, 2013 оны 5 дугаар сарын 24/ заасны дагуу хөрөнгийн зах зээл дээр компани үнэт цаас гарган хөрөнгө босгоход андеррайтерын болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон юм.

*Эрчим-Инженеринг" ХХК-ийн төсөлд ажиллаж буй мэргэжилтнүүд*

| № | Овог нэр | Мэргэжлийн эрдмийн зэрэг цол | Албан тушаал | Ажлын туршлага | Холбоо барих |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ж.Хишигжаргал | Санхүү, Бизнесийн удирдлага, Магистр | Голомт банк Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал | СХЗЗ-д 2009 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70111646 - 1405<br>Гар утас: 99105166<br>И-мэйл: Khishigjargal_j@golomtbank.com |
| 2 | Б.Мядагмаа | Санхүүгийн удирдлага, Бакалавр | Хөрөнгө оруулалтын менежер | СХЗЗ-д 2013 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70111646 - 1404<br>Гар утас: 99031871<br>И-мэйл: myadagmaa@golomtbank.com |
| 3 | Б.Сугарсүрэн | Санхүүгийн удирдлага, Бакалавр | Хөрөнгө оруулалтын менежер | СХЗЗ-д 2013 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70111646 - 1404<br>Гар утас: 99190782<br>И-мэйл: sugarsuren@golomtbank.com |
| 4 | О.Оч | Эдийн засаг, Бакалавр | Бүтцэт санхүүжилт хэлтсийн захирал | СХЗЗ-д 2011 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70111646 – 1402<br>Гар утас: 99071553<br>И-мэйл: Och@golomtbank.com |

МОНГОЛ УЛС ... ГОЛОМТ БАНК

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Б.Тэнгис | Бизнес удирдлага, Мастер | Аналист | СХЗЗ-д 2014 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70111646 – 1406<br>Гар утас: 99905954<br>И-мэйл: tengis_b@golomtbank.com |
| 6 | Б.Уянгаа | Бизнес удирдлага, Бакалавр | Аналист | СХЗЗ-д 2011 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70111646 – 1406<br>Гар утас: 88011427<br>И-мэйл: Uyangaa@golomtbank.com |

## ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР: ГОЛОМТ СЕКЮРИТИЗ ҮЦК

| | |
|---|---|
| ГОЛОМТ СЕКЮРИТИЗ | Голомт Секюритиз ҮЦК нь 2011 оны 05-р сарын 24-ны өдөр байгуулагдсан бөгөөд брокерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг хөрөнгө оруулагч дотоод, гадаадын харилцагч, түншүүд, хамтран ажиллаж байгаа байгууллагуудаа чанарын өндөр түвшинд хүргэн ажиллаж байна. Мөн МХБ дээр үнэт цаасны арилжаанд шууд оролцох арилжааны систем нэвтрүүлсэн. |

| N | Овог нэр | Мэргэжлийн эрдмийн зэрэг цол | Албан тушаал | Ажлын туршлага | Холбоо барих |
|---|---|---|---|---|---|
| 1 | Э.Амарбаясгалан | Санхүүгийн удирдлага, Магистр | Гүйцэтгэх захирал | СХЗЗ-д 2006 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70121530<br>Гар Утас: 99108339<br>И-мэйл: - amar@golomtsecurities.com |
| 2 | О.Уянга | Санхүүгийн удирдлага, Бакалавр, магистр | Хөрөнгө оруулалтын менежер | СХЗЗ-д 2008 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70121530<br>Гар Утас: 99094282<br>И-мэйл: uyanga@ golomtsecurities.com |
| 3 | Б.Мөнхбат | Бизнесийн удирдлага, магистр | Хөрөнгө оруулалтын менежер | СХЗЗ-д 2005 оноос хойш ажиллаж байна. | Утас: 70121530<br>Гар Утас: 88008922<br>И-мэйл: munkhbat.do@ golomtsecurities.com |

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРДЭНИЙН ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

СЗХ
БҮРТГЭВ
№01

## ХУУЛИЙН КОМПАНИ: "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН

"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь "Эм Ди Эс энд Ассошэйтс" ЗБН болон "Хаанлекс Адвокэйтс" ЗБН-ийн нэгдлийн үр дүнд байгуулагдсан хуулийн фирм бөгөөд Монгол Улс дахь хамгийн олон гишүүнтэй хуулийн нөхөрлөл билээ. Тус хуулийн фирм нь олон улсын томоохон хуулийн фирмүүд болох Clyde & Co LLP, Sidley Austin LLP-тэй удаан хугацааны турш, тогтвортойгоор хамтран ажиллан мэргэжлийн түвшинд олон улсын стандартад нийцсэн эрх зүйн үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлэх боломжийг бий болгосон ба хууль зүйн хил дамнасан асуудлыг шийдвэрлэх чадамжтай хуулийн фирм юм.

Эм Ди Эс энд ХаанЛекс ХХН нь хууль эрх зүйн салбарын тэргүүлэх Legal500 болон AsiaLaw хэвлэлүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн фирм юм.

*"Эрчим-Инженеринг" ХХК-д хуулийн дүгнэлт өгсөн хуульчид:*

| № | Овог нэр | Мэргэжлийн эрдмийн зэрэг цол | Албан тушаал | Ажлын туршлага | Холбоо барих |
|---|---|---|---|---|---|
| 1 | Д.Дүгэржав | Хуульч | Партнер | Монгол Улсын эрх зүйн салбарт нийт 30 гаруй жил ажиллаж байгаа туршлагатай | Гар утас: (976)-99111981<br>И-мэйл: Dugerjav@mdsa.mn |
| 2 | Б.Одзаяа | Хуульч, бакалавр | Туслах хуульч | 2014 оноос "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-д ажиллаж байгаа. | (976)-11330048<br>Odzaya@mdsa.mn |

## АУДИТИЙН КОМПАНИ: АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын "Ай Жэй Эй Эйч- Аудит " ХХК нь 2008 оны 12 сарын 26-нд байгуулагдсан. 2009 оны 07 сарын 14-нд Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. 2009 онд Даатгалын байгууллагад аудит хийх эрх, 2014 онд Үнэт цаас гаргагчдад үйлчилгээ үзүүлэх эрхийг тус тус авсан.
Үндсэн 5, гэрээт 3 аудитортой, хуулийн зөвлөх 1, аудиторын туслах 6, туслах ажилтан 1 буюу нийт 16 ажилтантай.

*"Эрчим-Инженеринг" ХХК-д аудит хийсэн аудиторууд:*

| № | Овог нэр | Мэргэжлийн эрдмийн зэрэг цол | Албан тушаал | Ажлын туршлага | Холбоо барих |
|---|---|---|---|---|---|
| 1 | Г.Энхмаа | Бизнесийн удирдлагын магистр, Мэргэшсэн нябо | Гүйцэтгэх захирал | 28 жилийн ажлын туршлагатай, сүүлийн 10 гаруй жил санхүүгийн аудитороор ажиллаж байна. | Утас: 99040059 И-мэйл: Enkhmaa_56@yahoo.com |
| 2 | Н.Пэрэнлиймаа | НББ-ийн бакалавр, Мэргэшсэн нягтлан бодогч | Аудитор | Нийт 7 жилийн ажлын туршлагатай сүүлийн 5 жил аудитоор ажиллаж байгаа. | Утас: 99075985 И-мэйл: Peegii_0526@yahoo.com |
| 3 | Ц.Гэрэлмаа | НББ-ийн бакалавр, | Аудиторын туслах | 2 жил туслах аудитороор ажиллаж байна: | Утас: 99228828 И-мэйл: tugspiano@yahoo.com |

## ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ: ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК

2008 онд Хөрөнгийн үнэлгээ хийх, НББ-ийн зөвлөх үйлчилгээ өгөх үйл ажиллагаа явуулах чиглэлээр байгуулагдаж, 2010 оны 12 сарын 15-нд аудит хийх тусгай зөвшөөрөл авснаар Эвиденсе Аудит ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Эвиденсе аудит ХХК нь нягтлан бодогч, санхүүгийн мэргэжлээр төсвийн байгууллага, болон хувийн аж ахуйн нэгж байгууллагад ерөнхий болон ахлах нягтлан бодогч, нягтлан бодогч, аудитороор ажиллаж байсан туршлагатай 8 мэргэшсэн нягтлан бодогчид (үндсэн аудитор 5, гэрээт аудитор 3), мэргэшсэн 4 хөрөнгийн үнэлгээчинтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

*Эрчим-Инженеринг" ХХК-д хөрөнгийн үнэлгээ хийсэн үнэлгээчид*

| № | Овог нэр | Мэргэжлийн эрдмийн зэрэг цол | Албан тушаал | Ажлын туршлага | Холбоо барих |
|---|---|---|---|---|---|
| 1 | С.Бадамгарав | Бизнесийн удирдлагын магистр | Гүйцэтгэх захирал | Монголын хөрөнгийн зах зээлд 10 гаруй жил аудит, хөрөнгийн үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагатай. | Утас: 99057121 И-мэйл: info@evidenceaudit.mn |
| 2 | Т.Болортуяа | Бизнесийн удирдлагын бакалавр | Туслах үнэлгээчин | | Утас: 99075985 |

СЭХ БҮРТГЭВ № 01

## Нэг. Үнэт цаас гаргагчийн талаарх мэдээлэл

### 1.1. Үнэт цаас гаргагчийн танилцуулга

| | |
|---|---|
| Компанийн бүртгэгдсэн нэр: | “Эрчим Инженеринг”ХХК |
| Байгуулагдсан огноо: | 1999 он |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9011023073 |
| Регистрийн дугаар: | 2571676 |
| Хувьцаа эзэмшигч: | М. Батболд – 100% хувьцаа эзэмшдэг |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл: | Эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, угсралт, суурилуулалт, туршилт, тохируулга. Эрчим хүчний болон барилгын зураг төсөл Гадаад худалдаа |
| Үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан хугацаа: | 16 жил |
| Үйл ажиллагаа явуулах хугацаа: | Хугацаагүй |

### 1.2. Компаний хаяг, хариуцсан захирал, холбоо барих утас

**Компанийн төв байр:**

Монгол улсын, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Гутал оффис, 3-р давхар

**Утас:** 11 – 343256
**Факс:** 11 - 343255
**Вэб сайт:** www.erchim.mn
**Е-мэйл:** info@erchim.mn

| | | | |
|---|---|---|---|
| **Удирдлага:** | Гүйцэтгэх захирал Н.Баярмагнай | **Утас:** | 99114227 |

### 1.3. Үнэт цаас гаргагчийн түүх

Үнэт цаас гаргагч нь эрчим хүчний тоног төхөөрөмжийн зураг төсөл бэлтгэх, тоног төхөөрөмж борлуулах, зуучлах, засвар үйлчилгээ үзүүлэх, угсрах, зөвлөх, туршилт, тохируулгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Тус компани нь зах зээл дээр цахилгааны урьдчилан үйлдвэрлэсэн дэд өртөөний төхөөрөмжийг Герман улсын SCHNIEDER ELECTRIC Gmbh компанитай хамтран нийлүүлж цахилгааны сүүлийн үеийн дэвшилтэт хэмнэлттэй бүтээгдэхүүнийг анхлан

санал болгож байгаа албан ёсны хамтран ажиллах эрх бүхий дотоодын нийлүүлэгч юм.

Байгуулагдсан цагаас өнөөдрийг хүртэл Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, БНХАУ санхүүжилтээр хот, орон нутаг болон байгууллагын хүсэлтээр 100 гаруй төсөл, гэрээт ажлыг амжилттайгаар хийж гүйцэтгээд байна.

**Бизнесийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд**

Компани нь дараах үндсэн чиглэлээр ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд цаашид өөрийн үйл ажиллагааны чиглэлийг өргөтгөхөөр ажиллаж байна.

1. Эрчим хүчний яамны 163/13 дугаартай тусгай зөвшөөрөл
   - 0,4 – 220 кВ болон түүнээс дээш цахилгааны дамжуулах шугам, дэд станцын засвар үйлчилгээ, угсралт түүний туршилт тохируулга, дагалдах үйлчилгээ
   - 0.7-40 кгх/см2 даралттай шугам хоолой, ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга дагалдах үйлчилгээ
2. Зам тээвэр хот байгуулалтын яамны 3II-294/12 дугаартай зураг төслийн тусгай зөвшөөрөл
   - Дулааны шугам, гол сүлжээ түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
   - Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ түүнтэй холбоотой барилга байгууламжийн технологийн ажлын зураг
   - Цахилгааны дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220 КВ хүртэл/
   - Усны барилга байгууламжийн зураг төсөл
   - Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл

**Бизнесийн түүх**

Эрчим-Инженеринг ХХК нь 1999 онд байгуулагдан эрчим хүчний тоног төхөөрөмжийн зураг төсөл, засвар үйлчилгээ, угсралт, туршилт тохируулгын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл Эрчим хүч, Уул уурхай, Нийтийн аж ахуй, Барилгын чиглэлд өөрийн үйл ажиллагаагаа явуулж Дэлхийн банк, Азийн Хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн төслүүд болон орон нутаг, тухайн байгууллагын санхүүжилтээр хийгдсэн 100 гаруй төсөл, гэрээт ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнээс дурдвал:

- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн баруун 5 аймгийн нийтийн аж ахуйг сайжруулах төсөл
- Бороогийн алтны уурхайн үйлдвэрийн болон 110кВ-н ЦДАШ, дэд өртөөний угсралтын ажил
- 330кВ-н габарит бүхий хос дамжуулагчтай 95км урттай 220кВ-н ЦДАШ-н зураг төсөл, барилга угсралтын ажил
- БНХАУ-ийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 110кВ-н ЦДАШ, 110/35/10кВ-н дэд өртөө, 10кВ-н хорооллын гадна цахилгаан хангамжийн төслүүд
- ДЦС-4 н шинэчлэлийн төслүүд
- ДЦС-3 н шинэчлэлийн төслүүд
- ЦДҮС ТӨҮГ-н шинэчлэлийн төслүүд
- УБЦТС ТӨҮГ-н шинэчлэлийн төслүүд
- УБДШС ТӨҮГ-н шинэчлэлийн төслүүд
- УБ-МГ-ОТ 220кВ-н ЦДАШ-н ТЭЗҮ
- Хөвсгөл аймгийн Мөрөн хотын Дулаан станц болон дулааны шугамын ТЭЗҮ-н зураг төсөл
- Шивээ Овоогийн уурхайг түшиглэн барих 750МВТ-н цахилгаан станцын ТЭЗҮ

*Зураг 1: Хийж гүйцэтгэсэн ажлууд 2011 - 2014 он*



**Шивээ-Овоо 750МВА Цахилгаан станц, 2014**
Шивээ-Овоо нүүрсний уурхайг түшиглэн баригдах 750МВА ЦС-ын ТЭЗҮ боловсруулах
**Захиалагч:** [illegible] Power Plc, [illegible]



**Хятадын засгийн газрын зээлээр хэрэгжиж төсөл 2013~2015**
Орон сууцны МҮОНРТ хорооллын цахилгаан хангамж, 110/35/10kV GIS дэд станц, 10кВ-ын РП, КТП, кабель шугам.
**Захиалагч:** [illegible]



**Хятадын засгийн газрын зээлээр хэрэгжиж төсөл 2013~2015**
Орон сууцны 7-р хорооллын цахилгаан хангамж, 110/35/10kV дэд станц, 10кВ-ын РП, КТП, кабель шугам.
**Захиалагч:** [illegible]



**Хятадын засгийн газрын зээлээр хэрэгжиж төсөл 2013~2014**
7-р хороолол, МҮОНРТ 110кВ-ын ЦДАШ, 26км
**Захиалагч:** [illegible]



**Салхит 50МВА салхин парк 2013**
110/35кВ-ын дэд станцын тоног төхөөрөмжийн хангах нийлүүлэлт, SCADA тоног төхөөрөмжийн нийлүүлэлт угсралт, програм хангамж
**Захиалагч:** Leighton Asia



**Салхит 50МВА салхин паркын зураг төсөл 2012**
110/35кВ-ын GIS дэд станц, 35/0.69кВ-ын дэд өртөө, 35кВ-ын кабель шугам, Реле хамгаалалт, SCADA зураг төсөл
**Захиалагч:** Leighton Asia



**Оюу толгой-Гашуун сухайт ЦДАШ – 2р үе шат 2012**
Оюу толгой – Гашуун сухайт чиглэлийн 220кВ-ын ЦДАШ-ын утас болон OPGW татлага, 95км
**Захиалагч:** Rio Tinto/Оюу Толгой ХХК



**Оюу толгой-Гашуун сухайт ЦДАШ – 1р үе шат 2011**
Оюу толгой – Гашуун сухайт чиглэлийн 220кВ-ын ЦДАШ-ын барилга угсралт, [illegible], 24,5км
**Захиалагч:** Rio Tinto/Оюу Толгой ХХК



**Эрчим Хүчний Хөтөлбөр 1 төсөл. 2010**
Германы KFW банкны зээлээр хэрэгжсэн ЭХХ-1 төслийн хүрээнд ТБЦДС-ний 20 дэд станцын тогтмол гүйдлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх
**Захиалагч:** [illegible]/ТБЦДС



**Оюу толгой-Гашуун сухайт ЦДАШ 2010**
Оюу Толгой-Гашуун сухайт чиглэлийн 330кВ-ын овортой, 2 хэлхээт хос дамжуулагч бүхий ЦДАШ-ын зураг төсөл
**Захиалагч:** Rio Tinto/Оюу Толгой ХХК



**Дундговь[illegible] ОУХТ 2010**
2 x 2500КВА 10/0.4кВ дэд өртөө, 10кВ-ын вакуум тасалгуур РП, 0.4кВ-ийн хуваарилах байгууламжийн тоног төхөөрөмж нийлүүлэлт угсралт
**Захиалагч:** [illegible]



**Бороо Гоулд уурхайн үйлдвэрийн өргөтгөл 2010**
Бороогийн уурхайн боловсруулах үйлдвэрийн өргөтгөлийн зураг төсөл, дотоодын зээлээ
**Захиалагч:** [illegible]

### Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд

*БИОСКО-Б120Т 10/0,4кВ-н 1250кВА хүртэл чадалтай дэд өртөө*

Тус компани нь зах зээл дээр урьдчилан үйлдвэрлэсэн дэд өртөөг Франц улсын SCHNIEDER ELECTRIC компанитай хамтран нэвтрүүлж сүүлийн үеийн дэвшилтэт, зай талбай бага эзэлдэг, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, ухаалаг бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгож байгаа албан ёсны хамтран ажиллах эрх бүхий дотоодын нийлүүлэгч юм. Энэ дэд өртөө нь өнөөдрийн ашиглагдаж байгаа уламжлалт дэд өртөөнөөс дараах давуу талуудтай болно. Үүнд:

- Аюулгүй ажиллагааг бүрэн хангасан
- Зай талбай бага шаарддаг. Дэд өртөөг 3 дахин бага зайд барьж болно
- Цаг хугацаа хэмнэсэн. Газар дээр нь 3 хоногийн дотор угсарч бэлэн болгох боломжтой
- Шаардлагатай үед нүүлгэн шилжүүлэх боломжтой
- Барилга угсралтын ажлын зардлыг хэмнэсэн
- Ашиглалтын үед засвар үйлчилгээ шаардахгүй
- Галд тэсвэртэй
- Дуу чимээний хамгаалалттай
- Ус чийгээс бүрэн хамгаалагдсан
- Нумын хамгаалалттай
- Байгаль орчинд ээлтэй
- Хяналт удирдлагын ухаалаг систем нэвтрүүлэх техникийн боломжтой
- Олон улсын IEC 62271-202 стандартын шаардлагыг хангасан.
- IEC 62271-202 стандартыг бүрэн орчуулж үндэсний стандарт болгосон
- Газар хөдлөлтөд тэсвэртэй. 8 баллын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадвартай
- ЭХЯ, УБЦТС ТӨҮГ-с Монгол улсад ашиглаж болох зөвшөөрөл өгөгдөж эрх зүйн орчин бүрдсэн
- Зураг төслийн ажлыг хөнгөвчилсөн

*Зураг 2: БИОСКО-Б120Т дэд өртөө*



10/0,4кВ-н 2x1250кВА уламжлалт дэд өртөө



10/0,4кВ-н 2x1250кВА уламжлалт дэд өртөөнөөс 3 дахин бага зай талбай эзэлдэг БИОСКО-Б120Т дэд өртөө

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

**110кВ-н далд хуваарилах байгууламж**

"Эрчим Инженеринг" ХХК нь ТБЭХС-н хэмжээнд анх удаа 110кВ-н далд хуваарилах байгууламжийг нэвтрүүлж ашиглалтанд оруулах гэж байна.

*Зураг 3: GIS дэд өртөө*



110/35/10кВ-н 2х40МВА уламжлалт дэд өртөө



Уламжлалт 110/35/10кВ-н 2х40МВА-н дэд өртөөнөөс 3-4 дахин бага зай талбай бага эзэлдэг GIS дэд өртөө

## 1.4. Зах зээлийн мэдээлэл

**Эрчим хүчний салбарын чиг хандлага**

Эрчим хүчний салбар нь төрийн нарийн зохицуулалттай, Монгол улсын эдийн засаг, нийгмийн салбарт онцгой чухал байр суурь эзэлдэг салбар юм. Монгол улсын хувьд эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадал 2015 оны байдлаар 950 МВТ болж өссөн бөгөөд 2020-2025 оны үед 2000МВТ болох хэтийн төлөвтэй байгаа нь эрчим хүчний салбарын ирээдүйн өсөлт хэрэгцээ жилээс жилд нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

2007-2014 оны хооронд Монгол улсын эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 8 - 9%-иар өсөж байна. Энэхүү эрчим хүчний эрэлт нь Монгол улсын уул уурхайн салбараас бий болсон эрчимтэй өсөлтөөс хамааралтай байна. Монгол улсын нийт суурилагдсан хүчин чадал 2015 онд 1375 мегаватт болох урьдчилсан тооцоо гарсан байна. Монгол улсын засгийн газрын зүгээс эрчим хүчний өсөж буй эрэлтийг хангахын тулд дараагийн жилд 770-880 мегаваттын хүчин чадалтай цахилгаан, дулааны станц барих шаардлагатайг онцолж байна.

Монгол улсын эрчим хүчний сүлжээ нь төвийн эрчим хүчний сүлжээ, баруун бүсийн эрчим хүчний сүлжээ, зүүн зүгийн эрчим хүчний сүлжээнээс бүрддэг. Дээрх 3 бүсийн эрчим хүчний сүлжээ нь төвийн эрчим хүчний сүлжээнд өнөөгийн байдлаар холбогдоогүй байна. Төвийн эрчим хүчний сүлжээ нь нийт Монгол улсын эрчим хүчний 91 хувийг үйлдвэрлэж, нийт эрчим хүчний хэрэглээний 96 хувийг хангаж байна. Монгол улсын нүүрсээр галладаг цахилгаан дулааны станцын нийт

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

суурилагдсан хүчин чадал нь 828 мегаватт боловч насжилт, тоног төхөөрөмжийн элэгдлийн улмаас 649 мегаватт нь ашиглагдаж байна. Энэхүү эрчим хүчний хязгаарлагдмал байдал нь дотоодод эрчим хүчний хомсдлыг үүсгэж байгаа ба одоогийн байдлаар ОХУ-аас импортлон хэрэгцээг хангаж байна.

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд болон 140 гаруй сумын төвийг эрчим хүчээр хангадаг цахилгаан, дулааны станц нь Төвийн эрчим хүчний өмчлөлд байдаг. Эрчим хүчний доголдол нь түгээмэл тохиолддог ба төвийн эрчим хүчний бүсээс алслагдсан говийн бүсэд Оюутолгой, Тавантолгой гэх мэт уул уурхайн томоохон ордууд байдаг. Иймээс говийн бүсийн эрчим хүчний огцом эрэлтийг хангах нийлүүлэлт, үйлдвэрлэлийг уул уурхайн төслүүдийн хөгжүүлэлттэй уялдуулан хангах хэрэгцээ тулгараад байна. 2014 онд Монгол улс нийт эрчим хүчний хэрэглээний 22%-ийг ОХУ-аас импортолсон . Засгийн газрын зүгээс эрчим хүчний хараат байдлыг бууруулахын тулд дотоодын эрчим хүчний станцын төслүүдийг идэвхжүүлж байна.

### Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний 5 системд35кВ-ын 8880км шугам, 260 дэд станц, 15кВ-ын 3638км шугам, 829 дэд станц, 6-10кВ-ын 12254км шугам, 3833 дэд станц, 0,22-0,4кВ-ын 10128км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудаар 15 тусгай зөвшөөрөл эзэмшигч бүхий компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

Цахилгаан түгээх сүлжээнд тулгамдаж буй гол асуудал нь үндсэн тоноглолуудын насжилт өндөр болсон явдал юм. 1970-1990 оны хооронд цахилгаан түгээх сүлжээг эрчимтэй барьж байгуулж байсан ба өдгөө эдгээрийн ашиглалтын хугацаа дуусч, цаашид ашиглахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа нь эрчим хүчний салбарт төрийн зүгээс зайлшгүй хөрөнгө оруулалт хийх шаардлагыг бий болгож байна.

Орон нутгийн цахилгаан түгээх сүлжээний үндсэн тоноглолын насжилтийн хувьд 20 жилээс дээш насжилттай цахилгаан дамжуулах агаарын шугам нь 50%-ийг, үлдсэн 50% нь 20 хүрэхгүй жилийн насжилттай байна. Дэд станцуудын 65% нь 20 жил ба түүнээс дээш жилийн насжилттай байна.

*Зураг 4: Дэд станц, ЦДАШ-ийн насжилт*




Эх сурвалж: Эрчим хүчний яам

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Мөн хөдөө орон нутагт тавигдсан модон тулгуурын ашиглалтын хугацаа дуусаж /15 жил/ ялзарч муудан унаж байгаа, үйлдвэрлэлийн осол удаа дараа гарсан ашиглалтын зардал өндөр, МХЕГазраас ашиглахыг хориглосон шугамууд олон байгаа ба дараах нэн чухал шаардлагатай байгаа сумдын ЦДАШ-н шинэчлэлтийн хөрөнгө оруулалтыг 2015 оны төсөвт суулгаж өгсөн.

- Цагаан суварга - Мандахын 22 кВ-ын 60.85 км ЦДАШ, дэд станц /Дорноговь, Мандах/
- Цагаан суварга - Хатанбулагийн 35 кВ-ын ЦДАШ, дэд станц барих
- Төгрөг-Бугатын 15 кВ-ын 52,5 км ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/
- Багануур-Цэнхэрмандал 35кВ-ын 60.2 км ЦДАШ, 35/6кВ-ын дэд станц барих /Хэнтий/
- Улаантолгой-Бургалтайн 35 кВ-ын ЦДАШ, 35/6кВ-ын дэд станц барих
- /Орхон/ 0,4 - 35,110 кВ-ын ЦДАШ, дэд станцын өргөтгөл шинэчлэл

**Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад төлөвлөгдсөн эрчим хүчний шинэтгэл**

2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаас Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын гэр хорооллын цахилгаан хангамжийг найдвартай болгох, хэрэглэгчдийн ЦЭХ-ийг өвлийн улиралд хязгаарлалт хийхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хүчин чадалдаа тулсан дэд станцын ачааллыг бууруулахаар шинээр хуваарилах байгууламжууд болон дэд станцыг өргөтгөх ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Шинээр баригдсан 110 кВ-ын дэд станцаас хуваарилах байгууламжууд руу 6 кВ-ын кабел татах /Дархан-Уул/
- Хотын төвд 2*16 МВА чадал бүхий газар доор 35 кВ-ын дэд станц, 6-10 кВ-ын 6 гаргалга шугам татах /Улаанбаатар/
- Төвийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн хаалттай дэд станцуудын хоорондох кабел шугамыг шинэчлэх, дэд станцуудын хооронд шинээр кабел шугам татах /Улаанбаатар/
- Өмнөд дэд станцын 35/6 кВ-ын 2*10000 кВа чадалтай өргөтгөл /Орхон/
- Хаалттай хуваарилах байгууламж 7-ийн өргөтгөл /Улаанбаатар/
- ИХБ-3-ийн 110/35/6 кВ-ын Т-1, Т-2 хүчний трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх /Улаанбаатар/

*Хүснэгт 1: Эрчим хүчний яамны 2015 оны хөрөнгө оруулалтын төсөв*

Сая.төг

| | 2014 батлагдсан | 2015 | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төсөвт өртөг | Байгууллагын санал | Хязгаарт бариулсан | Хязгаарт багтаагүй |
| **ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН НИЙТ ДҮН** | **146,370** | **1,428,591** | **700,693** | **157,732** | **442,174** |
| **Хөрөнгө оруулалт** | 146,370 | 824,106 | 383,678 | 157,732 | 123,870 |
| **Шилжих** | **146,370** | **468,551** | **169,462** | **85,612** | **83,850** |
| 1.1 ЦДАШ, дэд станц | 69,966 | 126,772 | 62,173 | 61,323 | 850 |
| 1.2 ДЦС, дулааны шугам | 73,396 | 311,849 | 101,745 | 18,745 | 83,000 |
| 1.3 Нийслэлийн агаарын бохирдол бууруулах | 2,009 | 5,000 | 834 | 834 | - |
| 1.4 Гадаадын зээлээр хэрэгжих дотоод эх үүсвэр | 1,000 | 12,200 | 2,623 | 2,623 | - |
| 1.5 ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах | - | 12,171 | 2,088 | 2,088 | - |
| **Шинээр эхлэх** | **-** | **355,555** | **214,215** | **72,126** | **40,020** |
| 2.1 ЦДАШ, дэд станц | - | 260,802 | 166,029 | 44,192 | 32,207 |
| 2.2 ДЦС, дулааны шугам | - | 87,553 | 43,279 | 26,685 | 7,813 |
| 2.3 Тоног төхөөрөмж | | 7,200 | 3,700 | 1,250 | |
| **Хөгжлийн банкны зээл, бондын хөрөнгөөр хийгдэж буй ажлууд** | | **604,485** | **318,304** | **-** | **318,304** |

Эх сурвалж: Эрчим хүчний яам

*Хүснэгт 2: Дэд станц, ЦДАШ, Зураг төсөлд хувиарилсан төсөв*

| | Шилжих дүн | 2014 оноос шилжих | 2013 оноос шилжих | 2012 оноос шилжих |
|---|---|---|---|---|
| **Нийт шилжих** | **85,612.40** | **65,174.00** | **17,079.90** | **3,358.50** |
| 1.1 ЦДАШ, дэд станц | | 52,633.60 | 5,330.80 | 3,358.50 |
| 1.2 ДЦС, дулааны шугам | | 12,540.50 | 6,204.40 | |
| 1.3 Нийслэлийн агаарын бохирдол бууруулах | | | 833.6 | |
| 1.4 Гадаадын зээлээр хэрэгжих дотоод эх үүсвэр | | | 2,623.10 | |
| 1.5 ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах | | | 2,088.00 | |

Эх сурвалж: Эрчим хүчний яам

Эрчим хүчний шугам сүлжээний зураг, ТЭЗҮ, ЦДАШ, дэд станцын шинэчлэл, 2015 онд шинээр барих нийт эрчим хүчний хөрөнгө оруулалтын багц зардалд 157 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил багтсан байна.

## ДҮГНЭЛТ

Дээрх төлөвлөгдсөн бүтээн байгуулалттай холбоотойгоор эрчим хүчний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хийгдэх, цахилгаан дамжуулах сүлжээ, цахилгаан түгээх сүлжээ, дулааны шугам сүлжээний томоохон төслүүдийг хэрэгжүүлэх хэрэгцээ гарч ирж байгаа нь эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын ирээдүйд ихээхэн хөрөнгө оруулалт болж зах зээлийг нээн өгч, бусад салбаруудтай харьцуулахад бизнесийн тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж илүү байгааг харуулж байна.

Мөн төр хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр эрчим хүчний салбарт хувьчлал хийх, хувийн хөрөнгө оруулалтаар эх үүсвэр барих зэрэг стратегийн ач холбогдол бүхий зорилтот томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа нь энэ салбарт хувийн хэвшлийн бизнесийн шинэ нөөц бололцоог бий болгож байна.

Энэ нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хувьд ихээхэн ирээдүйтэй зах зээл болох юм. Мөн эрчим хүчний салбарын хувьчлалд мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөхөд чухал түлхэц болж байна.

**Өрсөлдөгчдийн судалгаа**

Эрчим хүчний зөвлөх үйлчилгээ, барилга угсралтын чиглэлээр зах зээлд "Эрчим Инженеринг" ХХК–аас гадна

- "Эм Си Эс Интернейшнл" ХХК
- "Эрчим Хүчний Барилга Угсралтын Трест" ХХК
- "Илч Хангай" ХХК
- "Алтай Трест" ХХК
- "Цагаан Хорол" ХХК
- "Мон Энержи Консалт" ХХК
- "МонХорус" ХХК

болон бусад байгууллага, компаниуд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг болно. Эдгээр байгууллагуудтай зарим төсөл хөтөлбөр, тендерүүдэд өрсөлдөгч болж байгаа боловч хөгжлийн шатанд яваа манай улсын хувьд зах зээл жижиг, мөн ихэнх компаниуд том төслүүдийг дангаараа гүйцэтгэх хүчин чадалгүй байдагтай холбоотойгоор хүн, хүч, машин механизм, хөрөнгө оруулалт ихээр шаардсан төслүүд дээр өрсөлдөхөөс илүү хамтран ажиллах нь элбэг байдаг.

**"Эрчим-Инженеринг" ХХК-ийн давуу талууд**

- Олон жилийн харилцаа, хамтын ажиллагааны улмаас итгэл олсон үйлдвэрлэгч, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчнараас өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийг худалдан авахдаа харьцангүй бага урьдчилгаа төлж ажил үйлчилгээндээ ашиглах боломжтой байдаг
- Гадаадаас нарийн мэргэжлийн мэргэжилтэн, сургагч нарыг урин ажиллуулах боломжтой

СЗХ
...сел... ...дэ...
БҮРТГЭВ
№ 01

- Тогтвор суурьшилтай ажилладаг инженерийн болон мэргэшсэн ажилтнуудтай
- Бусад байгууллагуудад байхгүй тоног төхөөрөмж, программ хангамж зэргээр хангагдсан
- Томоохон төсөл хөтөлбөрүүдийн ТЭЗҮ, Зураг төсөл зэрэг зөвлөх үйлчилгээ болон барилга угсралтын цогц ажлыг бүтнээр нь буюу түлхүүр гардуулах нөхцөлөөр хийж гүйцэтгэх боломжтой
- Зөвхөн дотоодын зах зээл дээр бус гадаадын зах зээлд хэрэгжиж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүдэд гадаадын үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагч нартай хамтран ажилласан туршлагатай. Энэ нь цаашид дотоодын мэргэжлийн байгууллагууд, инженер, техникийн ажилчид болон мэргэшсэн ажилчдын хүчээр олон улсын хэмжээнд томоохон бүтээн байгуулалтад оролцох боломжийг нээж өгсөн юм.

**Хамтран ажилладаг байгууллагууд:**

"Эрчим Инженеринг" ХХК нь гадаад, дотоодын олон байгууллагатай хамтран ажилладаг бөгөөд эдгээрийн төлөөллөөс дурьдвал:

**Гадаадын хамтран ажилладаг байгууллагуудын төлөөлөл:**

- Финлянд улсын PROSPERO (www.prospero.fi)
- Франц улсын SCHEIDER ELECTRIC компани (www.schneider-electric.com)
- АНУ-н SEL(www.selinc.com)
- АНУ-н ETAP (www.etap.com)
- Австрали улсын AURECONGROUP (www.aurecongroup.com)
- Чех улсын OEZ (Siemens) (www.oez.com)
- ИБУИНВУ-н IMPOWER PLC (www.impowerplc.com)
- ХБНГУ-н HOPPECKE BATEREIN GmbH (www.hoppecke.com)
- Канад улсын ENERGITIX (www.energitix.com)
- Японы YOKOGAWA (www.youkogawa.com)
- ОХУ-н
  - ТМ-СМАРА (www.electroshield.ru )
  - Премьер Энерго (www.pr-energo.ru)
  - Иркутск кабел (www.irkutskkabel.ru)
  - Камкабел (www.kamkabel.ru)
- БНХАУ-н
  - BCEG (www.bcegi.com)
  - TK Group (www.tk-electric.com)
  - LEEEC (www.leeec.com)
  - ZTT Cable (www.zttcable.com)
  - China Gezhouba Group (www.cggc.cc)

**Дотоодын хамтран ажилладаг байгууллагуудын төлөөлөл:**

- Диспетчерын Үндэсний Төв (ДҮТ) (www.ndc.energy.mn)

- Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ (www.transco.energy.mn)
- Улаанбаатар Цахилгаан Түгээх Шугам Сүлжээ (www.ubedn.mn)
- Улаанбаатар Дулааны Шугам Сүлжээ (www.ubds.energy.mn)
- ЛЕЙТОН ХХК (www.leightonasia.com/mn)
- ОЮУ ТОЛГОЙ ХХК (www.ot.nm )
- БОРОО ГОУЛД ХХК (www.boroogold.mn)
- МАК ХХК (www.mak.mn)
- БУК-2 (www.ubbuk.mn)
- MSEL (www.msel.mn)
- ENCC (www.encc.mn)

“Эрчим-Инженеринг” ХХК нь үндсэн үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаас гадна нийгмийн хариуцлагын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд дараах ТББ-н гишүүн, удирдах зөвлөлд төлөөллөө оруулан ажилладаг юм. Үүнд:

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн
- Эрчим Хүчний Барилга, Засварчдын Холбооны гишүүн
- Эрчим Хүчний Зураг Төсөл Зохиогчдын Холбоо гишүүн
- Монголын Барилгын Үндэсний Ассоциацын гишүүн

## 1.5. Эрчим хүчний салбарт төрөөс баримталж буй бодлого

**Монгол улсын төсөв**

Монгол улсын төсвийн төслийг боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон аливаа харилцааг Монгол улсын Төсвийн тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиудаар зохицуулдаг.

Монгол улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн хөрөнгийг Монгол банканд байрших Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирддаг. Засгийн газраас улсын төсвийн ил тод, нээлттэй, ойлгомжтой байдал, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хөгжүүлэхийн үүднээс 2014 оны 07-р сарын 01-ний өдрөөс Шилэн дансны тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн. Тус хуулийн дагуу төрийн санхүүжилттэй, төсвийн байгууллагын санхүүгийн хөрөнгийн талаарх мэдээлэл болон төрийн сангийн нэгдсэн дансны мэдээллийг олон нийтэд нээлттэй байрлах Сангийн яамны цахим хуудаснаас нээлттэй авах боломжтой болсон.

Улсын төсөв нь орлого, зарлагын төсөвлөсөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд жил бүр хууль тогтоох дээд байгууллагын баталснаар төсөв нь хуулийн хүчин төгөлдөр санхүүгийн баримт бичиг болно.

Монгол улсын жил бүрийн төсвийг бэлтгэх хүрээнд төсвийн дунд хугацааны мөнгөн урсгалын төсөөлөл болон жилийн төсвийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн төлөвлөгөөг хангана ажиллуулах бэлтгэл ажил хийх зэрэг ажлууд багтдаг. Төсвийн төслийн төсөөллийг аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны төв байгууллага бэлтгэн Сангийн яаманд танилцуулж, Сангийн яамнаас

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

нэгдсэн байдлаар Улсын Их Хурал /УИХ/-ын байнгын хороо, цаашлаад УИХ-д танилцуулагдсанаар батлагддаг. Монгол улсын төсвийн төслийг боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон аливаа харилцааг Монгол улсын Төсвийн тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиудаар зохицуулдаг.

**Монгол улсын 2015 оны төсвийн тухай**

Монгол улсын 2015 оны төсвийн тухай хууль 2014 оны 11-р сарын 14-ны өдөр батлагдаж, 2015 оны 01-р сарын 23-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулан баталсан.

Төсвийн тухай хуульд 2015 онд Монгол улсын нийт орлого 6.6 их наяд төгрөг /3.5 тэрбум ам.доллар/ буюу нийт тооцоологдсон Дотоодын Нийт Бүтээгдэхүүн /ДНБ/-ий 27.6% байхаар тусгагдсан. Мөн тус оны нийт төсөвлөгдсөн зардал 7.8 их наяд төгрөг /4.2 тэрбум ам.доллар/ буюу нийт ДНБ-ий 32.7% байхаар тооцоологдсон. Үүнээс улсын төсвийн нийт алдагдал 1.2 их наяд төгрөг /0.9 тэрбум ам.доллар/ буюу ДНБ-ий 5.0% байхаар байна. Улсын төсвийн алдагдлын 1.05 их наяд төгрөгийг дотоодын эх үүсвэртэй санхүүжилтээр, үлдсэн 0.15 их наяд төгрөгийг гадаадын эх үүсвэрт санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

***Улсын төсвийн тэнцэл***

*Хүснэгт 3: Улсын төсвийн мэдээлэл 2009-2014*

| | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|
| Улсын төсвийн ашиг(алдагдал) / ДНБ (%) | -5.2 | 0.4 | -4.8 | -6.8 | -1.2 | -3.7 |
| Нийт өр төлбөр / ДНБ (%) | 51.1 | 35.5 | 32.7 | 52.9 | 61.9 | 69.9 |
| Бодит ДНБ өсөлт (%) | -1.3 | 6.4 | 17.3 | 12.3 | 11.6 | 7.8 |
| Нэрлэсэн ДНБ (их наяд, төгрөг) | 6,591 | 9,757 | 13,174 | 16,688 | 19,118 | 21,884 |
| Жилийн инфляци (%) | 4.2 | 13 | 10.2 | 14 | 12..5 | 11 |

Эх сурвалж: Үндэсний статискийн хороо

**Монгол улсын Орлого болон Зарлагын бүтэц**

Монгол улсын 2014 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 84.7%-ийг татварын орлогоор бүрдүүлсэн ба улсын төсвийн орлого ба тусламжийн өсөлт нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6%-аар өссөн. Уг өсөлт нь улсын шууд болон шууд бус татварын өсөлтөөс голчлон хамаарсан үзүүлэлт байсан байна. Мөн тухайн жилийн нийт зарлагад улсын төсөвт урсгал зардлын дүн 74.3%-аар хамгийн их дүнг эзэлж байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.8%-аар өссөн үзүүлэлт байсан.
Нийт урсгал зардалд хамгийн их дүнг буюу 52.5%-г улсын хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зардал эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 8.7% өссөн дүн юм.

МОНГОЛ УЛС

Нэгдсэн төсвийн хураангуй орлого, зардлыг харгалзах оноор авч үзвэл:

*Хүснэгт 4: Улсын төсвийн хураангуй 2009-2014*

| *(тэрбум, төгрөг)* | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|
| ***Улсын төсвийн орлого*** | | | | | | |
| Татварын орлого | 1,620.5 | 2,688.3 | 3,636.9 | 4,179.3 | 5,072.8 | 5,207.8 |
| Татварын бус орлого | 352.1 | 390.1 | 504.4 | 648.7 | 863.9 | 895.6 |
| Хөрөнгийн орлого | 2.3 | 5.7 | 16.8 | 10.4 | 3.4 | 1.7 |
| Тусламжийн орлого | 19.1 | 38.5 | 1.5 | 24.7 | - | 118.2 |
| Тогтворжуулалтын сан | - | - | 241.0 | 94.7 | 46.9 | 78.3 |
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,994.0 | 3,122.5 | 4,400.6 | 4,957.8 | 5,986.9 | 6,145.1 |
| ***Улсын төсвийн зардал*** | | | | | | |
| ***Урсгал зардал*** | | | | | | |
| Бараа үйлчилгээний зардал | 1,024.9 | 1,228.4 | 1,602.9 | 2,323.4 | 2523.5 | 2744.9 |
| Зээлийн үйлчилгээний төлбөр | 29.6 | 42.3 | 37.3 | 126.4 | 270.4 | 500.4 |
| Бусад урсгал зардал | 460.6 | 591.0 | 1,067.2 | 1,384.4 | 1,490.7 | 1,739.9 |
| ***Хөрөнгийн зардал*** | | | | | | |
| Дотоодын хөрөнгө оруулалт | 379.5 | 506.6 | 925.1 | 1,124.1 | 1,102.8 | 1,435.9 |
| Их засвар | 11.8 | 30.3 | 50.2 | 47.3 | 88.1 | 44..4 |
| Бусад зардал | 69.3 | 54.1 | 145 | 213.0 | 45.8 | 26.3 |
| ***Эргэж төлөгдөх цэвэр зээл*** | | | | | | |
| Цэвэр зээл | 87.9 | 233.4 | 490.5 | 69.4 | 121.3 | 64.9 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,336.6 | 3,080.7 | 4,792.0 | 6,043.9 | 6,149.7 | 7,031.4 |
| **Гүйцэтгэл** | (342.6) | 41.8 | (632.4) | (1,130.7) | (177.8) | (1,804.8) |

Эх сурвалж: Сангийн яам

**Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулдаг.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгодог.

- Нээлттэй тендер шалгаруулалтын журам
- Тендер шалгаруулалтын онцгой журам
- Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
- Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталдаг ба хяналтыг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аливаа зөрчлийн талаарх гомдлыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газар болон Шүүх дээд байгууллага маргааныг тасална.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

**Эрчим хүчний салбарт төсвөөс хийгдэх хөрөнгө оруулалт**

Эрчим хүчний салбарт төрөөс бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх дунд хугацааны эрчим хүчний үндэсний хөтөлбөрт тусгагдах төсөл, арга хэмжээ нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан мега төслүүд, дунд хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан орон нутгийн чанартай эх үүсвэр, түгээх шугам сүлжээ, ашиглалтад буй дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлтийн төслүүд, бага хэмжээний хөрөнгө оруулалтын шаардсан судалгаа тооцоо, гэрээ хэлэлцээр, сургалт сурталчилгаа зэрэг зохион байгуулалтын төсөл арга хэмжээ багтаж байна.

Их хэмжээний хөрөнгө оруулалт, том бүтээн байгуулалтын мега төслүүдээс төрийн оролцоо, үүрэгтэй төслүүдийг концессын тухай хууль, урт хугацааны хөнгөлөлтэй зээлийн бодлогоор хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эрчим хүчний салбарт 2030 он гэхэд 10.26 тэрбум ам.доллар хөрөнгө оруулалт шаардагдах урьдчилсан тооцоо гарч байгаа бөгөөд үүнд (i) Төвийн эрчим хүчний системд нэмэгдэх цахилгаан, дулаан хосолсон үйлдвэрлэлийн чадал 4.0 тэрбум ам.доллар, (ii) Улаанбаатарын дулаан хангамжийн хүчин чадлын өргөтгөлд 0.35 тэрбум ам.доллар, (iii) Өмнөд говийн бүсийн шинэ эх үүсвэр 2.0 тэрбум ам.доллар, (iv) бусад эрчим хүчний системүүдэд 0.75 тэрбум ам.доллар, (v) Аймгийн төвийн дулааны үйлдвэрлэлийн чадлыг нэмэх, засаж сайжруулах 0.26 тэрбум ам.доллар, (vi) дамжуулах сүлжээний өргөтгөл шинэчлэлд 1.7 тэрбум ам.доллар, (viii) түгээх сүлжээний өргөтгөл шинэчлэлд 1.1 тэрбум ам.доллар болж байна.

*Зураг 5: Урт хугацаанд эрчим хүчний салбарт төсвөөс хийх хөрөнгө оруулалтын зарцуулалт*




Эх сурвалж: Эрчим хүчний яам

Дараах хүснэгтэд эрчим хүчний салбарт ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон эх үүсвэр, дамжуулах шугамын төслүүдийн шаардагдах хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн урьдчилсан тооцоог харуулав.

Зураг 6: Эрчим хүчний салбарт ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон эх үүсвэр, дамжуулах шугамын төслүүд

| Хугацаа | Эх үүсвэр | СХЧадал, МВт | Хөрөнгө оруулалт, сая $ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Концесс | Зээл | IPP |
| Ойрын хугацаанд | Улаанбаатар ДЦС 5 төсөл | 450 | 1190 | | |
| | Тавантолгой ДЦС | 450 | | | 1000 |
| | ДЦС3 өргөтгөл | 250 | | 350 | |
| | ЭГ УЦС | 320 | | 800 | |
| | Багануур ДЦС | 700 | 1200 | | |
| | Дорнодын ДЦС өргөтгөл | 100 | 180 | | |
| | Баруун бүсийн ЦС | 100 | | 180 | |
| | Нийт эх үүсвэр | 2270 | 2'570 | 1'150 | 1'000 |
| | | | 4'720 сая $ | | |
| | **Дамжуулах шугам, дэд станц** | **Урт, км** | **Концесс** | **Зээл** | **Хувь** |
| | Чойр 220 кВ дэд станц өргөтгөл | | 20 | | |
| | ДЦС5- ТЭХС холбох 220 кВ 2 хэлхээ | 85 | | 19 | |
| | ЭГ УЦС -ТЭХС холбох 220 кВ 2 хэлхээ | 72 | | 23 | |
| | Багануур-Өндөрхаан-Чойбалсан 220 кВ | 518 | 153 | | |
| | Багануур ДЦС -Улаанбаатар 500 кВ | 157 | 113 | | |
| | Багануур ДЦС -Чойр-г 500 кВ | 190 | 120 | | |
| | Оюутолгой-Цагаансуврага 220 кВ 2 хэлхээ | 160 | 54 | | |
| | Нийт шугам | 1182 | 460 | 42 | 0 |
| | | | 502 сая $ | | |
| | **Нийт ойрын хугацаанд** | | **3'030** | **1'192** | **1'000** |
| | | | **5'222 сая $** | | |
| | **Эх үүсвэр** | **СХЧадал, МВт** | **Концесс** | **Зээл** | **IPP** |
| Дунд хугацаанд | Тэлмэн ДЦС | 100 | 180 | | |
| | Эрдэнэт ДЦС өргөтгөл | 30 | | 45 | |
| | Улаанбаатар Усан цэнэгт станц | 100 | 120 | | |
| | Нар | 100 | | | 200 |
| | Салхи | 100 | | | 300 |
| | Цайдам нуур/Бөөрөлжүүт/ Чандгана/ Тэвшийн говь/ Эрдэнэцогт ДЦС | 600 | 1100 | | |
| | Нийт эх үүсвэр | 1030 | 1'400 | 45 | 500 |
| | | | **1'945 сая $** | | |
| | **Дамжуулах шугам** | **Урт, км** | **Концесс** | **Зээл** | **Хувь** |
| | Чойр-Сайншанд-Замын Үүд 220 кВ | 406 | 124 | | |
| | Улаанбаатар-Мандалговь 330 кВ | 260 | 97 | | |
| | Нийт шугам | 666 | 221 | 0 | 0 |
| | | | 221 сая $ | | |
| | **Нийт дунд хугацаанд** | | **1'621** | **45** | **500** |
| | | | **2'166 сая $** | | |
| | **НИЙТ** | | **4'651** | **1'237** | **1'500** |
| | | | **7'388 сая $** | | |

Эх сурвалж: Эрчим хүчний яам

## 1.6. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт

“Эрчим Инженеринг” ХХК нь Монгол улсын компанийн тухай хуулийн дагуу байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж буй хуулийн этгээд юм. Тус компани нь Ерөнхий захирал болох М.Батболдын 100% хөрөнгө оруулалттай, нэг хүний өмчлөлтэй компани бөгөөд компанийн эрх барих дээд удирдлага нь компанийн Ерөнхий захирал юм.

### Компанийн бүтэц зохион байгуулалт

*Зураг 7: Компанийн бүтэц*




2015 оны 6 дугаар сарын байдлаар нийт 73 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

## 1.7. Үнэт цаас гаргагчийн удирдах албан тушаалтнуудын мэдээлэл

**Байгууллагын нэр: Эрчим Инженеринг ХХК**

| **Албан тушаал:** | Ерөнхий захирал |
|---|---|
| **Овог нэр** | М.Батболд |
| **Мэргэжил** | Цахилгааны инженер |
| **Төрсөн огноо** | 1959.04.13 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | 1978-1983 онд Словякийн техникийн дээд сургууль - Өндөр хүчдэл шугамын тоног төхөөрөмжийн инженер<br>1991-1992 онд Монгол Улсын Их сургууль - Англи хэлний орчуулагч<br>1998-2001 онд Санхүү эдийн засгийн дээд сургууль – Нягтлан бодогч, бизнесийн удирдлага<br>2006 онд ШУТИС - Шугам сүлжээний зөвлөх инженер буюу - Монгол улсын зөвлөх инженер цол хүртсэн. |
| **Хэлний мэдлэг** | Англи хэл<br>Орос хэл<br>Словяк хэл |
| **Ажилласан туршлага:** | 1999 оноос одоог хүртэл Эрчим инженеринг ХХК-ны ерөнхий захирал<br>1994-2003 онд Монгол-Энерго Сервис ХХК–д захирал<br>1984-1994 онд 4-р цахилгаан станцад инженер<br>Нийт ажилласан 29 жилийн 10 жилийг Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцад өндөр хүчдэлийн туршилт тохируулгын лабораторийн эрхлэгч, Реле хамгаалалт автоматикийн инженер, Телемеханикийн инженер зэрэг албан тушаалуудад ажиллаж туршлагажсан.Үлдсэн 19 жилд дамжуулах болон түгээх сүлжээний чиглэлээр ажиллаж 0.4-220кВ-н шугам сүлжээ, дэд өртөөний зураг төсөл, барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байсан арвин туршлагатай, Монгол Улсын Зөвлөх Инженер юм. |

| **Албан тушаал:** | Гүйцэтгэх захирал |
|---|---|
| **Овог нэр** | Н.Баярмагнай |
| **Мэргэжил** | Инженер орчуулагч, Ня-Бо |
| **Төрсөн огноо** | 1979.10.16 |

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

СЭХ БҮРТГЭВ № 31

| | |
|---|---|
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | 1997 -2001 онд ШУТИС Инженер орчуулагч<br>2005-2008 онд СЭЗДС Эдийн засагч, Санхүүч |
| **Хэлний мэдлэг** | Англи хэл<br>Орос хэл |
| **Ажилласан туршлага:** | 2001 оноос одоог хүртэл Эрчим инженеринг ХХК-ийн гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.<br>Нийт ажилласан 11 жилийн хугацаанд дамжуулах сүлжээ, түгээх сүлжээ, дулааны шугам сүлжээний чиглэлээр зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, барилга угсралтын төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан. |

| **Албан тушаал:** | **Төслийн удирдагч** |
|---|---|
| **Овог нэр** | Ц.Ширмэнбаатар |
| **Мэргэжил** | Цахилгааны инженер |
| **Төрсөн огноо** | 1981.08.07 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | 1998-2003 онд ШУТИС Цахилгааны инженер бакалавр<br>2003-2005 онд ШУТИС Цахилгааны инженер магистр |
| **Хэлний мэдлэг** | Англи хэл<br>Орос хэл |
| **Ажилласан туршлага:** | 2003-2005 Дулааны цахилгаан станц-4 цахилгааны инженер<br>2005-2015 Эрчим-Инженеринг ХХК –д цахилгааны инженер, төслийн удирдагч<br>Нийт ажилласан 12 жилийн 2 жилийг Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцад реле хамгаалалт автоматикийн инженер албан тушаалд ажиллаж дадлагажсан.<br>Үлдсэн 10 жилд дамжуулах болон түгээх сүлжээний чиглэлээр ажиллаж 0.4-220кВ-н шугам сүлжээ, дэд өртөөний зураг төсөл, барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байсан. |

| **Албан тушаал:** | **Ерөнхий инженер** |
|---|---|
| **Овог нэр** | С.Пүрэвдагва |
| **Мэргэжил** | Цахилгааны инженер |

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | |
|---|---|
| **Төрсөн огноо** | 1962.02.04 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | 1980-1983 онд Дархан хотын политехником – дипломын цахилгааны инженер<br>1994-1996 онд Дархан хотын политехником – Цахилгааны инженер бакалавр |
| **Хэлний мэдлэг** | Англи хэл |
| **Ажилласан туршлага:** | 1983-1996 Дулаан цахилгааны станц-4 цахилгааны инженер<br>1996-2000 Монхорус интернейшнл ХХК цахилгааны инженер<br>2000-2015 Эрчим Инженеринг ХХК цахилгааны инженер, ерөнхий инженер<br><br>Нийт ажилласан 35 жилийн 13 жилийг Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцад реле хамгаалалт автоматикийн инженер албан тушаалд ажиллаж дадлагажсан.<br>Үлдсэн 22 жилд дамжуулах болон түгээх сүлжээний чиглэлээр ажиллаж 0.4-220кВ-н шугам сүлжээ, дэд өртөөний зураг төсөл, барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байсан. |

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

СЗХ
Он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 1.8. Ажилтан, албан хаагчдын мэдээлэл

“Эрчим-Инженеринг” ХХК нь 2014 онд 67, 2015 онд үндсэн 73 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс инженер техникийн ажилчид тоо 16, санхүү бүргэлийн ажилтан 5, гүйцэтгэх удирдлага 2, мэргэжлийн ажилчид 50 байна.

*Зураг 8: Компанийн хүний нөөц*

| Мэргэжил | | Тоо | Ажилласан дундаж | Мэргэжлийн зэрэг |
|---|---|---|---|---|
| Удирдах албан хаагчид | Удирдах боловсон хүчин | 2 | 20 | Дээд |
| | Санхүү | 5 | 10 | Дээд |
| | Цахилгааны инженер | 3 | 15 | Дээд |
| Инженер техникийн ажилтан | Реле хамгаалалтын инженер | 2 | 4 | Дээд |
| | Барилгын хийцийн инженер | 1 | 4 | Дээд |
| | Геодезийн инженер | 2 | 8 | Дээд |
| | Маркшейдэр инженер | 1 | 4 | Дээд |
| | Программ хангамжын инженер | 1 | 4 | Дээд |
| | Холбооны инженер | 1 | 12 | Дээд |
| | Дулааны инженер | 2 | 35 | Дээд |
| | Сантехникийн инженер | 2 | 20 | Дээд |
| | КИП автомикийн инженер | 1 | 4 | Дээд |
| Үүнээс: | Металлын инженер | 1 | | |
| | Зөвлөх инженер | 3 | | |
| | Мэргэшсэн инженер | | | |
| | Тэргүүлэх төсөвчин | | | |
| | Мэргэшсэн төсөвчин | 1 | | |
| Мэргэжлийн ажилчид | Цахилгаанчин | 23 | 7 | IV |
| | Гагнуурчин | 4 | 15 | V |
| | Автокранчин | 2 | 4 | IV |
| | Экскаваторчин | 2 | 5 | III, II |
| | Жолооч | 1 | 4 | |
| | Дохиочин-оосорлгч | 3 | 3 | |
| | Тоног төхөөрөмжийн засварчин | 8 | 10 | IV |
| | Сантехникийн засварчин | 7 | 9 | IV |

Нийт ажиллагсдын 85 хувь нь эрэгтэй, 15 хувь нь эмэгтэй байна. Насны бүлгээр авч үзвэл 45 хувь 34 нас хүртэлх залуучууд, 28 хувь нь 34-45 настай, үлдсэн 27 хувь нь 45-аас дээш насны ахмад туршлагатай ажилчид ажиллаж байна.

Эдгээр ажилчдын 29 хувь нь бакалавр болон түүнээс дээш боловсролтой, 65 хувь нь техник технологийн тусгай мэргэжлийн зэрэгтэй, үлдсэн 4 хувь нь дунд боловсролтой ажилтнууд байна.

## 1.9. Гэрээ хэлцэл, тендер

“Эрчим-Инженеринг” ХХК нь 2015 оны 6 дугаар сарын байдлаар дараах тендерт оролцож байгаа бөгөөд эдгээр тендерүүд нь сонгон шалгаруулалтын шатандаа явж байна.

- Дулааны 4 дүгээр цахилгаан станцаас зарласан 125МВА/110/10кв-ийн 2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй трансформатор нийлүүлэх тендер
- Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн 40МВА/35/110кв-ийн 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй трансформатор нийлүүлэх
- Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй SCADA тендер
- Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан 6,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 35/6кВ-н 2х16МВА чадал бүхий дэд өртөөний барилга угсралт
- ТОСК, ТӨҮГ-с зарласан Буянт Ухаа 2 хорооллын гадна цахилгаан хангамжийн 8 ширхэг ХТП, кабел шугам, РП барих барилга угсралтын ажил
- Зам тээврийн яамнаас зарласан Замын Үүдийн Ложистикийн Төвийн 110/10кВ-н дэд өртөө, 110кВ-н ЦДАШ
- Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн технологийн парк ОНӨААТҮГ-с зарласан гадна цахилгаан хангамжийн 10/0,4кВ ХТП болон 10кВ-н ЦДАШ-н барилга угсралтын ажил

БНХАУ-н засгийн газрын 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 2015 оны 6 дугаар сарын байдлаар "Эрчим Инженеринг" ХХК нь УБ ХОТЫН УБ-220/110/35кВ-н дэд өртөөний өргөтгөл, 7-р Хороолол, МҮОНРТ-ийн 110/35/10 кВ-ЫН дэд өртөө, 110кВ-н ЦДАШ, Хороолол дунд орших 10кВ-н гадна цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил дээр Бээжин Констракшн Инженеринг Групп ХХК-ийн дам туслан гүйцэтгэгчээр ажиллаж байна.

БНХАУ-ийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс санхүүжигдэж буй дэд бүтцийн бүтээн байгуулалтын 47 сая ам.долларын төсөвтэй Улаанбаатар хотын 7 дугаар хороолол, Монголын үндэсний радио телевизийн орчмын хорооллын шугам сүлжээний угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Бээжин констракшн инженеринг групп ХХК нь шалгарсан. 2010 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр БЗА-2010/55-ИШ дугаартай гэрээг ЗАМ ТЭЭВЭР, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ гарын үсэг зурж баталгаажуулсан.

Бээжин Констракшн Инженеринг Групп нь 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр туслан гүйцэтгэгчээр "Инженерийн шугам сүлжээний барилга угсралт" ХХК ("ENCC")-г сонгож БЗА-2010/55/ШИ дугаартай гэрээний нөхцөлийг үндэслэн нийт 38,4 сая ам.долларын төсөвтэй ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулсан ба "Эрчим Инженеринг" ХХК нь энэхүү ажлын 28,609,946.15 ам.долларын өртөг бүхий ажлыг 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан, дугаар БЗА-2010/55-ИШС/ТГ-05 гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байна. /Гэрээний сунгалтыг 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, дугаар БЗА-2010/55-ИШС/ТГ-05 Нэм-1 гэрээгээр баталгаажуулан батлуулсан./

2015 оны 6 дугаар сарын байдлаар уг дэд станцын барилга угсралтын ажил 90 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. "Эрчим Инженеринг" ХХК нь ажлын гүйцэтгэлд одоогоор 20 сая ам.долларын төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгээд байна. 2015 оны 8 дугаар сарын 2-ны дэд станцын өргөтгөлийн ажлыг хариуцсан яам, агентлагт хүлээлгэн өгөх үүрэгтэй.

Уг төслийн санхүүжилтийн 80 хувь хийгдэж барилга угсралтын ажил 90-95 хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн ажлыг 2015 оны 08 сарын 01-нд дуусгаж төслийн үлдэгдэл санхүүжилтийг авах төлөвлөгөөтэй. Гэрээг хавсралт 3.3-аас харна уу.

## 1.10. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандарт

**Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандарт**

“Эрчим-Инженеринг” ХХК нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн ахуйн хөтөлбөр”-ийг 2012 онд батлан одоог хүртэл дагаж мөрдөн ажиллаж байна. “Эрчим-Инженеринг” ХХК нь анх байгуулагдсан цагаас одоог хүртэл ямар нэг осол эндэгдэл гаргалгүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг чанд мөрдөн ажиллаж байна.

Уг хөтөлбөр нь Монгол Улсын Хөдөлмөрийн Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны тухай хуулийн заалт болон “Эрчим Инженеринг” ХХК-н Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Байгаль орчны бодлогын дагуу ЦДАШ, барилга угсралтын ажилд зориулагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) төлөвлөгөөг ажлын бүхий л талбар дээр дагаж мөрдөх хөтөлбөр боловсруулагдсан.

Мөн “Эрчим-Инженеринг” ХХК-ийн бүх давхар гэрээлэгчид ХАБЭА-н төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

ХАБЭА-н хөтөлбөрт ЦДАШ, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх үйл ажиллагаанд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны хөтөлбөр болон аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам шаардлагуудыг тодорхойлсон.

ХАБЭА-ы төлөвлөгөөний гол зорилго нь барилга угсралтын ажлын талбар дахь эд хөрөнгийн эвдрэл, гэмтэл болон ажилчдыг аюулд учруулж болох бүхий л аюулаас урьдчилан сэргийлэх, чиглүүлэх юм.

**ХАБЭА төлөвлөгөөний сургалт, зааварчилгаа**

Компани нь ажлыг эхлүүлэхээс өмнө бүх ажилчдад ХАБЭА-н төлөвлөгөөний дагуу ажлын талбарт хэрхэн аюулгүй ажиллах дүрэм журмыг уншиж, танилцуулдаг. Байгууллагын ХАБЭА-н мэргэжилтэн аюулгүй ажиллагааны тухай зааварчилгааг өгч, сургалтын талаар тэмдэглэл хөтөлдөг. Байгууллагын ХАБЭА-н хэлтсээс өгч байгаа Аюулгүй ажиллагааны дүрэм журмууд болон Ажлын талбарын зарчмын талаар сургалт зааварчилгаанд бүх ажилчид хамрагддаг. Заавран барилга угсралтын ажлын бүхий л явцад дагаж мөрдөх ёстой байдаг. Ажлын талбайд дараах чиглэлээр заавар чиглэл өгдөг. Үүнд:

- Ажлын талбарын зохион байгуулалт, бүтэц
- Эрх үүргүүд
- Түргэн тусламжийн арга хэмжээ: Анхны тусламж болон аюулгүй ажиллагаа
- Эрүүл мэнд, нийгмийн халамжууд
- Ажлын талбарын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны дүрэм, журам
- Ажлын талбай руу орж гарах автомашин болон ажилчдад зориулсан гарцууд

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

- Ажлын зөвшөөрлүүд
- Осол аваарын тайлан
- Мэдээллэх хуудас /Эрсдэлийн үнэлгээ (ахлагч нарт).
- Эрүүл мэндэд аюултай хортой бодисыг хянах (COSHH)
- Хувийн хамгаалах хэрэгсэл
- Гэрээ/Захиалагчийн шаардлагууд
- Түргэн тусламжийн дуудлага (ахлагч нарт)

**Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартын удирдлага**

Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг хангахын тулд дараах албан тушаалтай ажилчид ажлын талбайд доорх үүрэгтэйгээр ажилладагв

*Хүснэгт 5: ХАБЭМС-ийн үүрэг хариуцлагын хүснэгт*

| | Хариуцагч | Томилогдсон үүрэг даалгавар |
|---|---|---|
| 1 | ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР | Ерөнхий менежер нь удиртгалд тусгагдсан бүхий л үүрэг хариуцлагуудыг анхааралтай хянаж, удирдах ёстой ба дараах ажлуудыг гүйцэтгэнэ:<br>1. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг томилох<br>2. Шуурхай хурал дээр үргэлж Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тухай авч хэлэлцэх ба тодорхой тогтоосон удирдлагын менежментийн үүрэг хариуцлагуудыг болон тайланг батлах.<br>3. Шаардлагатай тохиолдолд Аюулгүй ажиллагааны удирдах зөвлөлийн хуралд оролцох<br>4. ХАБЭА-н албыг дэмжих, чадварлаг бэлтгэгдсэн ажилтан бэлтгэж ажлын гүйцэтгэлийг үр дүнтэй байлгах боломжтой аргуудыг бий болгох<br>5. Аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн сар тутмын тайланг шаардах<br>6в Аюулгүй ажиллагаа хангах шаардлагатай ажлын талбайд очиж танилцах, өнөөгийн аюулгүй ажиллагааны дүрэм журам, шинэчлэлтүүдийн зарчмуудыг судлах, ХАБЭА-н шаардлагыг хангасан орчинд ажилчид ажиллаж байгаа эсэхийг хянах. |
| 2 | БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН АХЛАХ МЕНЕЖЕР | Барилга угсралтын ажлын менежерүүдийн хийх ёстой ажил үүргүүд:<br>1. Ажил хийгдэж буй тусгайлсан газрууд /хэсгүүд дэх эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг дээшлүүлэх<br>2. Техникийн гарын авлага, тусгайлсан Үйл ажиллагааны дүрэм, Эрүүл мэнд аюулгүй ажиллагааны дүрэм журамтай холбоотой шаардлагууд болон бусад хэрэгцээтэй баримт бичгүүдтэй танилцсан байх<br>3. Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэхийг шалгах<br>4. Барилга угсралтын ажлын шалгаруулалт, төлөвлөлтийн үеэр техникийн бүрэн засвар үйлчилгээ, тусгай зөвшөөрлийг чанарын шаардлага хангасан техник хэрэгслүүд, ажлын аюулгүйн системүүд болон аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжид өгч байгаад хяналт тавих<br>5. Боловсон хүчний албанаас тодорхойлсон өөрсдийн ажилтнаа сургалтанд суулгаж шаардлагатай тохиолдолд ажилтанг хичээлээс чөлөөлж болно<br>6. Аюулгүй ажиллагааг дэмжих шаардлагын дагуу ХАБЭА-ы албатай харилцан холбоотой ажиллах<br>7. Энэхүү аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг давхар гэрээлэгчдэд мөн адил хэрэгжүүлэх |

ЭРДМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

| | | |
|---|---|---|
| | | 8. Тухайн хэсгүүдэд ажиллах давхар гэрээлэгчдийн удирдлагуудтай хийх уулзалтыг зохион байгуулах<br>9. Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнүүд болон бүх байгаа өгөгдлүүдийг ашигладаг үнэлэлтүүд хийгдсэн эсэхийг шалгах, тэдгээр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, мэдээллэх хуудаснуудыг боловсруулж нэвтрүүлсэн байх<br>10. Аль ч аюулгүй ажиллагааны байдлыг нягтлан үзэх, талбай дээрх давхар гэрээлэгчдээс ирсэн аюулгүй ажиллагааны менежментийг батлах<br>11. Ажлын төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, холбоотой дүрэм журмын хэрэгжилт хийгдэж буйг хянах, мэргэжлийн ур чадварын өндөр түвшинд ажиллах, ажлын байрны цэвэр цэмцгэр байдал болон аюулгүй ажиллагааны гарц зэрэгт байнга анхаарч ажиллах<br>12. Ажлын хүрээнд хариуцаж буй хэсгүүд дэх аюулгүй ажиллагааны хяналт шалгалтыг сар бүр хөтөлж явах<br>13. Ажилчдын дунд аюулгүй ажиллагаа хуулийн шаардлагын дагуу хэрэгжиж байгаад хяналт тавих<br>14. Аюулгүй ажиллагааны албатай холбоотой бүхий л аюултай үзэгдэл, эвдрэл гэмтлүүдийн шинжлэл болон дахин давтахаас сэргийлэх засах арга хэмжээг авах, энэ тухай мэдээллийг шаардан авах<br>15в Шаардлагатай үед аюулгүй ажиллагааны хуралд оролцох. |
| 3 | ТЕХНИКИЙН МЕНЕЖЕР | Техникийн менежерүүд дараах ажил үүргийг гүйцэтгэх ёстой.<br>1. Ажил хийгдэж буй тусгайлсан газрууд /хэсгүүд дэх эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг дээшлүүлэх<br>2. Техникийн гарын авлага, тусгайлсан Үйл ажиллагааны дүрэм, Эрүүл мэнд аюулгүй ажиллагааны дүрэм журамтай холбоотой шаардлагууд болон бусад хэрэгцээтэй баримт бичгүүдтэй танилцсан байх<br>3. Аюулгүй ажиллагааг дэмжих шаардлагын дагуу ХАБЭА-н албатай харилцан холбоотой ажиллах<br>4. Өөрсдийн мэдээллэх хуудастай эрсдэлийн үнэлгээг бэлтгэх. Түүнчлэн барилга угсралтын багтай адил ХАБЭА-н албатай нягт харилцаатай ажиллах<br>5. Тухайн ХАБЭА-н зөвлөхөд өгөхөөс өмнө эрсдлийн үнэлгээ болон мэдээллийн хуудсыг ХАБЭА-н албанд хугацаанд нь танилцуулах.<br>6. Шаардлагатай үед эрсдэлийн үнэлгээний хурлыг зохион байгуулах.<br>7в Ялангуяа ХАБЭА-н албанд үйл ажиллагааны бэлтгэл ажилд нэмэр болохуйц мэдээллийг цуглуулахын тулд техникийн оффис менежер “3 сарын өмнөөс тандах” гэсэн хөтөлбөрийг боловсруулан ХАБЭА-н албыг мэдээллээр хангах, шинэчлэх үүрэгтэй. |

**Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлын систем нь дараах бүрдэл хэсгээс бүрддэг.**

1. **Талбайн хяналт:** Ажлын талбайд зөвхөн тухайн талбайд ажиллах чадвартай мэргэжлийн ажилтнууд нэвтрэн орох эрхтэй байдаг. Менежментийн талбайгаас зөвшөөрөл авсан хүмүүс ажлын талбай руу нэвтэрч байгаа эсэхийг орох, гарах гарц дээр зогсож байгаа хамгаалагч нар шалган ажлын талбайд оруулдаг. Ажилчдаас бусад хүмүүс удирдлагын хэсэгт мэдэгдсэн байх ёстой.

2. **Кран ба өргөх тоног төхөөрөмжтэй харьцах:** Өргөх ажил хийгдэж байх үед талбай дээр краны орчим ямар ч ажилчин байх ёсгүй. Өргөх үйл ажиллагааны үед краны доор хүн байхаас өөр аргагүй тохиолдолд тухайн ажилчны аюулгүй байдлыг хангахын тулд тохиромжтой, үр дүн бүхий хяналт тавьж ажилладаг. Өргөх үйл ажиллагаа явуулах бүсийг тодоор заасан тэмдэглэгээ байх ёстой бөгөөд тухайн бүсэд зөвхөн тусгай оператор нэвтрэхийг зөвшөөрдөг. Краны оператор нь байнга нүдэнд сайн өртөхүйц тод өнгийн, гэрэл ойлгогчтой хувцас өмсдөг. Краны оператор нь өргөх үйлдэл хийхдээ зөвхөн дохиочны зааврын дагуу ажил үүргээ гүйцэтгэдэг.

   Кран болон бусад өргөх тоног төхөөрөмжүүд нь хяналт шалгалтаар орж баталгаажсан байна. Краныг ашиглахаас өмнө мэргэжлийн хүн шалгалт үзлэг хийдэг ба Тухайн ажилд ашиглах бүх өргөх төхөөрөмжүүд нь (кран, дохиочин болон утас буюу трос) шаардлагатай хууль ёсны зөвшөөрөлтэй байдаг. Хэрэглэхээс өмнө тэдгээр ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК ХАБЭА ХӨТӨЛБӨР 20 / 40 зөвшөөрлүүдийг ХАБЭА-н төлөөлөгчөөр хянуулдаг. Ажлын талбай дээр өргөх тоног төхөөрөмжийн үнэмлэхний төвлөрсөн бүртгэл байх ёстой бөгөөд уг бүртгэл нь тухайн удирдлагын салбар нэгж бүрийн ахлагч нарт байдаг. Бүртгэлийн нэг хувь нь ХАБЭА-н хэлтэст хадгалагдаж байна. Бүх багаж, тоног төхөөрөмжүүд ажил эхлэхэд бэлэн байдалд байх байдлаар зохицуулдаг. ХАБЭА-н хэлтсээс бүх багаж тоног төхөөрөмжийг тогтмол хугацаанд шалгадаг ба хүнд тоног төхөөрөмжүүдийг ажил эхлэхээс өмнө өдөр тутам шалгаж байна. Нарийн үзлэг шалгалтыг долоо хоног тутам хийж баримтжуулдаг.

3. **Үзлэг шалгалт:** Байгууллагын үндсэн шаардлагын дагуу бүх тоног төхөөрөмжүүд гурван сар /улирал тутам техникийн үзлэгээр ордог. Бүх өргөх тоног төхөөрөмж бүртгэгдсэн байдаг. Бүх хавчаар, роллик нь тодорхой шошготой байх ба трос, гинж, дэгээ болон хориг дээр даацын хязгаарын тэмдэглэгээ хийгдсэн байдаг. Бүх өргөх тоног төхөөрөмжүүд нь хэрэглэгдэхийн өмнө өдөр бүр шалгагдаг. Мэргэжлийн эрх бүхий хүн тухайн өргөх тоног төхөөрөмжийг засагдах боломжгүйгээр эвдэрч, гэмтсэн хэмээн дүгнэсэн бол өргөх тоног төхөөрөмжийг хэсэгчлэн задалж эвдрэлтэй хэсгийг ашиглалтаас гаргах бөгөөд энэ үйл ажиллагааг техник ашиглалтын дэвтэр дээр тэмдэглэдэг.

4. **Ажилчдын хамгаалалтын хувцас**

Компани нь ажилчдаа дараах төрлийн хамгаалалтын хувцсаар хангадаг.

*Хүснэгт 6: Хөдөлмөр, хамгааллын хэрэгсэл*

| Хамгаалалтын төрөл | Зориулалт, ашиглалт |
|---|---|
| Толгойн хамгаалалт | Аюулгүйн малгай буюу хамгаалалтын малгай (каск) нь олон төрөл болон загвараар хатуу, бат бөх материалаар хийгдсэн цохилт, дээрээс ямар нэгэн биет унах эсвэл ямар нэг биет үсчих, цахилгаанд цохиулах болон эдгээртэй холбоотой бэртэл гэмтлээс сэргийлэх зориулалт бүхий тоноглогдсон малгай |
| Нүд, нүүрний хамгаалалт | Дотор эсвэл задгай барилга угсралтын талбайд ажиллаж |

| | |
|---|---|
| | байх үед ашигладаг үйлдвэрлэлийн хэрэглэлийн хамгаалалтын нүдний шил (хамгаалалтын бүрхүүлтэй) |
| Гарын хамгаалалт | Ямар материалтай ямар багаж хэрэгсэл ашиглан ажиллаж байгаагаас хамааран хэрэглэх бээлийний төрлийг сонгодог. Хавчуулагдаж, гараа бэртээхээс сэргийлэх үүднээс эргэдэг машин механизмын ойролцоо бээлий хэрэглэхийг хориглоно. Ихэнх барилгын ажлын үеэр тохиромжтой бээлийг ажилчдад ханган нийлүүлдэг. |
| Хөлийн хамгаалалт | Хамгаалалтын гутал нь хөлийн үзүүрийг гэмтэхээс хамгаалсан төмөр хоншоортой байдаг. Гутлын хоншоор нь даралт болон цохилтын үед ачаа даах чадвартай байх. Барилгын ажлын хамгаалалтын гутал нь 1100 кг-ын даралт, 33кг-ын цохилтод тэсвэртэй байдаг |
| Хамгаалалтын бүс | Газрын түвшнөөс/ гадаргуугаас 1.8 метрээс дээш өндөрт ажиллах үед давхар татлагатай аюулгүйн хамгаалалтын бүсийг заавал зүүдэг. Хамгаалалтын татлага хамгийн багадаа 14 мм-ийн нийлэг эд, эсвэл түүнтэй төстэй материалаар хийгдсэн байх ёстой бөгөөд уналтын зайг сайтар тооцоолсон урттай байдаг. Хамгаалалтын татлага нь зөөллөвч буюу амаржинтай байна. |
| Амьсгалын хамгаалалт | Тоосжилт ихтэй орчинд агааржуулагч, сэнс, агаарын солилцоо, тоосны маскийг ашигладаг. Тоосны маск, агаар шүүгчтэй маск болон респираторыг таарч байгаа эсэхийг, мөн хэрэглэж байгаа ажилчин бүрэн зөв ашиглаж чадаж байгаа эсэхийг шалгадаг |

**Ажлын байрны эрүүл ахуй болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө**: Ажил эхлэхээс өмнө гэрээ хийсэн тал нарийвчилсан ажлын байрны эрүүл ахуй болон аюулгүй ажиллагааны журмын дагуу бэлдэнэ.

**ХАБЭА-н хяналт шалгалт:** Аюулгүй ажиллагааны ажилтан нь өдөр тутам ажлын талбайн хяналт шалгалтуудыг хийдэг. Аюулгүй ажиллагааны ажилтан нь ажлын талбайн хянагчтай хамтран өөрсдийх нь хариуцсан талбайд долоо хоногт доод тал нь нэг удаа ХАБЭА-н хяналт шалгалтыг явуулдаг. Ерөнхий менежер ажил явагдаж буй талбайд сард доод тал нь нэг удаа очиж аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтыг хийдэг. Хяналт шалгалтаар байгууллагын тухайн талбайн ажлын багт хамаардаггүй нэгнийг хамт дагуулж явдаг.

## 1.11. Чанарын хяналт

“Эрчим Инженеринг” ХХК нь Монгол улсын Эрчим хүчний яамны “Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын норм ба дүрэм УНбД. 3.05.06-85”-ийн дагуу цахилгаан техникийн байгууламжийн угсралтыг гүйцэтгэдэг. Эрчим Инженеринг ХХК нь тендер, төслийн ажлыг уг стандартын дагуу гүйцэтгэдэг.

## 1.12. Компанийн санхүүгийн мэдээлэл

Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг Хавсралт 3.4-өөс дэлгэрүүлж харна уу.

*Хүснэгт 7: Сүүлийн 3 жилийн компанийн баланс*

**Баланс**

| Хөрөнгө | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 489,388,887 | 1,148,822,411 | 60,750,092 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 0 | 0 | |
| Үнэлгээний хасагдуулга | 0 | 0 | |
| Дансны авлага | 152,771,282 | 809,707,274 | 828,454,155 |
| Татвар, НДШ-ийн авлага | 0 | 8,961,558 | 10,586,568 |
| Бусад авлага | 17,057,634 | 3,429,642 | 3,429,642 |
| Бараа материал | 31,596,453 | 1,008,707,399 | **2,467,951,156** |
| Мал амьтад | 0 | 0 | 0 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 1,370,020,793 | 5,514,010,102 | 1,755,524,186 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **2,060,835,049** | **8,493,638,384** | **5,126,695,799** |
| Үндсэн хөрөнгө | 1,318,708,263 | 1,287,273,479 | 1,168,344,913 |
| ҮХ Хуримтлагдсан элэгдэл | -165,840,554 | 0 | 0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 47,055,200 | 0 | 0 |
| БҮХ Хуримтлагдсан элэгдэл | -4,871,975 | 0 | 0 |
| Дуусаагүй барилга | 0 | 0 | 0 |
| Мал амьтад (ХАА-н үйлдвэрлэлийн) | 0 | 0 | 0 |
| **Биет бус хөрөнгө** | 18,734,266 | 37,839,500 | 45,049,965 |
| ББХ Хуримтлагдсаи элэгдэл | -6,059,715 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | 2,500,000 | 7,500,000 | 7,500,000 |
| Үнэлгээний хасагдуулга | 0 | 0 | 0 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,210,225,483** | **1,332,612,979** | **1,220,894,878** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **3,271,060,533** | **9,826,251,363** | **6,347,590,677** |
| **Өр төлбөр ба эзэмшигчийн өмч** | | | |
| Дансны өглөг | 498,634,156 | 892,480,426 | 1,036,216,303 |
| Цалингийн өглөг | -71 | 0 | 0 |
| Орлогын татварын өглөг | 0 | 116,232,377 | 18,222,015 |
| ХАОАТ-ын өглөг | 20,371,920 | 0 | 15,873,727 |
| НӨАТ-ын өглөг | 10,066,759 | 0 | 0 |
| Бусад татварын өглөг | 479,980 | 0 | 0 |
| ЭМНД-ийн шимтгэлийн өглөг | 14,379,725 | 12,466,709 | 2,420,005 |
| Ноогдол ашгийн өглөг | 0 | 0 | 0 |
| Банкны богино хугацаат зээл | 0 | 0 | 770,000,000 |
| Бусад өглөг | 0 | 0 | 0 |
| Урьдчилж орсон орлого | 1,299,712,405 | 7,041,084,043 | 2,727,588,521 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,843,644,875** | **8,062,263,555** | **4,570,320,572** |
| **Урт хугацаат өр төлбөр** | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат векселийн өглөг | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат зээл | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат бондийн өглөг | 0 | 0 | 0 |
| Бусад урт хугацаат өглөг | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат өглөгийн хасагдуулга | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 0 | 0 | 0 |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **1,843,644,875** | **8,062,263,555** | **4,570,320,572** |
| **Эзэмшигчдийн өмч** | | | |
| Төрийн өмч | 0 | 0 | 0 |
| Хувийн өмч | 10,000,000 | 10,000,000 | 10,000,000 |
| Халаасны хувьцаа | 0 | 0 | 0 |
| Хувьцаат капиталын дүн | 10,000,000 | 10,000,000 | 10,000,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | 0 | 0 | 0 |
| Дахин үнэлгээний нөөц | 0 | 0 | 0 |
| Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | 0 | 0 | 0 |
| Хуримтлагдсан ашиг алдагдал | 1,417,415,658 | 1,753,987,808 | 1,767,270,105 |
| Тайлант үеийн | 815,733,244 | 0 | 0 |
| Өмнөх үеийн | 601,682,413 | 0 | 0 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **1,427,415,658** | **1,763,987,808** | **1,777,270,105** |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | **3,271,060,533** | **9,826,251,363** | **6,347,590,677** |

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

*Хүснэгт 8: Орлогын тайлан*

| Орлогын тайлан | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого ( цэвэр ) | 7,421,749,106 | 11,854,000,939 | 13,293,630,466 |
| Борлуулалтын өртөг | 3,153,801,063 | 9,785,560,895 | 11,368,404,239 |
| **Нийт ашиг (алдагдал )** | **4,267,948,043** | **2,068,440,044** | **1,925,226,227** |
| Түрээсийн орлого | 545,455 | 0 | 0 |
| Хүүгийн орлого | 5,198,787 | 11,764,918 | 2,722,686 |
| Ногдол ашгийн орлого | 0 | 0 | 0 |
| Эрхийн шимтгэлийн орлого | 0 | 0 | 0 |
| Бусад орлого | 21,817,273 | 38,157,317 | 60,189,109 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 0 | 0 | 0 |
| **Ерөнхий ба удирдлагын зардал** | **3,302,805,997** | **1,961,163,142** | **2,259,796,759** |
| Санхүүгийн зардал | 2,406,667 | 0 | 54,361,946 |
| Бусад зардал | 0 | 0 | 0 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз ) | 14,540,164 | 261,418,364 | 412,639,752 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | 0 | 0 | -14,297,186 |
| Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз ) | 0 | 0 | 0 |
| Бусад ашиг ( алдагдал ) | -90,074,124 | -38,444,954 | -50,377,680 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )** | **914,762,934** | **380,172,548** | **21,944,204** |
| Орлогын татварын зардал | 99,029,689 | 42,600,398 | 8,661,907 |
| Татварын дараах ашиг ( алдагдал ) | 815,733,244 | 337,572,150 | 13,282,297 |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал ) | 0 | 0 | 0 |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )** | **815,733,244** | **337,572,150** | **13,282,297** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 0 | 0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү | 0 | 0 | 0 |
| Гадаад валютын хорвуулэлтийн зөрүү | 0 | 0 | 0 |
| Бусад олз ( гарз ) | 0 | 0 | 0 |
| Цэвэр ашиг | 815,733,244 | 337,572,150 | 13,282,297 |
| **Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)** | **815,733,244** | **337,572,150** | **13,282,297** |

## 1.13. Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн талаар

Үнэт цаас гаргагч нь 2014 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээр нийт 4.570 тэрбум төгрөгийн богино хугацаатай өр төлбөртэй байна. Үүнээс 800 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор Чингис хаан банкнаас 2 жилийн хугацаатай жилийн 21.6%-ийн хүүтэй 2014 оны 8 дугаар сарын 4-ны өдрийн 1133/01/CL-2014 дугаартай гэрээгээр зээлийн шугам нээн санхүүжүүлсэн. Мөн 1 тэрбум төгрөгийн дансны өглөгтэй байна. Эрчим Инженеринг ХХК нь 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Зээлийн мэдээлийн сангийн лавлагааны мэдээллээр 9 удаа зээл авч байсан ба хугацаа хэтэрсэн түүхгүй, одоогоор зээлийн шугамын 565 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

## 1.14. Хараат бус аудиторын тайлан

Үнэт цаас гаргагч болон АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-н хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр тус аудитын компани нь Эрчим Инженеринг ХХК-н 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хараат бус аудиторын дүгнэлтийг дараахь байдлаар гаргасан байна.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХОНДЛОНГИЙН БАЙГУУЛЛАГА

**“Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК**

2015 он 06 сар 25 өдөр | № 1/300 | Улаанбаатар хот

**“Эрчим Инженеринг” ХХК-ийн хөрөнгө оруулагч танаа**

**Хараат бус аудиторын дүгнэлт**

“Эрчим Инженеринг” ХХК-ний 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдлийн тэнцэл, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, бусад тайлбар тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

**Санхүүгийн тайлангийн талаарх компанийн удирдлагын хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх; тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна.

**Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээрстандарт ньсанхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүйилэрхийлэгдсэнгэсэнзохих нотолгоотолжавах зорилгоораудитыгтөлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийгбиднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын үл үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

СЗХ
сар
БҮРТГЭВ
№ 01

"Эрчим Инженеринг" ХХК

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)**

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна

**Хараат бус аудиторын дүгнэлт**

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь "Эрчим Инженеринг" ХХК- ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал,тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь НББОУС-д нийцсэн тайлан гаргах шаардлага. Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө болон түүний үр ашигт байдлыг хангаж байна.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 91-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Эрчим инженеринг" ХХК-ийн хувь нийлүүлэгч болон хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн

Үнэт цаасны танилцуулга хавсаргасан бичиг баримтанд тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь бодит байдалд нийцсэн байна

ЗАХИРАЛ Г.ЭНХМАА

2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын тайланг бүрэн эхээр нь **Хавсралт 3.7**-оос үзнэ үү.



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
FRONT BANK

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

## 1.15. Санхүүгийн тайлангийн шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээг тус компанийн 2013-2014 оны аудитлагдсан санхүүгийн тайланд тулгуурлан хийлээ.

“Эрчим инженеринг" ХХК ны 2014 оны жилийн эцсээр нийт хөрөнгийн дүн нь 6,347,590,676.68 төгрөг болж өмнөх оноос 3,478,660,686.16 төгрөгөөр буурсан байна. Үүнийг задалж үзвэл эргэлтийн хөрөнгө 3,366,942,585.26 төгрөгөөр, эргэлтийн бус хөрөнгө 111,718,100.90 төгрөгөөр тус тус буурсан байна. Эргэлтийн хөрөнгийн бууралт нь мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал тооцоо буурснаас эргэлтийн бус хөрөнгийн бууралт элэгдлийн зардлаас шалтгаалсан байна. Тайлант онд 13,282,296.59 төгрөгийн цэвэр ашигтай ажилласанаар эзэмшигчдийн өмч 2014 оны эцэст 1,777,270,104,89 болж өссөн байна.

*Хүснэгт 9: Санхүүгийн шинжилгээ*

| А.Хөрөнгө<br>*1.Эргэлтийн хөрөнгө* | 2013<br>*Эхний үлдэгдэл* | 2014<br>*Эцсийн үлдэгдэл* | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1,148,822,410.52 | 60,750,092.35 | (1,088,072,318.17) |
| Дансны авлага | 809,707,273.89 | 830,904,155.05 | 21,196,881.16 |
| Татвар НДШ-ийн авлага | 8,961,557.78 | 8,136,567.76 | (824,990.02) |
| Бусад авлага | 3,429,641.60 | 3,429,641.60 | - |
| Бараа материал | 1,008,707,398.50 | 2,467,951,156.30 | 1,459,243,757.80 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо . | 5,514,010,101.84 | 1,755,524,185.81 | (3,758,485,916.03) |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | *8,493,638,384.13* | *5,126,695,798.87* | (3,366,942,585.26) |
| *2.Эргэлтийн бус хөрөнгө* | | | |
| Үндсэн хөрөнгө | 1,287,273,478.77 | 1,168,344,912.67 | (118,928,566.10) |
| Биет бус хөрөнгө | 37,839,499.94 | 45,049,965.14 | 7,210,465.20 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 7,500,000.00 | 7,500,000.00 | - |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | *1,332,612,978.71* | *1,220,894,877.81* | (111,718,100.90) |
| ***Нийт дүн*** | **9,826,251,362.84** | **6,347,590,676.68** | **(3,478,660,686.16)** |
| **Б.Өр төлбөр, Эзний өмч** | | | - |
| *1.Өр төлбөр* | | | - |
| Богино хугацаат өр төлбөр | 1,021,179,511.48 | 1,072,732,050.38 | 51,552,538.90 |
| Урьдчилж орсон орлого | 7,041,084,043.06 | 2,727,588,521.41 | (4,313,495,521.65) |
| Богино хугацаат зээл | | 770,000,000.00 | 770,000,000.00 |
| Богино хугацаат өр төлбөрийн үн | *8,062,263,554.54* | 4,570,320,571.79 | (3,491,942,982.75) |
| Урт хугацаат өр төлбөр | | | - |
| Нийт дүн | *8,062,263,554.54* | 4,570,320,571.79 | (3,491,942,982.75) |
| *Эзэмшигчдийн өмч* | | | - |
| Төрийн өмч | | | - |
| Хувийн өмч | 10,000,000.00 | 10,000,000.00 | - |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | | - |
| Нэмж төлөгдсөн капитал | | | - |
| Эздийн өмчийн бусад хэсэг | | | |
| Хуримтлагдсан ашиг | *1,753,987,808.30* | 1,767,270,104.89 | 13,282,296.59 |
| Дүн | *1,763,987,808.30* | *1,777,270,104.89* | 13,282,296.59 |
| ***Нийт дүн*** | **9,826,251,362.84** | **6,347,590,676.68** | **(3,478,660,686.16)** |

*Хүснэгт 10: Балансын шинжилгээ*

| **А.Хөрөнгө**<br>*1.Эргэлтийн хөрөнгө* | **2013**<br>*Эхний үлдэгдэл* | **2014**<br>*Эцсийн үлдэгдэл* | **Өөрчлөлт** |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 12% | 1% | -10.7% |
| Дансны авлага | 8% | 13% | 4.8% |
| Татвар НДШ-ийн авлага | 0% | 0% | 0.0% |
| Бусад авлага | 0% | 0% | 0.0% |
| Бараа материал | 10% | 39% | 28.6% |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 56% | 28% | -28.5% |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | *86%* | *81%* | -5.7% |
| *2.Эргэлтийн бус хөрөнгө* | | 0% | 0.0% |
| Үндсэн хөрөнгө | 13% | 18% | 5.3% |
| Биет бус хөрөнгө | 0% | 1% | 0.3% |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 0% | 0% | 0.0% |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | *14%* | *19%* | 5.7% |
| ***Нийт дүн*** | **100%** | **100%** | 0.0% |
| **Б.Өр төлбөр, Эзний өмч** | | 0% | |
| *1.Өр төлбөр* | 0% | 0% | 0.0% |
| Богино хугацаат өр төлбөр | 10% | 17% | 6.5% |
| Урьдчилж орсон орлого | 72% | 43% | -28.7% |
| Богино хугацаат зээл | 0% | 12% | 12.1% |
| Богино хугацаат өр төлбөрийн үн | *82%* | 72% | -10.0% |
| Урт хугацаат өр төлбөр | 0% | 0% | 0.0% |
| Нийт дүн | *82%* | 72% | -10.0% |
| *Эзэмшигчдийн өмч* | 0% | 0% | 0.0% |
| Төрийн өмч | 0% | 0% | 0.0% |
| Хувийн өмч | 0% | 0% | 0.1% |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 0% | 0% | 0.0% |
| Нэмж төлөгдсөн капитал | 0% | 0% | 0.0% |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 0% | 0% | 0.0% |
| Хуримтлагдсан ашиг | *18%* | 28% | 10.0% |
| Дүн | *18%* | *28%* | 10.0% |
| ***Нийт дүн*** | **100%** | **100%** | |

*Хүснэгт 11: Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн задаргаа*




*Хүснэгт 12: Орлогын тайланд гүйцэтгэсэн босоо шинжилгээ*

| А.Борлуулалт | 2014 он | Коэфф |
|---|---|---|
| 1.Цэвэр борлуулалт | 13,318,130,465.99 | |
| 2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 11,368,404,238.86 | |
| **Нийт ашиг** | **1,949,726,227.13** | |
| | | **Босоо шинжилгээ 2014 он** |
| 3.Үйл ажиллагааны зардал | ***2,284,296,759.07*** | |
| Цалингийн зардал | 1,057,024,843.00 | 46.3% |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | 126,346,105.74 | 5.5% |
| Засвар үйлчилгээний зардал | 21,872,501.37 | 1.0% |
| Ашиглалтын зардал | 64,715,034.57 | 2.8% |
| Албан томилолтын зардал | 72,478,564.04 | 3.2% |
| Бичиг хэргийн зардал | 3,803,564.59 | 0.2% |
| Элэгдлийн зардал | 211,656,032.91 | 9.3% |
| Түрээсийн зардал | 108,482,785.58 | 4.7% |
| Зар сурталчилгаа, сургалтын зардал | 19,153,411.82 | 0.8% |
| Шуудан холбооны зардал | 14,428,889.29 | 0.6% |
| Шатахууны зардал | 183,492,177.25 | 8.0% |
| Тээврийн зардал | 79,591,493.17 | 3.5% |
| Түүхий эд материалын зардал | 9,955,480.95 | 0.4% |
| Хангамжийн зардал | 14,304,160.16 | 0.6% |
| Даатгалын зардал | 19,256,261.60 | 0.8% |
| Бусад зардал | 277,735,453.03 | 12.2% |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | **(334,570,531.94)** | |
| 4.Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 472,828,861.32 | **3.6%** |
| 5.Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 119,036,812.10 | 5.2% |
| **Ердийн үйл ажиллагааны ашиг** | **19,221,517.28** | **0.1%** |
| 6. Хүүгийн орлого | 2,722,686.36 | 0.0% |
| 7.Онцгой зардал | | 0.0% |
| Татварын өмнөх ашиг | **21,944,203.64** | **0.2%** |
| Орлогын татварын зардал | 8,661,907.05 | 0.1% |
| Цэвэр ашиг | **13,282,296.59** | 0.1% |
| Нэгж хувьцаанд ноогдох ашиг | | |

Тайлант онд нийт 8,661,907.05 төгрөгийн татварын үүрэг хүлээж, 13,282,296.59 төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

*Зураг 9: Үйл ажиллагааны зардлын задаргаа*




Нийт үйл ажиллагааны зардлын 46%-ийг цалингийн зардал эзэлж байна. Энэ нь хүч ихээхэн шаардсан барилга угсралтын гүйцэтгэлийн ажил үйлчилгээ үзүүлж байгаатай холбоотой юм.

*Зураг 10: Төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ*







Бие даах чадварын коэффициент өмнөх оноос өссөн байна. Нийт өр төлбөрийн нийт хөрөнгөтэй харьцсан харьцаа буурсан.

*Хүснэгт 13: Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ*

| | 2013 | 2014 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Бие даах чадварын коэфф=Өөрийн капитал/Балансын дүн | 18% | 28% | -10% |
| Өрийн харьцаа=Нийт өр төлбөр/Нийт хөрөнгө | 82% | 72% | 10% |
| Өр эзний өмчийн харьцаа=Урт хугацаат өр/Эзний өмч | 0% | 0% | 0% |
| Гадны капиталын хувийн жин=Гадны капитал/Нийт хөрөнгө | 82% | 72% | 10% |

Альтманы индексээр санхүүгийн байдал 2.675 -аас дээш байвал тогтвортой гэж үздэг. Тус байгууллагын хувьд 3.31 байгаа нь санхүүгийн байдал тогтвортой байгааг харуулж байна.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

*Хүснэгт 14: Эргэцийн шинжилгээ*

| Эргэцийн шинжилгээ | |
|---|---|
| АЭ(өдөр)=360/(Бор.ор/Ав. Дун.Үлд) | 22.46 |
| НЭ(өдөр)=360/(ББӨ/БМҮБЗ.дун.үлд) | 31.94 |
| Эрг. Хөр.эргэц(өдөр)= 360/(Бор.ор/Ав. Дун .үлд) | 138.58 |
| Нийт хөрөнгийн ачаалал=Бор.ор/Баланс дүн | 2.10 |
| Өглөг эргэц=360/(Зээлээрх худалдан авалт/өглөг дундаж цуг) | 1,421.11 |
| Санхүүгийн цикл=АЭ+НЭ-АЭ | 192.98 |

Санхүүгийн эргэц 192.98 хоногт 1 эргэдэг гэж байгаа нь эргэлтийн хөрөнгийн эргэц удаан байгаагаас шалтгаалж байна. Тендерийн ажилтай холбоотой бараа материал татсан нь бараа материалын эргэцийг уртасгаж байна.

## 1.16. Үнэлгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлангийн дүгнэлт

“Эрчим инженеринг” ХХК-н захиалгаар ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК нь 2014 оны 12-р сарын 31-ний байдлаар тус компанийн нийт хөрөнгийн үнэлгээг компанийн өрийн бичиг босгох зорилгоор хийж гүйцэтгэсэн..

**Нэгдсэн үнэлгээний тайлан**

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн ангилал тус бүрээр тодорхойлсон болно. Энэ хэсэгт өмнөх хэсгүүдээр бэлтгэгдсэн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үнэлгээг нэгтгэж дараах хүснэгтээр харуулав.

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

*Хүснэгт 15: Цэвэр хөрөнгийн дүн*

| № | Хөрөнгийн нэрс | Дасны үнэ | Нэмэгдсэн | Хасагдсан | Шинэчилсэн үнэлгээгээр /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгөн хөрөнгө | 60,750,092 | - | - | 60,750,092 |
| 2 | Авлагын тооцоо | 320,244,803 | - | - | 309,658,236 |
| 3 | Бараа материал | 2,467,951,156 | - | - | 2,467,951,156 |
| 4 | Урьдчилж төлсөн зардал | 2,277,749,747 | - | 76,654,866 | 2,201,094,881 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | 5,126,695,799 | - | 76,654,866 | 5,039,454,365 |
| 5 | Тээврийн хэрэгсэл | 823,856,133 | - | 34,846,978 | 789,009,155 |
| 6 | Машин, тоног төхөөрөмж | 93,177,589 | 6,936,995 | - | 100,114,584 |
| 7 | Тавилга эд хогшил | 56,410,491 | - | - | 56,410,491 |
| 8 | Компьютер, дагалдах | 10,608,940 | - | - | 10,608,940 |
| 9 | Биет бус хөрөнгө | 17,773,410 | - | - | 17,773,410 |
| 10 | Лицэнз | 27,276,556 | - | - | 27,276,556 |
| 11 | Бусад хөрөнгө | 45,763,422 | - | - | 45,763,422 |
| 12 | Нэр төрийн зардал | - | 166,312,300 | - | 166,312,300 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 1,074,866,540 | 173,249,295 | 34,846,978 | 1,213,268,857 |
| Нийт | | 6,201,562,339 | 173,249,295 | 111,501,844 | 6,252,723,222 |

Шинэчлэн үнэлсэн нийт хөрөнгө (сая төгрөг)-ийн 6,252.7 сая төгрөг буюу 80.6 хувь нь эргэлтийн хөрөнгө 1,213.3 сая төгрөг буюу 19.4 хувь нь үндсэн хөрөнгө болж байна. Шинэчилсэн үнэлгээгээр эргэлтийн хөрөнгө 76,6 сая төгрөг буюу 3.37 хувиар хасагдаж, эргэлтийн бус хөрөнгө 138.4 сая төгрөг буюу 12.88 хувиар нэмэгдсэн байна.

Ийнхүү “Эрчим Инженеринг” ХХК-н нийт хөрөнгийн үнэлгээний дүнд нь 6,252,723,222 (Зургаан тэрбум хоёр зуун тавин хоёр сая долоон зуун хорин гурван мянга хоёр зуун хорин хоёр) төгрөгөөр үнэлэгдлээ.

**Үнэлгээний талаарх захиалагчийн болон гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага**

Үнэлгээг Олон улсын үнэлгээний стандарт, Монгол Улсын Компанийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 343-р тушаалаар батлагдсан барилга байгууламжийн нэгж хүчин чадлын сууръ үнэлгээ, Үндэсний статистикийн газраас гаргасан барилгын болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн үнийн өсөлтийн индекс, шуудан холбооны салбарын үнийн индекс зэргийг удирдлага болгон тус компанийн улсын бүртгэлийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээ, захиалагчийн санхүүгийн бүртгэл, тайлагнал, хөрөнгийн дэлгэрэнгүй жагсаалт, хөрөнгө оруулалтын төсөв, бизнес төлөвлөгөө, бусад материалд тулгуурлан хийлээ.

Үнэлгээг Сангийн сайдын 2007 оны 353, 2008 оны 367-р тушаалаар олгогдсон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн эрхийн 071200067 тоот гэрчилгээтэй үнэлгээчин С.Бадамгарав, туслах үнэлгээчин Г.Балжинням, туслах үнэлгээчин Т.Болортуяа нар хамтран гүйцэтгэсэн болно.

Үнэлгээний явцад ашигласан мэдээллийн нууцлал, гэрээнд заагдсан холбогдох бусад асуудлыг гүйцэтгэгч тал, харин үнэлгээчинд гаргаж өгсөн мэдээлэлийн үнэн бодит байдлыг “Эрчим Инженеринг” ХХК тус тус хариуцна. Үнэлгээчид энэхүү үнэлгээг хийхдээ ОУҮС-аар тогтоосон “Дүрэм”-ийн дагуу мэргэжлийн болон ёсзүйн дараах шаардлагуудыг мөрдсөн болно.

- Тайланд тусгагдсан баримт мэдээлэл нь үнэлгээчний мэдэж байгаагаар үнэн зөв;
- Шинжилгээ ба дүгнэлт нь тайлагнасан таамаглал, нөхцөл байдлаар хязгаарлагдсан;
- Үнэлгээчид нь мэргэжлийн боловсролын шаардлагыг хангасан;
- Үнэлгээчин үнэлж буй бизнесийн төрөл зүйлийн талаар туршлагатай;
- Тайланд тусгайлан дурьдсанаас бусад ямар ч этгээд тухайн тайланг бэлтгэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлээгүй болохыг баталж байна.

Үнэлгээг захиалагчийн ирээдүйн орлого, ашгаас хараат бусаар үнэлгээчний мэргэжлийн ёс зүйн дагуу гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний ажлын хөлсийг үнэлгээний дүнгээс хамааралгүйгээр гэрээгээр урьдчилан тогтоосон болно.

Хөрөнгийн үнэлгээний дэлгэрэнгүй тайланг **Хавсралт 3.6.**-аас үзнэ үү.

Үнэлгээний тайлан болон хавсралт тооцооллын талаар  дараах хаягаар тодруулж болно.

**"Эвидэнс Аудит" ХХК,** С.Бадамгарав Утас: (+976) 11 323497 , (+976) 99057121

**Хаяг:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу – 14201, Зоос Гоёл ХК байр 207

## 1.17. Үнэт цаас гаргахтай холбогдуулан гаргасан хуульчийн дүгнэлт

Үнэт цаас гаргагч болон Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс ХХН-ийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр дараах бичиг баримт, ажил гүйлгээнд хараат бус хуульчийн хууль зүйн дүгнэлтийг гаргасан байна.

1. Компанийн хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх,
2. Компанийн гүйцэтгэх удирдлага,эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдал,
3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх,
4. Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх,
5. Сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх,
6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх,
7. Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;
8. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох,
9. Нэмэлт шинжилгээ, судалгаа.

MDS & KHANLEX

MDS & Khanlex LLP
5 floor, Express Tower, Baga Toiruu
1 khoroo, Chingeltei District, 15160
Ulaanbaatar, Mongolia
Tel: (976) 11 330018
Fax: (976) 11 330019
E-mail: info@mdsa.mn

2015-07-02 № 05/218

"ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ" ХХК-ийн хөрөнгө оруулагчдад

## "ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ" ХХК-ИАС ГАРГАХ БОНД-ЫН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ҮНЭН ЗӨВ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТУХАЙ

## ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

***Нийтлэг үндэслэл***

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН нь Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн 25 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд (ХАВСРАЛТ 1 СЗХ-ны тогтоолын хуулбарыг хавсаргав)-ийн хувьд энэхүү хууль зүйн дүгнэлт гаргах эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Эрчим инженеринг" ХХК (цаашид "ЭИ" ХХК гэх) нь нийтэд санал болгон өрийн хэрэгсэл буюу бонд гаргах гэж байгаатай холбогдуулан хууль зүйн дүгнэлт гаргахыг бидэнд санал болгосон юм. (ХАВСРАЛТ 2 "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх тухай 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан гэрээ").

Энэхүү хууль зүйн дүгнэлтийг зөвхөн Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 5.2-т 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон гадагш хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах бөгөөд бусад үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр гаргаж болно. Мөн Компанийн тухай хуулийн 41.1-д "компани нь өөрийн хөрөнгийн хэмжээгээр баталгаа гаргаж тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргаж болно" гэж заасныг гадна өрийн хэрэгсэл гаргахад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.15-д заасны "өрийн хэрэгслийн тухайд эргэн төлөх баталгаа, барьцаа хөрөнгө"-ийн талаар үнэт цаасны танилцуулгад заах ёстой хуульчилсны дагуу тус компани нь энэхүү бондыг гаргах эрх зүйн үндэслэлтэй байна. Бондыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 (Үнэт цаас), 6 (Үнэт цаас гаргах) 7 (Үнэт цаас гаргагч), 9 (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 16-р зүйл (Компанийн өрийн хэрэгсэл)-д заасны дагуу бүртгүүлж, нийтэд санал болгон гаргахаар төлөвлөсөн байна.

2

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

Энэхүү бондын бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10.8.1, Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 2014/05 тоот тогтоолоор баталсан "Бүртгэлийн журам" болон Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "МХБ ТӨХК-ийн арилжааны журам"-ын дагуу явагдана. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 7/3201тоот албан бичгээс үзвэл "Бондын баталгааны даатгал"-ын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь энэхүү бондыг худалдан авах хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн шинэлэг алхам болж байна.

Бид хууль зүйн дүгнэлт гаргах зорилгоор "ЭИ" ХХК-аас түүний гэрчилгээ, дүрэм, Хувьцаа эзэмшигчийн шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг эх хувиар болон хуулбарыг тулган шалгаж, судалсан болно. (ХАВСРАЛТ 3 Хууль зүйн дүгнэлт гаргахтай холбогдуулан судалсан компанийн бичиг баримтын жагсаалт). Түүнчлэн компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно (ХАВСРАЛТ 4 Шүүх болон төрийн холбогдох 15 байгууллага болон банкуудаас гаргуулсан бичгүүд).

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, дүгнэлт гаргахдаа (а) үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, (б) бидэнд ирүүлсэн бүх бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн, зөв; (в) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг бодит, зөв; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (д) бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй гэж үзсэний үндсэн дээр, доор дурдсан асуудлаар, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн энэхүү хууль зүйн дүгнэлт гаргаж байна:

1. **Компани хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх**

"Эрчим инжиниринг" ХХК нь "Нөхөрлөл Компанийн тухай" хуулийн дагуу 1999 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн шийдвэрээр нэг гишүүнтэйгээр үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн. /Улсын бүртгэлийн дугаар: 9011023073, Регистрийн дугаар: 2571676/.

Тус компани нь нэг үүсгэн байгуулагчтай, үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн М.Батболд (Регистрийн дугаар: УС 59041357).

Компанийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг Компанийн хувьцаа эзэмшигчийн 2015 оны 5-р сарын 15-ны өдрийн 01/2015 тоот шийдвэрээр баталсан дүрэмд зааснаар "Гадаад худалдаа" болон "Эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, угсралт, туршилт, тохируулга" гэж заасан байна. Тус компанийн Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамнаас 2012 оны 5-р сарын 7-ны өдөр 3 жилийн хугацаатайгаар олгогдсон "Дулааны шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг", "Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг", "Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220кв хүртэл/", "Усны барилга байгууламжийн зураг төсөл", болон "Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн



ЭРЧИМ ИНЖИНИРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС

зураг төсөл" боловсруулах тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 5-р сарын 7-нд дууссан байна. Уг асуудлаар Барилгын хөгжлийн төвөөс лавлагаа авахад 2015 оны 6-р сарын 17 ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд одоогоор сунгуулах хүсэлтээ өгөөгүй байна гэсэн хариу өгсөн. Гэвч тус компаниас 2015 оны 5-р сарын 14 ны өдрийн 130/2015 тоот албан бичгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар хандсан байна.

Компани нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

2. **Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдал**

"ЭИ" ХХК"-ийн Захирал, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийг удирдах чадвар, дадлага туршлага хангалттай байна гэж үзэж байна. (ХАВСРАЛТ 3.5 удирдах албан тушаалтнуудын намтар).

3. **Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх**

Компанийн дүрэм болон дотоод журмууд нь дор дурдсан зүйлсээс бусад нь хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-д нийцэж байна гэж үзэж байна:

"Монголын компанийн засаглал кодекс"-н Дөрөвдүгээр бүлгийн 4.1.1-н а/ хэсэгт "...компанийн гүйцэтгэх удирдлагын бие даан шийдвэрлэж болох хөрөнгийн хэмжээг өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарлан тогтоох нь зүйтэй бөгөөд уг хэмжээний хөрөнгийн асуудлыг холбогдох төлөвлөгөөнд тусссан тохиолдолд шийдвэрлэх эрхтэй байх нь зүйтэй. Компанийн холбогдох төлөвлөгөөнд тусаагүй, эсхүл компанийн өөрийн хөрөнгийн 5 хувиас дээш хэмжээний хөрөнгийн талаар аливаа захиран зарцуулах шийдвэрийг ТУЗ шийдвэрлэдэг байвал зохино" гэж заасан байдаг. Гэвч "Эрчим инженеринг" ХХК-н Захирлаар хувьцаа эзэмшигч М.Батболд бүртгэлтэй байдаг бөгөөд Гүйцэтгэх удирдлагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилладаг байна. (ХАВСРАЛТ 3.6 Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээ).

4. **Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх**

Чингис хаан банк ХХК-тай 2014 оны 8-р сарын 04-ны өдөр байгуулсан 565,000,000 төгрөгийн Зээлийн шугам нээх гэрээ, болон Барьцааны гэрээ, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтүүд нь одоо хэрэгжих шатандаа байгаа бөгөөд эдгээр нь хэрэгжих боломжтой. зээл нь хэвийн ангилалд байна.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Улаанбаатар хотын VII хороолол, Монголын үндэсний радио телевизын орчмын хорооллын инженерингийн шугам сүлжээний үргэлжлэлийн ажлын хүрээнд "Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам",

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

түүнийг төлөөлж тус яамны төрийн нарийн бичгийн дарга болон "Бээжин контракшн инженеринг групп" ХХК нар 2010 оны 11-р сарын 5-ны өдөр БЗА-2010/55-ИШС дугаар бүхий "Улаанбаатар хотын VII хороолол, Монголын үндэсний радио телевизийн хэрэг эрхлэх газар орчмын орон сууцны хорооллуудын инженерийн шугам сүлжээ барьж байгуулах угсралтын ажлын гэрээ" байгуулсан. "Бээжин контракшн инженеринг групп" ХХК нь туслан гүйцэтгэгчээр "Инженерийн шугам сүлжээний барилга угсралт" ХХК-ыг сонгож барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ерөнхий туслан гүйцэтгэгчийн 2011 оны 11-р сарын 1-ны өдөр БЗА-2010/55-ИШС/Т2 тоот гэрээг байгуулж, 2012 оны 4-р сарын 12-ны өдөр талууд БЗА-2010/55-ИШС/Т2 тоот гэрээний тусгай нөхцлийг тохирсон.

Ерөнхий туслан гүйцэтгэгч "Инженерийн шугам сүлжээний барилга угсралт" ХХК нь 2012 оны 3-р сарын 7-ны өдөр туслан гүйцэтгэгчээр "ЭИ" ХХК-г сонгож "УБ хотын УБ-220/110/35кВ-ы дэд өртөөний өргөтгөл, 7-р хороолол, МҮОНТ-ийн 110/35/10кВ-ын дэд өртөө, 110кВ-ы ЦДАШ, хороолол дунд орших 10кв-н цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлын ерөнхий туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч ("ЭИ")-ийн БЗА-2010/55-ИШС/ТГ-05 тоот гэрээг байгуулж, 2014 оны 6-р сарын 20-ны өдөр гэрээнд нэмэлт оруулж хугацааг 2015 оны 7-р сарын 31-ны өдөр хүртэл сунгасан байна. Эдгээр гэрээний дагуу төслийг хэрэгжүүлэхэд Захиалагчаас төлбөр орж ирэх хүртэл барилгын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор бонд гаргаж байгаа бөгөөд эдгээр гэрээ нь үнийн дүнгийн хувьд хангалттай, хуульд нийцсэн байна.

**5. Сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх**

Компанийн тухай хуулийн 87.4-т заасныар Компани нэг эзэмшигчтэй бөгөөд уг этгээд гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх тохиолдолд энэ хуулийн арванзэгдүгээр бүлэг (Их хэмжээний хэлцэл)-ийн заалт хамаарахгүй гэж заасан бөгөөд тус компани нь нэг үүсгэн байгуулагчтай, үүсгэн байгуулагч М.Батболд нь тус компанийн Ерөнхий захирлаар ажиллаж байгаа тул хууль зүйн дүгнэлтийн энэ хэсэг нь тус компанийн хувьд хамааралгүй байна.

Мөн хуулийн 92.8-д Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай энэ хуулийн арванхоёрдугаар бүлэг (Сонирхлын зөрчилтэй хэлцэл)-т тогтоосон журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах тухай энэ хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална гэж заасан бөгөөд тус компанийн дүрэмд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг тусгайлан зохицуулаагүйг Компанийн тухай хуулийг зөрчсөн гэж үзэхгүй. Мөн гүйцэтгэх захирлтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тодорхой түйя заалт байхгүй.

**6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, гэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх;**

"ЭИ" ХХК нь Эрчим хүчний яамнаас олгогдсон "0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга,



МОНГОЛ УЛС
54

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

дагалдах ажил үйлчилгээ" болон "0,7-40,0 кгх/см$^2$ даралттай шугам хоолой, ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээний" тусгай зөвшөөрлүүдийг 2013 оны 6-р сарын 19-ны өдөр 3 жилийн хугацаатайгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрөл өнөөдрийн байдлаар хүчинтэй байгаа эсэх, одоогийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүссэн эсэх талаарх тодорхойлолт гаргуулахаар Эрчим хүчний яамнаа албан бичгээр хандсан. Эрчим хүчний яамны 2015 оны 6-р сарын 15-ны өдрийн в/1848 тоот албан бичгээр өгсөн тодорхойлолтод дурдсанаар дээрх 2 төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь 2013 оны 6-р сарын 19-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгогдсон бөгөөд 2015 оны 6-р сарын 15-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл үүсээгүй байна.

Барилга хот байгуулалтын яамнаас олгогдсон "Дулааны шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг", "Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг", "Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220кв хүртэл/", "Усны барилга байгууламжийн зураг төсөл", болон "Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл" боловсруулах тусгай зөвшөөрлийн лавлагааг авахаар Барилга хот байгуулалтын яаманд хандсан. Барилга хот байгуулалтын яам лавлагааг гаргуулахаар "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-т 2015 оны 6-р сарын 11-ны өдрийн 8/1893 тоот албан бичгээр хандсан. Барилгын хөгжлийн төвөөс 2/1391 тоот албан бичгээр өгсөн тодорхойлолтод дээрх 5 төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 5-р сарын 7-ны өдөр дууссан бөгөөд 2015 оны 6-р сарын 17-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл өгөөгүй байгаа талаар дурдсан байна. Гэвч тус компаниас 2015 оны 5-р сарын 14 ны өдрийн 130/2015 тоот албан бичгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар хандсан байна.

"ЭИ" ХХК нь ямар нэгэн лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмшдэггүй болно.

6. **Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа;**

"ЭИ" ХХК нь нийт 500,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 50,000 ширхэг бондыг 6 сарын хугацаатайгаар гаргана. Бонд нэг бүр 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18,50 хувийн хүүтэй байна. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна. Энэ тухай ХАВСРАЛТ 3.4–өөс үзнэ үү.

7. **Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох**

"ЭИ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагааг 2015 оны 6 дугаар сарын 5-ны байдлаар "Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн төв архив"-аас гаргуулан судлав ( ХАВСРАЛТ 4-ын 1.Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа). 2015 оны 6-р сарын 5-ны өдрийн байдлаар "ЭИ" ХХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэн М.Батболд 100 хувь эзэмшиж байна. "ЭИ" ХХК-ийн хувьцаа



55

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

эзэмшигч бөгөөд Ерөнхий захирал М.Батболд нь тус компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч мөн.

8. Нэмэлт шинжилгээ, судалгаа

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэж зарим нэмэлт шинжилгээ судалгаа (Due diligence) хийж, шаардлагатай гэж үзсэн холбогдох мэдээлэл цуглуулж, доор дурдсан дүгнэлт хийв. Үүнд:

- "ЭИ" ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд Хан-Уул дүүргийн шүүхийн 2013 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 1489 тоот шийдвэртэй, "Пролог солюшн" ХХК-ийн нэхэмжлэлтэй 34,023,479 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан бөгөөд 2015 оны 6-р сарын 4-ны байдлаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тодорхойлолт дээр ямар нэгэн өр төлбөргүй гэж тодорхойлогдсон тул дээр дурдсан шийдвэрийг биелүүлж, нэхэмжлэгчид төлбөрийг төлсөн байна. Захиргааны шүүх, арбитрт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаагүй.

- Нийслэлийн татварын газраас ирүүлсэн мэдээллээр 14,187,556.8 төгрөгийн татварын илүү төлөлттэй, Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр гаалийн татварын өргүй. Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн мэдээллээр нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байна.

- Тус компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэлд тусгаснаар өөрийн данс байршуулсан Голомт банк болон Худалдаа хөгжлийн банкны зээлийн албан ёсны мэдээллээр тус банкинд зээлийн болон зээлийн хүүгийн өр төлбөргүй байна. Чингис хаан банкинд 2015 оны 6-р сарын 9-ны байдлаар 565,000,000 (таван зуун жаран таван сая) төгрөгийн зээлийн шугамын үлдэгдэлтэй байна.

- Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн мэдээллээр "ЭИ" ХХК нь Өрсөлдөөний тухай хуульд заасан зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоолгож байгаагүй бөгөөд тус компани нь 2015 оны 6-р сарын 23-ны өдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хуулийг зөрчиж байгаагүй ба Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас торгууль, шийтгэвэр оногдуулж байгаагүй байна.

- Эрчим хүчний яамнаас "0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ" болон "0,7-40,0 кгх/см$^2$ даралттай шугам хоолой, ЦТХ-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах үйлчилгээний" тусгай зөвшөөрлүүдийг 2013 оны 6-р сарын 19-ны өдөр 3 жилийн хугацаатайгаар авсан. Эрчим хүчний яамнаас ирүүлсэн мэдээллээр 2015 оны 6-р сарын 15-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл үүсээгүй байна.



ЭРДЭНЭ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
ГОЛОМТ БАНК

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

- Барилга хот байгуулалтын яамнаас "Дулааны шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг", "Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг", "Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220кв хүртэл/", "Усны барилга байгууламжийн зураг төсөл", болон "Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл" боловсруулах тусгай зөвшөөрлийг авсан. Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн мэдээллээр "уг тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 5-р сарын 07-ны өдөр дууссан бөгөөд 2015 оны 6-р сарын 17-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл өгөөгүй байна" гэж мэдэгдсэн. Гэвч тус компаниас 2015 оны 5-р сарын 14 ны өдрийн 130/2015 тоот албан бичгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар хандсан болох нь нотлогдож байна. ( ХАВСРАЛТ 3.8 "ЭИ"-ээс БХБЯ-нд өгсөн Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт). Тус компанийн одоогийн хэрэгжүүлж байгаа төслүүд нь Эрчим хүчний яамнаас 2013 оны 6 дугаар сарын 19-ний өдөр 3 жилийн хугацаагаар олгогдсон 165\13 дугаартай "0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ" болон "0,7-40,0 кгх/см² даралттай шугам хоолой, ЦТХ-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах үйлчилгээний" тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэгжиж байгаа тул Барилга хот байгуулалтын яамнаас дээр дурдсан тусгай зөвшөөрөл сунгахаар хүлээгдэж буй нь бонд эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөргүй байна.

**8. Дүгнэлт**

"ЭИ" компанийн Бонд гаргах танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн байна. Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн тухай нотолгоог (ХАВСРАЛТ 5)-аас үзнэ үү.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН,
ХУУЛЬЧ Д.ДҮГЭРЖАВ

ЭМ ДИ ЭС ЭНД
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

## 1.18. Хууль эрх зүйн орчин

"Эрчим инженеринг" ХХК нь 1999 онд нийт 10 000 000 (арван сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр Нөхөрлөл, компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Компанийн тухай хууль (2011)–ийн дагуу шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь "Эрчим хүчний тухай" хуулийн 12-р зүйлд заасны дагуу эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөлд хамаарах:

- "0.4-220кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ",
- "0.7-40.0 кгх/см2 даралттай шугам хоолой, ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ" төрлийн тусгай зөвшөөрлүүд,

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15.14.6-д заасан барилгын байгууламжийн зураг төсөл боовсруулах тусгай зөвшөөрөлд хамаарах:

- Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг,
- Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг,
- Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220 КВ хүртэл/,
- Усны барилга байгууламжийн зураг төсөл,
- Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн ажлын зураг төсөл зэрэг тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

Компанийн тухай хуулийн 41.1-д "компани нь өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргаж болно" гэж заасснаас гадна өрийн хэрэгсэл гаргахад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.15-д зааснаар "өрийн хэрэгслийн тухайд эргэн төлөх баталгаа, барьцаа хөрөнгө"-ийн талаар үнэт цаасны танилцуулгад заах ёстойг хуульчилсны дагуу тус компани нь энэхүү бондыг гаргах эрх зүйн үндэслэлтэй байна.

Бондыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 (Үнэт цаас), 6 (Үнэт цаас гаргах) 7 (Үнэт цаас гаргагч), 9 (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 16-р зүйл (Компанийн өрийн хэрэгсэл)-д заасны дагуу бүртгүүлж, нийтэд санал болгон гаргана. Уг хуулиар хязгаарлагдмал хариуцлагатай компани бонд гаргахыг хориглоогүй болно.

Энэхүү бондын бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10.8.1, Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 2014/05 тоот тогтоолоор баталсан "Бүртгэлийн журам" болон Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2012 оны 2 дугаар

сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "МХБ" ТӨХК-ийн арилжааны журам"-ын дагуу явагдана.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 7\3201 тоот албан бичгээс үзвэл "Бондын баталгааны даатгал"-ын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь энэхүү бондод хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн шинэлэг алхам болж байна.

# Хоёр. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

## 2.1. Олон нийтэд санал болгох бондын танилцуулга

**Үнэ цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 42, 43 дугаар зүйл, Үнэт цаасны тухай хуулийн 4, 5 дугаар зүйлсийг үндэслэн олон нийтэд нээлттэй бонд гаргаж байна.**

| | |
|---|---|
| **Бондын төрөл** | Хямдруулсан үнэтэй бонд |
| **Нэгж бондын нэрлэсэн үнэ** | 10,000 төгрөг |
| **Нийт ширхэг** | 50,000 ширхэг |
| **Нийт үнийн дүн** | 500,000,000 төгрөг |
| **Бондын хугацаа** | 6 сар |
| **Хүүгийн хэмжээ** | Жилийн 18.50% (сарын 1.54%) |
| **Хүү төлөх хугацаа** | Хугацааны эцэст нэг удаа |
| **Бонд гаргах зорилго** | Тендерийн ажлын гүйцэтгэл, төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| **Бондын баталгаа** | Бондын Даатгалаар 100% даатгагдсан Даатгагч “Соёмбо Даатгал” ХХК |
| **Үндсэн андеррайтер** | “Голомт банк” |
| **Туслах андеррайтер** | “Голомт Секюритиз” ҮЦК |
| **Бонд эзэмшигчдийн бүртгэл, төлбөр тооцооны хадгаламж** | “Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжын төв” ТӨХК |
| **Бонд арилжих зах зээл** | Монголын Хөрөнгийн биржийн арилжаагаар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаална. |

## 2.2. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр

“Компанийн тухай хууль”-ийн 42, 43 дугаар зүйл, “Үнэт цаасны тухай хууль”-ийн 5,6 дугаар зүйлийг үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчийн 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 07/15 дугаар бүхий шийдвэрээр нийт 500,000,000 төгрөгийн үнэ бүхий, нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000 ширхэг “Эрчим бонд"-ыг жилийн 18.50 хувийн хүүтэй (%), хүүг хугацааны эцэст төлөхөөр хямдруулсан үнэтэйгээр гаргахаар шийдвэрлэсэн.

**Шийдвэрийн эх хувийг Хавсралт 3.1-с харна уу.**

## 2.3. Бондын баталгаа

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны зөвшөөрөл бүхий Соёмбо Даатгал компанитай Бондын Даатгалын гэрээ байгуулан энэхүү “Эрчим Бонд”-ын эргэн төлөлтийг 100% даатгуулсан. Энэхүү бондын даатгал нь бонд эзэмшигчдийн хувьд бондын төлбөрийг хүүгийн хамт хугацааны эцэст бүрэн хүлээж авах баталгаа болно. Андеррайтер

болон Даатгагч нь бондын хугацаанд Бондын эргэн төлөлтийн эрсдэл дээр хамтран хяналт тавьж ажиллана.

Бондын даатгалын гэрээнд зааснаар энэхүү даатгалын харилцаа нь Иргэний хуулийн 441 дүгээр зүйлд заасан Бусад этгээдэд ашигтайгаар даатгах даатгалд хамаарах ба энэ хүрээнд Даатгуулагч нь өөрийн нэрийн өмнөөс Хөрөнгө оруулагчид ашигтайгаар Бондын баталгааны даатгалын гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээний үндсэн дээр даатгалын тохиолдол үүсч, даатгалын нөхөн төлбөр хийгдэх тохиолдолд түүнийг хүлээн авах эрхийг ашиг сонирхол нь даатгагдсан этгээд буюу Хөрөнгө оруулагч эдлэхээр заасан байгаа.

**Даатгалын компанийн тухай**

Соёмбо даатгал нь 1990 онд байгуулагдсан. Одоогийн байдлаар нийт 29 салбартай. Даатгалын чиглэлээр олон улсын хэмжээнд арвин туршлага хуримтлуулсан боловсон хүчинтэй. Монгол улсын хэмжээнд 35000 гаруй хувь хүн, 10500 гаруй албан байгууллагатай хамтран ажилладаг. Соёмбо Даатгал нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос бондын баталгааны даатгалын бүтээгдэхүүний анхны зөвшөөрлийг 2015 оны 6-р сард авсан байна.

**Эрчим бондын эргэн төлөлтийг Соёмбо даатгал Санхүүгийн даатгалын гэрээгээр 100% бүрэн даатгаж, бондын эргэн төлөлтийн баталгааг хангаж байна.**

**Соёмбо даатгалын төлбөрийн чадварын талаар**

Соёмбо даатгал нь өөрийн Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд НББОУС, МУ-н нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдлөгө болгон ажилладаг.

Даатгалын байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран санхүүгийн тайланд даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын хураамж, буцаасан даатгалын хураамж, даатгалын цэвэр хураамж, орлогод тооцоогүй хураамж, орлогод тооцсон хураамж, нэхэмжилсэн хохирлын нөөц сан, учирч болзошгүй хохирлын нөөц сан, даатгалын нөхөн төлбөр зэрэг нэр томьёо, данснуудыг тусгадгийг анхаарах хэрэгтэй.

**Соёмбо даатгал 2014 оны жилийн эцсийн хураангуй тайлан, түлхүүр үзүүлэлтүүд**

*Хүснэгт 16: Даатгалыг компаний санхүүгийн үзүүлэлт*

| Санхүүгийн үзүүлэлт /сая төгрөг/ | 2014 он |
|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 6 340.7 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 2 691.9 |
| Нийт хөрөнгийн дүн | 9 032.6 |
| Богино хугацаат өр төлбөр | 484.9 |
| Урт хугацаат өр төлбөр | - |
| Нөөц сангийн дүн | 3 691.8 |
| Эздийн өмч | 4 855.8 |
| Даатгалын нийт хураамжийн орлого | 5 198.7 |
| Давхар даатгалын хураамж | 389.2 |
| Нийт нөхөн төлбөр | 1 752.3 |

*Хүснэгт 17: Түлхүүр үзүүлэлт*

| Түлхүүр үзүүлэлтүүд | Сүүлийн 3 жилийн дундаж /%/ |
|---|---|
| Нийт нөхөн төлбөр/даатгалын нийт хураамжийн орлого | 33.7% |
| Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлт | 0.5% |
| Төлбөрийн чадварын зохистой харьцаа үзүүлэлт | 133.1% |

Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгч даатгалын компаниудын төлбөрийн чадварыг тооцох жишиг үзүүлэлтийг даатгалын компанийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг өр төлбөрийн дүнд харьцуулан хувьчилж гаргадаг.

Энэхүү үзүүлэлт нь

- 125% буюу түүнээс дээш байвал төлбөрийн чадвар сайтай,
- 100% – 125% -н хооронд байвал даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүй,
- 100%-аас доош байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцдог.

2014 оны санхүүгийн жилийн эцсийн байдлаар Соёмбо даатгалын төлбөрийн чадварын зохистой харьцааны үзүүлэлт 133.09% байсан нь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангаад зогсохгүй салбартаа манлайлах үзүүлэлт болж байна.

Даатгалын салбарын хяналт тавих, зохицуулагч эрх бүхий байгууллага нь Санхүүгийн Зохицуулах Хороо бөгөөд улирал бүр санхүүгийн тайлангийн хамтаар "Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам"-ын хоёрдугаар хавсралт дахь Маягт 2-н дагуу Төлбөрийн чадварын үзүүлэлтийг тайлагнадаг.

Даатгалын компаниудын дээрх төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт тогтвортой байдлыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос эрх авсан актуарч үйл ажиллагаа явуулж тооцоолно. Даатгалын тухай хуулинд "Актуарч" гэж даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдлийг

урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийг ойлгоно гэж заасан байдаг байна.

**Санхүүгийн баталгааны даатгал буюу Бондын Даатгалын тухай**

- Тухайн төсөлд шаардлагатай байгаа хөрөнгийн эх үүсвэрийг татах зорилгоор гаргах бондын эргэн төлөлтийг хугацаанд нь хийх баталгаа болж хийгдэж буй даатгалын харилцааг бондын даатгал гэнэ.
- Даатгалын тохиолдол нь бонд гаргагч тал аливаа шалтгаанаас үүдэн Хөрөнгө оруулагчид бондын төлбөрийг өгч чадахгүй буюу үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдлыг хэлнэ.
- Даатгалын харилцаа нь Иргэний хуулийн 441 дүгээр зүйлд заасан Бусад этгээдэд ашигтайгаар даатгах даатгалд хамаарах бөгөөд Даатгуулагч өөрийн нэрийн өмнөөс Хөрөнгө оруулагчид ашигтайгаар Бондын баталгааны даатгалын гэрээ байгуулах ба энэхүү гэрээний үндсэн дээр даатгалын тохиолдол үүсч, даатгалын нөхөн төлбөр хийгдэх тохиолдолд түүнийг хүлээн авах эрхийг ашиг сонирхол нь даатгагдсан этгээд буюу Хөрөнгө оруулагч эдлэнэ.
- Хөрөнгө оруулагчид олгосон даатгалын нөхөн төлбөрийг Даатгагч нь даатгалын тохиолдлоос хойш Даатгуулагчаас эргүүлэн шаардах эрхтэй байна.

| Даатгалын Гэрээний оролцогч талууд | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч буюу Даатгуулагч** | “Үнэт цаас гаргагч” гэж хуульд заасны дагуу үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа этгээдийг ойлгоно. Даатгалтай үнэт цаас гаргагч нь даатгуулагч байна. |
| **Даатгагч** | “Даатгагч” гэж бонд гаргагч тал буюу төсөл хэрэгжүүлэгчийн өмнөөс даатгалын тохиолдол болсон нөхцөлд эргэн төлөлтийг хийх үүрэг хүлээсэн этгээдийг ойлгоно. |
| **Андеррайтер** | “Андеррайтер” гэж хуульд заасны дагуу үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгоход мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэтгээдийг ойлгоно. |
| **Хөрөнгө оруулагч** | “Хөрөнгө оруулагч” гэж бондыг худалдан авч буй аливаа этгээд буюу бондыг хямдруулсан үнээр худалдан авч хугацааны эцэст бондын нэрлэсэн үнийн дүнг хүлээн авах этгээдийг ойлгоно. |

**Даатгалын гэрээний нөхцөл**

| **Бондын Даатгал** | |
|---|---|
| **Даатгалын тохиолдол** | Бонд гаргагч тал бонд эзэмшигч буюу хөрөнгө оруулагчдад бондын нөхцлийн дагуу үндсэн төлбөр болон хүү, хямдруулсан бондын хувьд нэрлэсэн үнийн дүнг хугацаанд нь төлж чадахгүй болсныг даатгалын тохиолдол гэнэ. |
| **Даатгалын хугацаа** | Бонд арилжигдаж эхэлсэн өдрөөс бондын төлбөрийг Хөрөнгө оруулагчид төлж дуусах өдөр хүртэл буюу Бондын хугацаа байна. |
| **Даатгалын үнэлгээ** | Хямдруулсан бондын хувьд Бондын хугацааны эцэст төлөгдөх бондын нэрлэсэн үнийн дүн, болон төлбөрийг Хөрөнгө оруулагчдад олгохтой холбогдон гарах бусад зардалийн нийлбэр байна. |

Даатгалын тохиолдол үүсэх нөхцөл байдал бий болсон тохиолдолд:

Ийм нөхцөл үүссэн тохиолдолд Даатгуулагч нь бондын эргэн төлөх хугацаа болохоос ажлын 15 өдрийн өмнө Даатгагч болон Андеррайтерт энэ тухай мэдэгдэх үүрэгтэй бөгөөд уг мэдэгдлийг авсан даруйд Даатгагчаас бондын төлбөртэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн хөрөнгийг даатгалын нөхөн төлбөрийн нөөц болгон Андеррайтер банкинд байршуулна. Андеррайтер нь уг нөөц санд бондын хугацаа дуустал хяналт тавина. Бондын хугацаа болоход Даатгагч нь уг тусгаарласан нөөцөөс даатгалын нөхөн төлбөр болгож бондын төлбөрийг хөрөнгө оруулагчдад шилжүүлнэ.

Даатгалын гэрээг талууд гэрээний хугацаанд цуцлах боломжгүй бөгөөд хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн энэхүү үүрэг нь давагдашгүй хүчин зүйлсээс бусад тохиолдолд ямагт хүчин төгөлдөр хэвээр байна.

*Хүснэгт 18 Бондын баталгааны схем*




**Схемийн тайлбар:**

1. Төсөл хэрэгжүүлэгч буюу бонд гаргагч тал болох Даатгуулагч нь Даатгагчтай Бондын Даатгалын гэрээ байгуулж бонд гаргагч нь даатгалын хураамжийг Даатгагчид шилжүүлнэ.
2. Андеррайтерийн гэрээ байгуулагдаж Андеррайтерийн үйлчилгээг хэрэгжүүлнэ.
3. Хөрөнгийн бирж дээр бондыг брокерийн компаниудаар дамжуулан борлуулна.
4. Бонд зарагдсанаар даатгалын хугацаа эхэлж Даатгагчид даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд нөхөн төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлөх үүрэг үүснэ.
5. Бондын борлуулалтаар орж ирсэн эх үүсвэр бонд гаргагчид орж ирснээр төслийн ажлын санхүүжилт бүрдэж, ажлыг хэрэгжүүлнэ.
6. Бондын эргэн төлөлтийн хугацаа болох үед даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд Даатгагч нь нэн даруй хөрөнгө оруулагчдад нөхөн төлбөр болох бондын төлбөрийн бүрэн олгоно.
7. Даатгагч бонд гаргагчаас нөхөн төлбөр олгогдсоны дараа шаардах эрхийн дагуу гаргасан нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхтэй.

## 2.4. Үнэт цаас эзэмшигчийн эрх

Бонд эзэмшигч нь дараах эрхтэй байна. Үүнд:

- Бонд эзэмшигч нь дараах бичиг, баримтууд болон мэдээллийг шаардах эрхтэй үүнд:
  - Компанийн улирлын санхүүгийн тайлантай танилцах
  - Бондын хоёрдогч зах зээлийн үнийн мэдээг хүлээн авах
  - Бондын хоёрдогч зах зээлийн арилжааны саналыг хүлээн авах
- Бонд эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй бондыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах,
- Хугацааны эцэст бондыг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, эсвэл хугацааны эцэст бондын

даатгагчийг бондын эргэн төлөлтийг хийхийг шаардах болон Монгол улсын хуульд заасан бусад холбогдох хууль, журамд заасан эрхүүдийг эдэлнэ.

## 2.5. Үнэт цаас гаргагчийн үүрэг

- Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлнэ.
- Үнэт цаас гаргагч нь Бонд борлуулснаас орсон орлогыг зөвхөн Андеррайтерын гэрээнд тусгагдсаны дагуу зарцуулна.
- Үнэт цаас гаргагч нь бондыг нэрлэсэн үнээр хугацааны эцэст хөрөнгө оруулагчаас буцаан худалдаж авна.
- Үнэт цаас гаргагч нь Бондын даатгалын гэрээний дагуу даатгагчийн өмнө үүрэг хүлээнэ.
- Үнэт цаас гаргагч нь бондын төлбөрийг бондын хугацаанд хөрөнгө оруулагчидад төлөх. Энэхүү үүргийг биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Бонд эзэмшигчид мэдээлэл хүргэх үүрэг**

Эрчим бондыг худалдан авсан хөрөнгө оруулагчид нь дараах сувгуудаар Компанийн үйл ажиллагааны сүүлийн үеийн мэдээлэл, тайлбарыг авна.

- Эрчим Инженеринг ХХК нь өөрийн веб сайт (www.erchim.mn)-аар дамжуулан компанийн үйл ажиллагаа, бондын хоёрдогч зах зээлийн арилжааны мэдээллийг хөрөнгө оруулагчидад нээлттэйгээр байршуулах үүрэгтэй.
- Андеррайтер нь бонд эзэмшигчийн электрон шуудангийн хаягаар бондын хоёрдогч зах зээлийн саналыг хүргэх үүрэгтэй.

## 2.6. Даатгагчийн хүлээх үүрэг

- Даатгалын тохиолдол бий болсон үед нөхөн төлбөрийг бондын эргэн төлөгдөх заасан хугацаанд Даатгуулагчийн нэрийн өмнөөс хөрөнгө оруулагчидад ҮЦТТТХТ-өөр дамжуулан шилжүүлэх үүрэгтэй.
- Даатгалын зах зээлийн, хууль тогтоомж, даатгалын нөхцөл, өөрийн санхүүгийн чадавхийн талаарх бүрэн, үнэн зөв мэдээллийг Андеррайтерт тухай бүрт өгнө.

## 2.7. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бондын хүүгийн түвшин

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй "Эрчим бонд"-ын хүүг тогтоохдоо Засгийн газрын бондын хүү, арилжааны банкуудын хадгаламж, зээлийн хүүгийн түвшин зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр суурь хүүг тогтоон, компанийн зээлийн эрсдлийн хувь, даатгалын хувь, хөрвөх чадварын хувь зэргийг нэмж тооцсон.

2015 оны 05 дугаар сарын байдлаар Монгол банкнаас тооцоолон гаргадаг банк хоорондын захын хадгаламжийн хүү 14.51%, жигнэсэн дундаж хүү 13.57%, бодлогын хүү 13.00% байна. Арилжааны томоохон зургаан банкны энгийн, хугацаатай /6 сар/ хадгаламжийн дундаж хүү жилийн 13.12% байна.

Сангийн яамнаас гаргаж буй 2015 оны 06 сарын 30-ны өдөр МХБ-ээр арилжаалсан 12 долоо хоногийн хугацаат Засгийн Газрын Үнэт Цаас /ЗГҮЦ/-ны хүүгийн хэмжээ 14.415% -тай, 52 долоо хоногтой ЗГҮЦ-ны хүү 15.473%-тай гарсан байна.

*Хүснэгт 19: Засгийн газрын үнэт цаасны хүү*

| | ЗГҮЦ | Хүү |
|---|---|---|
| 1 | ЗГҮЦ 12 долоо хоног, хямдруулсан | 14.415% |
| 2 | ЗГҮЦ 52 долоо хоног, сар бүр тогтмол хүүтэй | 15.473% |

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ЗГҮЦ нь эргэн төлөлт нь найдвартай хамгийн эрсдэл багатай үнэт цаасанд тооцогддог. Хэдий тийм ч манай улсын хөрөнгийн зах зээл дээр ЗГҮЦ-н хүү нь арилжааны банкуудын энгийн хугацаатай хадгаламжийн хүүтэй ойролцоо буюу илүү хүүг санал болгож байна.

Эрчим бондын хүүг тогтоох анхдагч суурь нь ойролцоо хугацаат ЗГҮЦ-ын хүүн дээр үндэслэнэ. 2014 оны 11 дүгээр сараас эхлэх Засгийн Газрын үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар ЗГҮЦ нь 12, 28, 52 долоо хоногийн хугацаатайгаар арилжигдаж байна.

Хугацаанаас хамааралтай ЗГҮЦ-уудын хүүгийн зөрүү /spread/ харьцуулалт дараах байдалтай байна.

*Зураг 11:ЗГҮЦ-ны хүү*




Дээрх графикаас харахад өнгөрсөн 6 сарын хугацаанд 28 долоо хоногтой ЗГҮЦ нь 12 долоо хоногтой ЗГҮЦ-наас дунджаар 0.60 нэгжээр илүү, 52 долоо хоногтой ЗГҮЦ-наас дунджаар 0.50 нэгжээр бага байна.Үүний дунд одоогийн байдлаар энэхүү бондын хүүгийн ЗГҮЦ-ны хүүтэй харьцуулах суурь 15 хувь орчимд байхаар байна. Үүн дээр компанийн эрсдлийн түвшинг гаргах бондын хэмжээ, хугацаа, болон даатгалын компанийн эрсдэл даах чадварыг харгалзан үзэж 2.70 хувиар эрсдлийн нэмэгдэлийг, мөн ЗГҮЦ-тай харьцуулахад хөрвөх чадвар бага гэж үзэн 0.8 хувиа хөрвөх чадварын нэмэгдлийг тус тус тооцон ЗГҮЦ-тай дүйцүүлсэн суурь хүүн дээр нэмсэнээр энэхүү бондын хүү нь ойролцоогоор 18.494% болж байна.

Тиймээс Эрчим бондыг хүүг жилийн 18.5 хувь буюу сарын 1.54 хувь байхаар тогтов. Энэхүү ттогтоосон хүү нь одоогоор зах зээл дээр санал болгож байгаа хадгаламжийн

хүүний дундаж түвшингээс 5.5 нэгжээр өндөр, зээлийн хүүний дундаж түвшингээс 6 нэгжээр бага байна.

*Зураг 12: Бондын хүүгийн харьцуулалт*




Хөрөнгө оруулагчдын хувьд энэхүү бондын хүүний хэмжээгээр хүүний орлого хүртэх боловч эцсийн өгөөж нь татвар болон холбогдох арилжааны шимтгэлийг төлсний дараа үлдэх цэвэр ашгаар тодорхойлогдоно. Бондын хүүгийн орлого нь татвараас чөлөөлөгдөхгүй тул хөрөнгө оруулагчид эцсийн өгөөжөө татварын дараах өгөөжөөр тооцох нь зүйтэй.

Хөрөнгө оруулагчдын бас нэг анхаарч үзэх зардал нь брокерийн үйлчилгээний шимтгэл бөгөөд энэ нь арилжааны дүнгээс хамаараад 0.1 - 0.5 хувь орчим байна.

*__Татварын тухай:__*

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8,13 дугаар зүйлд зааснаар хүүгийн орлого нь татвар ногдох орлого бөгөөд 19 дүгээр зүйлд зааснаар хүүгийн орлогыг дүнгээр нь тооцож татвар ногдуулна. Тус хуулийн 23 дугаар зүйлд зааснаар ногдуулах албан татварын хэмжээ 10 хувь байна.

Иймд хөрөнгө оруулагч нь бондын хүүгийн орлогоноос 10 хувийн албан татвар төлөх бөгөөд энэхүү бондыг худалдаж авснаар хөрөнгө оруулагчдад очих татварын дараах өгөөж нь 16.60 хувь байхаар тооцоологдож байна.

Бондын хугацааны туршид хөрөнгө оруулагч нь бондоо хоёрдогч зах зээл дээр худалдах тохиолдолд худалдаж буй үнэ нь тухайн хөрөнгө оруулагчийн уг бондыг худалдаж авсан үнэ болон тухайн хугацаанд хуримтлагдсан хүү, холбогдох арилжаанд оролцоход гарсан зардлуудын нийлбэрээс илүү гарсан тохиодолд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8, 20 дугаар зүйлд зааснаар хөрөнгө

борлуулсны орлогод ногдох албан татвар /тус хуулийн 20.1.4 заалт/ төлөх бө энэ нь мөн 10 хувь байна.

Хувь хүний албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т заасны дагуу даатгалын нөхөн төлбөр нь орлогын албан татвараас чөлөөлөгдөх орлогод тооцогддог тул хэрэв даатгалын тохиолдол үүсээд, хөрөнгө оруулагчид бондын төлбөрийг даатгалын нөхөн төлбөр хэлбэрээр авсан бол хөрөнгө оруулагч нь бондын хүүгийн орлогод ногдох татвараас чөлөөлөгдөнө.

## 2.8. Анхдагч зах зээлд байршуулах арилжаа

Тус арилжаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн /МХБ/ ТУЗ-ын 2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 2014/05 тоот тогтоолоор баталсан "Бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-н 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "МХБ ТӨХК-ийн арилжааны журам"-ын дагуу явагдана.

Олон нийтэд санал болгох 50,000 ширхэг бондыг анхдагч зах зээлд арилжих хугацаа нь ажлын 5-10 хоног байна. Бондын хугацаа 6 сар буюу 182 хоногоор, хүүний хэмжээг 365 хоногт үндэслэн тооцов.

Бондыг анхдагч зах зээлд хямдруулсан үнээр буюу нэгж бондын худалдах үнийг 9,155 төгрөг байхаар тогтоосон ба нийт 457,750,000 төгрөгийн хөрөнгийг босгохоор төлөвлөж байна. Бондын эргэн төлөлтийг хугацааны эцэст нэрлэсэн үнээр буюу нэгж хувьцааг 10,000 төгрөгөөр үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчдад төлнө.

Бондын арилжааг хэрэгжүүлэх үйл явц:

- 50,000 ширхэг, 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 500 сая төгрөгийн бондыг Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрөл гарч, Монголын Хөрөнгийн биржид бүртгэгдсэнээс хойш 2015 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн дотор анхдагч зах зээлд нэрлэсэн үнээр арилжаалахаар төлөвлөж байна.
- Бондыг анхдагч зах зээлд байршуулснаас хойш ажлын 15 хоног дотор анхдагч зах зээлийн арилжааг амжилттай хэрэгжүүлсэн тухай тайланг холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ.

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР ХОТ

**Бондыг арилжих болон Бондын төлбөрийн график**

*Зураг 13: Бондын нийтэд санал болгох хуваарь*




Бонд хадгалах, өмчлөх эрх бүртгэх ажиллагаа, бондын анхдагч болон хоёрдогч зах зээлд дээрх төлбөр тооцоог ҮЦТТТХТ ТӨХК хийж гүйцэтгэнэ.

Бондын эргэн төлөлтийг хийхэд үнэт цаас гаргагч нь графикт заасан төлбөрийг ажлын өдрийн 12.00 цагаас өмнө Хадгалагчийн буюу ҮЦТТТХТ дэх үнэт цаас гаргагчийн дансанд шилжүүлсэн бол ҮЦТТТХТ нь Т+0 хугацаанд, 12:00 цагаас хойш шилжүүлсэн бол Т+1 хугацаанд багтаан холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл Хадгалагч буюу ҮЦТТТХТ нь эргэн төлөлт хийгдэх өдрийг 12 цагаас өмнө төлбөрийг хүлээн авсан тохиолдолд тухайн өдрийн 14:00-16:30 цагийн хооронд төлбөрийг бонд эзэмшигчийн ҮЦТТТХТ ТӨХК дах бонд эзэмшигчийн дансанд шилжүүлнэ.

**Үнэт цаасыг худалдан авах**

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд Монгол улсын болон гадаадын аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн оролцох боломжтой бөгөөд арилжаанд оролцох байгууллага болон хувь хүн нь ҮЦТТТХТ-д үнэт цаасны данс нээлгэж арилжаанд оролцох боломжтой.

Үнэт цаасыг худалдан авахдаа өөрийн сонгосон брокерийн компанид үнэт цаас худалдан авах захиалга өгч үнэт цаас худалдан авах боломжтой.

Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох хөрөнгө оруулагчид Голомт Секюритиз ҮЦК дээр очиж үнэт цаасны дансаа нээлгэх боломжтой.

**Голомт Секюритиз ҮЦК**-тай холбогдох хаяг:

Утас: +976-70121530
Цахим хаяг: www.golomtsecurities.com

**ҮЦТТТХТ дах дансанд үнэт цаасны худалдан авах мөнгө шилжүүлэхдээ:**

Гүйлгээ хийх загвар:

| | |
|---|---|
| Хүлээн авах банкны нэр: | **ҮЦТТТХТ** |
| Хүлээн авах дансны дугаар: | **0120 0000 0XXX** /өөрийн брокерын компаниас 12 оронтой үнэт цаасны дансаа лавлаж асууна/ |
| Хүлээн авагчийн нэр: | **Овог Нэр** |
| Гүйлгээний утга: | **Эрчим бондын мөнгө** |

**Урьдчилсан санал**

"Тэтгэврийн Ууган Сан" ТББ /ТУС сан/ болон "Голомт банк" ХХК /Андеррайтер/ талуудын хооронд 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан Харилцан ойлголцлын санамж бичигт тусгагдсанаар ТУС сан нь Эрчим бондын анхдагч зах зээлийн арилжаанаас 200 сая төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг худалдан авах сонирхолоо илэрхийлсэн болно.

ТУС сантай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг **Хавсралт 3.9**-с үзнэ үү.

Мөн Эрчим бондын үндсэн андеррайтер болох Голомт Банк нь бонд гаргагч Эрчим Инженеринг ХХК болон уг бондыг даатгаж буй Соёмбо Даатгал компанийг тус тусад нь судлан шинжилж, банкны журмын дагуу холбогдох эрсдлийн түвшинг дүгнэж үзсэний үндсэн дээр энэхүү бондын анхдагч зах зээл дээр арилжигдсанаас үлдсэн хэсгийг өөрөө худалдан авах бүрэн боломжтой гэдгээ илэрхийлж байна. Энэ тухай холбогдох гэрээнд тусгасан болно.

## 2.9. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулах хөрөнгийн зарцуулалт, эдийн засаг үр ашгийн тооцоо

**Бонд гаргах шалтгаан**

“Эрчим-Инженеринг” ХХК нь эрчим хүчний салбарт зураг төсөл, зөвлөх үйлчилгээ, ЦДАШ, дэд станцын барилгын угсралтын ажлыг амжилттайгаар хийж гүйцэтгэж байна. Тус компанийн үйл ажиллагаа эрхэлж буй эрчим хүчний салбар нь төрийн зохицуулалтаас хамааралтай учир тендерийн ажлын санхүүжилт улсын төсвөөс хамааралтай байдаг ба энэ нь тендерийн ажлын санхүүжилт цаг хугацаандаа орж ирэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Иймээс барилга, угсралт бүтээн байгуулалтын ажлыг цаг хугацаанд дуусгах, зуны улиралд цаг алдалгүй тендерийн ажлыг явуулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

*ЦДАШ, ЦДШ, дэд станц барилга угсралтын ажиллагаа*

- “Эрчим-Инженеринг” ХХК нь жил бүр 4 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Энэ үеэр тендерийн ажлын санхүүжилт тасралтгүй байх шаардлагатай байдаг.

*Санхүү, төлбөр тооцоо*

- Жил бүр улсын төсвийн алдагдлаас хамааран тухайн оны тендерийн ажлын санхүүжилт 12 дугаар сар хүртэл хойшлох, цаашлаад дараа оны 1 дүгээр сар хүртэл хойшлох магадлалтай байдаг.

**Шийдэл**

Дээрх болзошгүй асуудлуудаас урьдчилан сэргийлэх, үүссэн ч түүний үзүүлэх нөлөө, үр дагаврыг бага байлгах арга зам нь бүтээн байгуулалтын ажлыг эрчимтэй хэрэгжүүлэх цаг үеийг алдалгүйгээр хүлээгдэж буй санхүүжилтийг богино хугацаатай **компанийн өрийн бичиг** гаргах замаар шийдвэрлэх боломжтой байна. . Арилжааны банкуудын богино хугацаат зээлийн хүү өндөр, барьцаа хөрөнгийн шаардлага тавигддаг тул төсөл хэрэгжүүлэгчдийн хувьд хөрөнгийн зах зээл дээр бонд гаргах замаар шаардлагатай санхүүжилтээ бүрдүүлэх нь Бас нэгэн боломжит шийдэл болж байна. Цаашилбал бондын хүү нь банкны зээлийн хүүгээс бага байх боложтой байгаа нь компанид ашигтай, нөгөө талдаа бондыг худалдан авч буй хөрөнгө оруулагчдын хувьд хадгаламж болон бусад хөрөнгө оруулалтын хэлбэрээс харьцангүй өндөр өгөөжтэй байгаа нь аль аль талдаа үр өгөөжтэй хувилбар болж байна.

**Бонд гаргагчийн 2015-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө**

“Эрчим Инженеринг” ХХК нь 2015 оны хувьд хэд хэдэн томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцож ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:

1. БНХАУ-н хөнгөлттэй зээлийн хүрээнд хийгдэж байгаа дараах ажлуудыг үргэлжлүүлэн хийж дуусган улсын комисст хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байгаа.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

*Хүснэгт 20 Тендерийн ажлын гүйцэтгэл*

| | Хийгдэх ажил | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | "Улаанбаатар" 220/110кв-ын дэд өртөө"-өргөтгөлийн ажил | 100% |
| 2 | VII хороолол 110кВ-н 14.8 км ЦДАШ-н барилга угсралтын ажил | 100% |
| 3 | VII хороолол 110/35/10кВ-н дэд өртөөний барилга угсралтын ажил | 90-95% |
| 4 | "МҮОНРТ 110кВ-н 8.4км ЦДАШ"-н барилга угсралтын ажил | 95% |
| 5 | "МҮОНРТ 110/35/10кВ-н " дэд өртөөний барилга угсралтын ажил | 90-95% |
| 6 | "YII хороолол 10кВ-н кабел шугам, ХТП, РП | 50% |
| 7 | "МҮОНРТ 10кВ-н кабел шугам, ХТП, РП | 3-5% |

Эх:үүсвэр "Эрчим-Инженеринг ХХК"

Төслийн нийт санхүүжилт 28,6 сая ам.доллар бөгөөд өнөөдрийн байдлаар 21,0 сая ам.долларын гүйцэтгэлийн санхүүжилт авсан. Үлдэгдэл 7,6 сая ам.долларын санхүүжилтээр дээрх ажлуудаас үлдсэн хэсгийг хийж гүйцэтгэх бүрэн боломжтой.

Гүйцэтгэгчээс үл шалтгаалах төрөл бүрийн саатал (газар чөлөөлөлт) гарахгүй тохиолдолд төслийг хэрэгжүүлж дуусгах боломжтой.

2. Франц улсын SCHNEIDER ELECTRIC компанитай хамтран Монгол улсад зай талбай бага эзэлдэг, шинэ технологи бүхий БИОСКО Б120Т маягийн ухаалаг дэд өртөөг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай олон улсын IEC 62271-2 хэсэг стандартыг эх хэлэнд орчуулж ЭХЯ болон ашиглагч байгууллага УБЦТС ТӨҮГ-аар хянуулж баталгаажуулсан. Одоогийн байдлаар уг стандартыг үндэсний стандарт болгох асуудлыг Стандарт хэмжил зүйн газарт тавьж баталгаажуулах үе шат дутуу байна. Энэхүү дэд өртөөний ажлын зураг мөн 90-95 хувьтай хийгдэж байна. Зураг төслийг улсын экспертизээр батлуулж төслийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдвэл 2015 онд нийт 20-25 дэд өртөөг үйлдвэрлэж зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа.

3. ДЦС-4 д 125000кВА хүчин чадал бүхий 110/10,5кВ-н трансформатор нийлүүлэх сонгон шалгаруулалтад холбогдох материалыг бүрдүүлж өгсөн.

4. ЦДҮС ТӨҮГ – с зарласан 40МВа хүчин чадал бүхий 110/35/6кВ-н трансформаторын тендерт уг трансформаторыг нийлүүлэх тендерийн ажилд саналаа өгсөн.

5. Дээрх сонгон шалгаруулалтаас гадна "Эрчим-Инженеринг" ХХК нь гадаадын хөрөнгө оруулалтаар хийх дараах төслүүдэд гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах саналаа явуулж байгаа. Үүнд:

- БНХАУ-н зээлээр санхүүжигдэх 320МВа н хүчин чадал бүхий Эгийн голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтад БНХАУ-н хөрөнгө оруулагчтай хамтран оролцохоор хэлэлцэж байна.
- "МАК" ХХК-ийн Нарийн Сухайтын нүүрсний уурхайг түшиглэн барих 270МВа-н хүчин чадал бүхий ДЦС-н төсөл дээр мөн БНХАУ-н хөрөнгө оруулагч компанитай хамтран ажиллахаар ажиллаж байна.

- “МАК” ХХК-ийн “Оюу Толгой”- “Цагаан Суварга” чиглэлд баригдах 160км 220кВ-н ЦДАШ-ийн барилга угсралтын ажлын тодорхой хэсгийг гүйцэтгэх талаар хэлэлцэж байна.

**Бондын зарцуулалт**

“Эрчим-Инженеринг” ХХК нь бондын санхүүжилтээр 450 сая орчим төгрөг босгох төлөвлөгөөтэй байна. Уг бондын хөрөнгөөр “Эрчим-Инженеринг” ХХК нь ажилчдынхаа цалин болон ажлыг гүйцэтгэхэд тохиромжтой цаг үед төслийн ажлыг гүйцэтгэх, түүнтэй холбогдон гарах зардлаа санхүүжүүлнэ. 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр төслийн ерөнхий гүйцэтгэгч “Бээжин констракшин ХХК”, туслан гүйцэтгэгч “ENCC” ХХК–руу 840 мянган ам.долларын төслийн санхүүжилтийг авах хүсэлтээ өгсөн. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээс хүссэн төслийн санхүүжилтийн орж ирэх хугацаа одоогоор тодорхойгүй байгаа учраас бондын санхүүжилтээр тендерийн, барилга угсралтын ажлыг идэвхтэй улиралд тасралтгүй санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна Бонд гаргагч нь уг тендерийн санхүүжилт бондын хугацааны туршид орж ирнэ гэж үзэж байгаа ба энэхүү санхүүжилтийн хугацааны эрсдлээс хамааралтай Бондын эргэн төлөлийн эрсдлийг даатгагч компани болох Соёмбо даатгал нь 100% батлан дааж байгаа болно.

**2015 оны эцэс хүртэлх борлуулалт, ашгийн таамаглал**

Ашгийн таамаглалыг 2015 оны 11 дүгээр сард урьдчилгаа төлбөрийг орж ирнэ гэсэн нөхцөл тавьж тооцооллыг хийж гүйцэтгэлээ.

*Хүснэгт 21 Эрчим Инженеринг ХХК-н 2015 оны ашгийн таамаглал*

| Орлогын тайлан | 1/1/2014<br>12/31/2014 | 1/1/2015<br>12/31/2015 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого ( цэвэр ) | 13,293,630,466 | 1,796,753,592 |
| Борлуулалтын өртөг | 11,368,404,239 | 139,011,136 |
| **Нийт ашиг (алдагдал )** | **1,925,226,227** | **1,657,742,456** |
| Түрээсийн орлого | - | - |
| Хүүгийн орлого | 2,722,686 | - |
| Ногдол ашгийн орлого | - | - |
| Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| Бусад орлого | 60,189,109 | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 2,259,796,759 | 406,063,026 |
| Санхүүгийн зардал | 54,361,946 | - |
| Цалингийн зардал | - | 897,997,961 |
| Түлш, шатахуун | - | 40,000,000 |
| Түрээс ашиглалт | - | 2,000,000 |
| Бусад зардал | - | 20,000,000 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз ) | 412,639,752 | 50,000,000 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | - 14,297,186 | - |
| Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз ) | - | - |
| Бусад ашиг ( алдагдал ) | - 50,377,680 | - |
| Бондын хүүгийн зардал | | 48,490,846 |
| Бонд босголтын зардал | | 40,000,000 |
| Элэгдлийн зардал | | 99,107,138 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )** | **21,944,204** | **460,146,511** |
| Орлогын татварын зардал | 8,661,907 | - |
| Татварын дараах ашиг ( алдагдал ) | 13,282,297 | - |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал ) | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )** | **13,282,297** | **460,146,511** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| Бусад олз ( гарз ) | - | - |
| Цэвэр ашиг | 13,282,297 | 460,146,511 |

Эх үүсвэр: Голомбанкны тооцоолол

СЭХ
он . сар . . . өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 2015 оны эцэс хүртлэх мөнгөн урсгалын таамаглал

*Хүснэгт 22: Мөнгөн урсгалын таамаглал*

| Мөнгөн Гүйлгээний Тайлан | 4/30/2015 | 5/31/2015 | 6/30/2015 | 7/31/2015 | 8/31/2015 | 9/30/2015 | 10/31/2015 | 11/30/2015 | 12/31/2015 | 1/31/2016 | 2/29/2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Үйл Ажиллагааны Мөнгөн Гүйлгээ** | | | | | | | | | | | |
| **Цэвэр ашиг** | (110,910,714) | (72,447,011) | (111,910,714) | (2,629,922) | (150,910,714) | (110,910,714) | 1,401,089,286 | (110,910,714) | (110,910,714) | (110,910,714) | 506,637,357 |
| **Тохируулга** | 469,834,158 | 5,834,410 | 22,164,634 | (51,317,206) | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | - |
| Биет Хөрөнгийн Элэгдэл | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | 9,910,714 | - |
| Биет Бус Хөрөнгийн Элэгдэл | | | | | | | | | | | |
| Ажлын капиталын өөрчлөлт | | | | | | | | | | | |
| Дансны авлага | | | | | | | | | | | |
| Дансны өглөг | | | | | | | | | | | |
| Бараа материал | | | | | | | | | | | |
| Урьдчилж гарсан зардал | (26,309,056) | 26,309,056 | (110,702,080) | 110,702,080 | - | - | - | - | - | - | - |
| Урьдчилж орсон орлого | 466,232,500 | (32,385,360) | 122,956,000 | (171,930,000) | - | - | - | - | - | - | - |
| **Нийт Үйл ажиллагааны Мөнгөн Гүйлгээ** | 358,923,444 | (66,612,601) | (89,746,080) | (53,947,128) | (141,000,000) | (101,000,000) | 1,411,000,000 | (101,000,000) | (101,000,000) | (101,000,000) | 506,637,357 |
| **Хөрөнгө Оруулалтын МГ** | | | | | | | | | | | |
| Барилга | | | | | | | | | | | |
| Тоног төхөөрөмж худалдан авах | | | | | | | | | | | |
| Дэд бүтцийн зардал | | | | | | | | | | | |
| Бусад зардал | | | | | | | | | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | | | | | | | | | |
| **Хөрөнгө Оруулалтын Мөнгөн Гүйлгээ** | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Санхүүгийн Мөнгөн Гүйлгээ** | | | | | | | | | | | |
| Хувьцаа нэмж гаргах | | | | | | | | | | | |
| Бондын санхүүжилт | - | - | - | - | 457,772,092 | - | - | - | - | - | - |
| Бондын эргэн төлөлт | - | - | - | - | - | - | - | - | - | - | (500,000,000) |
| Валютын ханшийн хэрэгжээгүй алдагдал | | | | | | | | | | | |
| Зээл | | | | | | | | | | | |
| Зээл(Эргэн төлөлт) | | | | | | | | | | | |
| **Санхүүгийн Мөнгөн Гүйлгээ** | - | - | - | - | 457,772,092 | - | - | - | - | - | (500,000,000) |
| **Мөнгөн Хөрөнгө** | | | | | | | | | | | |
| **Эхний** | 358,923,444 | (66,612,601) | (89,746,080) | (53,947,128) | 316,772,092 | (101,000,000) | 1,411,000,000 | (101,000,000) | (101,000,000) | (101,000,000) | 6,637,357 |
| Мөнгөн хөрөнгийн өөрчлөлт | 114,688,473 | 473,611,917 | 406,999,317 | 317,253,237 | 263,306,109 | 580,078,201 | 479,078,201 | 1,890,078,201 | 1,789,078,201 | 1,688,078,201 | 1,587,078,201 |
| **Эцсийн мөнгөн урсгал** | 473,611,917 | 406,999,317 | 317,253,237 | 263,306,109 | 580,078,201 | 479,078,201 | 1,890,078,201 | 1,789,078,201 | 1,688,078,201 | 1,587,078,201 | 1,595,715,557 |

## 2.10. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчдад учирч болох эрсдэлийн хүчин зүйлс

Макро болон Микро эдийн засгийн нөлөөлөлд аж ахуй үйл ажиллагаагаа буруу тооцоолох, макро орчны хүчин зүйлсийг дутуу үнэлэх нь компанийн үйл ажиллагаанд эрсдэлийг учруулна. Тус компанийн аж ахуйн үйл ажиллагаанд дараах төрлийн эрсдэл учирч болзошгүй. Зах зээлийн эрсдэлийг урьдчилан таамаглах төвөгтэй учир үнэ, макро орчны судалгаа, үнэ ханшийн талаар тогтмол судалгаа хийж байх шаардлагатай.

Макро эдийн засгийн нөлөөлөл, инфляци

- Татварын эрсдэл
- Тоног төхөөрөмжийн үнэ ханшийн эрсдэл
- Валютын ханшийн тогтворгүй байдал
- Харилцагч байгууллагуудын ажлын уялдаа холбооноос шалтгаалсан хүндрэл

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

**Байгаль, цаг уураас хамааралтай эрсдэл:**

Монгол улс нь эрс тэс уур амьсгалтай орон юм. Үүний улмаас барилга угсралт, ЦДАШ, дэд станцын барих зэрэг бүтээн байгуулалт нь хавар 4 дүгээр сараас намар 11 дүгээр сарын хооронд үргэлжлэх боломжтой юм. "Эрчим-Инженеринг" ХХК-ийн үйл ажиллагаа нь зуны улиралд эрчимтэй байдаг ба өвөл улирлын нөлөөнөөс шалтгаалж сул зогсолттой байдаг. Мөн зуны улиралд байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас ажлын төлөвлөгөө хойшлох, цаг хугацаа алдах эрсдэлүүд үүсэж болзошгүй.

**Компанийн үйл ажиллагааны эрсдэл**

*Тус компанийн ажлын гүйцэтгэлийн чанарын эрсдэл*

Компанийн ажлын гүйцэтгэлийг захиалагч нь ажлын явцын дунд болон ажлын гүйцэтгэлийг бүрэн хийгдсэн үед үнэлэн санхүүжилтийг гүйцэтгэл дээр тулгуурлан өгдөг. Компани нь 19 жилийн туршид үйл ажиллагаагаа явуулж буй туршлагатай компани юм. Дотоодын үйл ажиллагаа болоод ханган нийлүүлэгчийн тоног төхөөрөмжийн чанар, тээвэрлэлтийн үеийн гэмтэл зэрэг гадаад хүчин зүйлсээс хамааран ажил, үйлчилгээний гүйцэтгэлд чанарын эрсдэл учирах боломжтой.

*Компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл*

- Салбарын нийтлэг сул тал болох эцсийн захиалагч буюу тендер зарлагч /эсвэл одоогийн тохиолдолд бол Ерөнхий гүйцэтгэгч/-аас шалтгаалан санхүүжилт хойшлогдох, цаг хугацаандаа төлбөрөө төлөхгүй байх зэргээс үүдэлтэй өрийн сүлжээ үүсэх, үйл ажиллагаа доголдох;
- Ажил үйлчилгээ захиалагч, хүлээн авагч нь ихэнх тохиолдолд бараа, үйлчилгээ худалдан авах тендер зарлан, нээлттэй сонгон шалгаруулалт хийх журмаар ажил, үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулдаг. Энэ нь компанид өрсөлдөөний улмаас ажил, үйлчилгээний хөлсийг бууруулах, улмаар төлөвлөсөн борлуулалтын хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлийг бий болгох;
- Валютын ханшны тогтворгүй байдал нь санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөөлж байна. Импортын бараа, тоног төхөөрөмжийн үнэ валютын ханшийн өсөлтийн улмаас компанийн санхүүгийн төлөвлөгөө, төсөв гэнэтийн алдагдалд орох;
- Сэлбэг материал, шугам, сүлжээний материалын үнэ огцом өссөнөөс төсөвлөсөн зардал хэтэрч, ашиг буурах;
- Зардлын өсөлтийн улмаас үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийн дутагдалд орох;
- Улс орны эдийн засгаас шалтгаалж төсвийн санхүүжилт хойшлох зэрэг эрсдэл учирч болохоор байна.

*Хүний нөөц, удирдлагын үйл ажиллагааны эрсдэл*

Мэргэжлийн түвшинд үйл ажиллагааг явуулж, удирдлагаар хангах нь харилцагч, худалдан авагч, захиалагч нараа алдах улмаар зах зээл дээрх нэр хүндээ алдах зэрэг эрсдэлээс хамгаалж байдаг. Удирдлагын ажлын чиг, баг бүрдүүлэлт хүний нөөцийн асуудлаас шалтгаалан компанийн борлуулалт, мөнгөн урсгал буурах эрсдэл учрах боломжтой.

**Улс төрийн бодлого, шийдвэрийн эрсдэл**

Засгийн газрын нийгэм эдийн засаг хэрэгжүүлж буй бодлого шийдвэрүүд компанийн үйл ажиллагаа , тендерийн ажил, борлуулалтанд нөлөөлөх магадлалтай. Тухайлбал:

- Төр засгийн тогтворгүй байдлаас шалтгаалж салбарын хууль эрх зүйн орчинд өөрчлөлт орох;
- Байгуулагдсан тендер, концессийн гэрээ цуцлагдах;
- Эдийн засгийн хямралын улмаас төрөөс хийх салбарын хөрөнгө оруулалт буурах, санхүүжилт зогсох;
- Иргэдийн нийгмийн халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого нь улсын төсвийн зардлыг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, үүнтэй
- холбоотой татварын хувь хэмжээнд өөрчлөлт орох.

Мөн татварын орчинд гарсан аливаа өөрчлөлт нь хөрөнгө оруулагчдад очих цэвэр өгөөжид нөлөөлөх боломжтой. Энэхүү бондын хугацааны туршид татварын эрсдэл гарах магадлал хамгийн бага гэж үзэж байна.

**Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбогдон үүсэж болох эрсдэл**

Монголын хөрөнгийн зах зээл нь 1991 оноос төрийн өмчит компаниудыг хувьчлаж 1995 онд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлснээр хөгжих эхлэл нь тавигдсан. 2000 оноос Засгийн Газар нь ЗГҮЦ, 2001 оноос компаниуд компанийн бонд, 2005 оноос хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд компанийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх замаар хувьцаат компани болж шинээр хувьцаа гарган олон нийтээс санхүүжилт татаж эхэлсэн. 2005 оноос хойш нийт 8 компанийн бондыг нээлттэй арилжаагаар Монголын хөрөнгийн бирж дээр гарган нийт 7.01 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнээс сүүлийн 3 жил буюу 2012 оноос хойш компанийн бонд арилжигдаагүй байна. Компанийн үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр гадаад, дотоодын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлаас үүдэн шинээр гаргаж буй бондын үнэ ханш буурах, борлогдохгүй байх эрсдэлтэй.

**Төлбөрийн чадварын эрсдэл**

Бонд гаргагч нь бондын үндсэн төлбөрийн цаг хугацаанд нь төлж чадахгүй байх магадлалтай. Энэхүү эрсдэлийг даатгалын гэрээгээр шийдвэрлэж байгаа болно.

**Бусад эрсдэл**

Мөнгөний үнэгүйдлээс шалтгаалж хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй бондын бодит үнэ цэнэ, хүүгийн бодит орлого буурах эрсдэл байдаг. Энэхүү эрсдэлийг таамаглах, бууруулах, эрсдэлээс зайлс хийхэд хүндрэлтэй байдаг. Дээр дурдсан эрсдэлүүд нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөнөөс хамааран учирж болох эрсдэлүүд юм.

## ГУРАВ. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

3.1. ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР
3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР, ТЕНДЕРИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ХҮСЭЛТ
3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДҮРМИЙН ХУУЛБАР
3.4. САНХҮҮГИЙН ТАЙЛАН - ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК
3.5. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ
3.6. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
3.7. БИЕ ДААСАН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН
3.8. АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ
3.9. "ТЭТГЭВРИЙН УУГАН САН" ТББ БОЛОН "ГОЛОМТ БАНК" ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ
3.10. БОНДЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

## 3.1. ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК – ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

# Эрчим Инженеринг ХХК

## ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

2015 оны 7 дугаар сарын 01 ны өдөр | № 07 / 15 | Улаанбаатар хот

Бонд гаргах тухай

"Эрчим инженеринг" ХХК нь компанийн хэрэгжүүлж байгаа болон цаашид хэрэгжих төслүүдийн санхүүжилтын эх үүсвэрийг бий болгох, байгууллагын мөнгөн урсгалыг сайжруулах зорилгоор "Компанийн тухай хууль"-ийн 41 (Компанийн өрийн бичиг), 42 (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), 43 (Хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг тогтоох), 62 (хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрх) дугаар зүйл, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 5 (Үнэт цаас), 7 (Үнэт цаас гаргагч) дугаар зүйлийг удирдлага болгон шийдвэрлэх нь:

1. Нийт 500,000,000 төгрөгийн үнэ бүхий хэсэгчлэн төлөгдөх бондыг "Эрчим бонд" нэрээр, 1 дүгээр Хавсралтад заасан нөхцөлөөр олон нийтэд нээлттэй санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй.

2. Үнэт цаас эзэмшигчийн эрх, үнэт цаас гаргагчийн үүргийг 2 дугаар Хавсралтаар баталсугай.

3. Бонд гаргахтай холбоотой ажлыг удирдан зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Н.Баярмагнайд, бонд гаргахтай холбогдуулан Даатгалын гэрээ байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд аудит, хөрөнгийн үнэлгээний тайлан хийлгэх зэрэг бонд гаргахтай холбогдсон зардлыг тооцож оролцогч талуудтай байгуулсан гэрээний дагуу зарцуулахыг нягтлан бодогч Б.Шинэзаяад, бусад холбогдох материалыг бүрдүүлэхийг хүний нөөцийн мэргэжилтэн Б.Мэнд-Амар нарт тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ /М.БАТБОЛД/

СЭХ БҮРТГЭВ № 01

Хувьцаа эзэмшигчийн 2015 оны 7-р сарын 01-ны

өдрийн 07/15 тоот шийдвэрийн 1 дүгээр Хавсралт

**"Эрчим Бонд"-ын Ерөнхий Нөхцөл**

| | |
|---|---|
| Бондын төрөл | Хямдруулсан үнэтэй |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 10,000 төгрөг |
| Нийт ширхэг | 50,000 ширхэг |
| Нийт үнийн дүн | 500,000,000 төгрөг |
| Бондын хугацаа | 6 сар |
| Хүүгийн хэмжээ | Жилийн 18.50% |
| Хүү төлөх хугацаа | Хугацааны эцэст төлөгдөх |
| Эргүүлэн авах нөхцөл | |
| Бонд гаргах зорилго | Тендерийн эхлэн гүйцэтгэл, төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| Бондын баталгаа | Бондын Даатгалаар 100% даатгагдсан |
| Бондын андеррайтер | "Голомт банк" |
| Бонд эзэмшигчдийн бүртгэл, төлбөр тооцооны хадгаламж | "Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн төв" ТӨХХК |
| Бонд арилжих зах зээл | Монголын Хөрөнгийн биржийн арилжаагаар дамжуулах олон нийтэд нээлттэй арилжаалах |

Хувьцаа эзэмшигчийн 2015 оны 7-р сарын 01-ний

өдрийн 07/15 тоот шийдвэрийн 2 дугаар Хавсралт

**ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ**

1. **Үнэт цаас эзэмшигчийн эрх**

Бонд эзэмшигч нь дараах эрхтэй байна. Үүнд:

1.1. Бонд эзэмшигч нь дараах бичиг, баримтууд болон мэдээллийг шаардах эрхтэй үүнд:
    - Компанийн улирлын санхүүгийн тайлантай танилцах
    - Бондын хоёрдогч зах зээлийн үнийн мэдээг хүлээн авах
    - Бондын хоёрдогч зах зээлийн арилжааны саналыг хүлээн авах

1.2. Бонд эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй бондыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах,

1.3. Хугацааны эцэст бондыг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, эсвэл хугацааны эцэст бондын даатгагчийг бондын эргэн төлөлтийг хийхийг шаардах болон Монгол улсын хуульд заасан бусад холбогдох хууль, журамд заасан эрхүүдийг эдэлнэ.

2. **Үнэт цаас гаргагчийн үүрэг**

2.1. Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлнэ.

2.2. Үнэт цаас гаргагч нь Бонд борлуулснаас орсон орлогыг зөвхөн Андеррайтерын гэрээнд тусгагдсаны дагуу зарцуулна.

2.3. Үнэт цаас гаргагч нь бондыг нэрлэсэн үнээр хугацааны эцэст хөрөнгө оруулагчаас буцаан худалдаж авна.

2.4. Үнэт цаас гаргагч нь Бондын даатгалын гэрээний дагуу даатгагчийн өмнө үүрэг хүлээнэ.

2.5. Үнэт цаас гаргагч нь бондын төлбөрийг бондын хугацаанд хөрөнгө оруулагчидад төлөх. Энэхүү үүргийг биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

3. **Бонд эзэмшигчид мэдээлэл хүргэх үүрэг**

Эрчим бондыг худалдан авсан хөрөнгө оруулагчид нь дараах сувгуудаар Компанийн үйл ажиллагааны сүүлийн үеийн мэдээлэл, тайлбарыг авна.

3.1. Эрчим Инженеринг ХХК нь өөрийн веб сайт (www.erchim.mn)-аар дамжуулан компанийн үйл ажиллагаа, бондын хоёрдогч зах зээлийн арилжааны мэдээллийг хөрөнгө оруулагчидад нээлттэйгээр байршуулах үүрэгтэй.

3.2. Андеррайтер нь бонд эзэмшигчийн электрон шуудангийн хаягаар бондын хоёрдогч зах зээлийн саналыг хүргэх үүрэгтэй.

4. **Даатгагчийн хүлээх үүрэг**

4.1. Даатгалын тохиолдол бий болсон үед нөхөн төлбөрийг бондын эргэн төлөгдөх заасан хугацаанд Даатгуулагчийн нэрийн өмнөөс хөрөнгө оруулагчидад ҮЦТТТХТ-өөр дамжуулан шилжүүлэх үүрэгтэй.

4.2. Даатгалын зах зээлийн, хууль тогтоомж, даатгалын нөхцөл, өөрийн санхүүгийн чадавхийн талаарх бүрэн, үнэн зөв мэдээллийг Андеррайтерт тухай бүрт өгнө

## 3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ, ЗӨВШӨӨРӨЛ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР, ТЕНДЕРИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ХҮСЭЛТ

МОНГОЛ УЛС
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

Дугаар 165/13

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн

Улаанбаатар аймаг/нийслэлийн Баянгол сум/дүүргийн "Эрчим-Инженеринг" ХХК -д РД 2571676

03.2.5 заалтын дагуу

ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2013 оны 06 -р сарын 19 өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгов.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД М.Сономпил

2013 оны 06 -р сарын 19 өдөр
Улаанбаатар хот

**Ажил үйлчилгээний төрөл**

03.2.5. 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

**Нэмэлт өөрчлөлт:**

03.5.2 0.7-40.0 кгх/см² даралттай шугам хоолой, ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

Сайд . . . . . . . . . . . . . . . . . . . / М.Сономпил /

2014 оны 02-р сарын 26 өдөр

**СУНГАЛТ:**

. . . . . оны . . . . -р сарын . . . . өдрөөс эхлэн . . . . жилийн хугацаатай сунгав.

Сайд . . . . . . . . . . . . . . . . . . . / /

. . . . . оны . . . . -р сарын . . . . . өдөр

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000103505

2006 01 25
/ Бүртгэсэн он сар өдөр /

9011023073
/ Улсын бүртгэлийн дугаар /

2571676
/ Регистрийн дугаар /

Эрчим-Инженеринг Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр
/ шийдвэрийн нэр /

01
/ дугаар /

1999.03.09
/ он, сар, өдөр /

4610 Гадаад худалдаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4329 Эрчим хүчний тоног төхөөрөмж засвар,угсралт,тохируулга,туршилт /2013.06.19-2016.06.19/

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй
/ хугацаа /

1
/ эзэмшигчийн тоо /

10,000.00
/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мөнгөн төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, 10-р хороолол, 15, 16 тоот Утас1: 99114227, Утас2 , Факс
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

*Гэрчилгээ дахин олгосон 2015 он 6 сар 18 өдөр*

### Харилцах дансны бүртгэл

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан тэмдэг |
|---|---|---|---|
| Голомт банк | Валютын | 110207226 | Г.Мягмар |
| Худалдаа хөгжлийн банк | Валютын | 495054596 | Д.Чулуунтуяа |
| Чингисхаан банк | Төгрөгийн | 3920010197 | Д.Чулуунтуяа |
| Чингисхаан банк | Валютын | 3920040197 | Д.Чулуунтуяа |
| Голомт банк | Төгрөгийн | 1102026278 | Г.Мягмар |
| Голомт банк | Валютын | 1102769255 | Г.Мягмар |
| Худалдаа хөгжлийн банк | Төгрөгийн | 495054595 | Д.Чулуунтуяа |

### Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Мягбал овогтой Батболд-г Захирал-р томилсныг бүртгэв. | 2006.01.25 | Г.Мягмар |
| 2 | Дахин гэрчилгээ олгов | 2015.06.16 | Г.Аймаржавхлан |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

0000291

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ЗТП-294/12

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Баянгол сум/дүүргийн " Эрчим-Инженеринг " ХХК-д

9011023073 /улсын бүртгэлийн дугаар/

2571676 /регистрийн дугаар/

Зураг төсөл : 1.3.1, 1.3.2, 1.3.4, 1.3.5, 1.3.6. заалтын дагуу ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 05 дугаар сарын 07 -ны өдрөөс ГУРВАН жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Ц.ДАШДОРЖ

2012 оны 05 дугаар сарын 07 өдөр
Улаанбаатар хот

СЭХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

СУНГАЛТ

..... оны ....-р сарын .... хүртэл сунгав.

Сайд ................ Ц.ДАШДОРЖ

*Ажил үйлчилгээний төрөл:*

I.3.I. Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг

I.3.2. Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

I.3.4. Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг / 220 КВ хүртэл /

I.3.5. Усны барилга байгууламжийн зураг төсөл

I.3.6. Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл

*Нэмэлт өөрчлөлт:*

Сайд ................ Ц.ДАШДОРЖ

..... оны ....-р сарын .... өдөр

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг: Гутал ХК-ийн 8-р давхар, Чингисийн өргөн чөлөө.

Компанийн захирал /эзэн/ Н.Баярмагнай (Гарын үсэг)

Утас: 348256, 342396 Факс: 976-11-342336 E-mail: ....................

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

БАТЛАВ "ENCC" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.ГАНЗОРИГ

БАТЛАВ "ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ"ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
М.БАТБОЛД

**УБ ХОТЫН УБ-220/110/35кВ-н ДЭД ӨРТӨӨНИЙ ӨРГӨТГӨЛ, 7-Р ХОРООЛОЛ, МҮОНРТ-ИЙН 110/35/10кВ-ЫН ДЭД ӨРТӨӨ, 110кВ-н ЦДАШ, ХОРООЛОЛ ДУНД ОРШИХ 10кВ-н ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЕРӨНХИЙ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

Дугаар **БЗА-2010/55-ИШС/ТГ-05**

2012 оны 03 дугаар сарын 07 -ны өдөр — Улаанбаатар хот

Нэг талаас 5404894 тоот регистрийн дугаар, 9011252023 тоот улсын бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээтэй Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо Алтайн гудамжны Start төвд байрлах "ENCC" ХХК-ийг төлөөлж Ерөнхий нягтлан бодогч Л.Анхбаяр /цаашид Ерөнхий туслан гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 2571676 тоот регистрийн дугаар 9011023073 тоот улсын бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээтэй "Эрчим инженеринг"ХХК-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Н.Баярмагнай /цаашид Туслан гүйцэтгэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг: Гэрээний ерөнхий нөхцөл**

1.1 Энэхүү гэрээний зорилго нь УБ хотын **УБ ХОТЫН УБ-220/110/35кВ-н ДЭД ӨРТӨӨНИЙ ӨРГӨТГӨЛ, 7-Р ХОРООЛОЛ, МҮОНРТ-ИЙН 110/35/10кВ-ЫН ДЭД ӨРТӨӨ, 110кВ-н ЦДАШ, ХОРООЛОЛ ДУНД ОРШИХ 10кВ-н ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ** /цаашид гэрээт ажил гэх/-ыг Туслан гүйцэтгэгч нь гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д заасан Ерөнхий гүйцэтгэгчийн тодорхойлсон тоо хэмжээ, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөх, гүйцэтгэсэн ажлын төлбөрийг энэ гэрээгээр тохиролцсон нөхцлийн дагуу барагдуулах, Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

**Хоёр. Гэрээний үнэ, хугацаа**

2.1 Туслан гүйцэтгэгч тал гэрээт ажлыг 2012 оны 04 дугаар сарын 10 –аас 2013 оны 10 дугаар сарын 30-ны хооронд захиалагчийн баталгаажуулсан ажлын хугацааны графиктай уялдуулан цаг хугацаа, чанарыг хатуу баримтлах нөхцөлтэйгээр гүйцэтгэх болно.

2.2 Туслан гүйцэтгэгч нь гэрээгээр гүйцэтгэх ажлыг нийт **28 609 946,15** / Хорин найман сая зургаан зуун есөн мянга есөн зуун дөчин зургаан ам.доллор 15/ цент-р тооцож гүйцэтгэгч талд төлөхөөр тохиролцлоо.

Энэхүү ажлын холсөнд Барилгын тухай хуулийн 23-р зүйлийн 23.1-д заасан магадлашгүй ажлын зардал, НӨАТ багтсан болно.

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ

СЗХ БҮРТГЭВ №01

**Гурав. Гүйцэтгэл хүлээж авах болон төлбөрийн нөхцөл**

3.1. Туслан гүйцэтгэгч нь гэрээт ажлын 10-аас доошгүй хувийг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж баталгаажуулсны дараа эхний төлбөрийг авах эрхтэй болно. Дараагийн төлбөрийг нийт ажлын 30-аас доошгүй хувийг гүйцэтгэсний дараа төлнө. Үлдсэн төлбөрийг хийгдсэн ажлын гүйцэтгэлээр төлнө.
3.2. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлээ гарган холбогдох бичиг баримт, акт, зургаар баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ерөнхий гүйцэтгэгчээс уг ажлын төлбөр "ENCC"ХХК-ийн дансанд орж ирмэгц ажлын 5 хоногийн дотор санхүүжилтийг олгоно.
3.3. Ерөнхий туслан гүйцэтгэгч тал туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг чанарын шаардлага хангаагүй гэж үзвэл гарсан зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төлбөрийг олгохгүй байх эрхтэй.
3.4. Гэрээт ажлыг дуусган улсын комисст хүлээлгэн өгсний дараа гэрээгээ дүгнэснээр эцсийн санхүүжилт хийгдэнэ.
3.5. Ерөнхий туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажлын нийт санхүүжилийн 5%-ийг гүйцэтгэлийн баталгаа болгон үлдээж авах ба ажлаа дуусган улсын комисст хүлээлгэн өгсний дараа авсан энэ барьцаа хөрөнгийн 50%-ийг буцаан олгох ба үлдсэн 50%-ийг нэг жилийн дараа хүлээлгэн өгсөн обьектод зөрчил гараагүй бол гүйцэтгэгчид буцаан олгоно. Үлдсэн хугацаанд ашиглалтын бус буруугаас зөрчил гарвал гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засварлах үүрэг хүлээнэ.
3.6. Гүйцэтгэлийг Сангийн яамнаас баталсан гүйцэтгэл гаргах маягтын дагуу гаргаж ирүүлнэ.
3.7 Ажлын гүйцэтгэлийн явцад хугацаа алдсан, талбайн цэвэрлэгээ хийгээгүй тохиолдолд тухайн гүйцэтгэсэн ажлын төлбөрийг тухайн дутуу хийгдсэн ажлын тоо хэмжээ, байдлаас шалтгаалан дутуу тооцож төлбөр хийж болох ба хугацааны алдагдлыг засаж нөхсөн тохиолдолд уг суутган авсан төлбөрийг буцаан олгож болно. Харин алдаагаа засаагүй тохиолдолд суутган авсан энэхүү төлбөрийг олгохгүй.
3.8 Ерөнхий гүйцэтгэгчийн ажлын хугацааны график, ажил дуусгах хугацаа нь туслан гүйцэтгэгчээс хамааралгүй шалтгаанаар өөрчлөгдсөн тохиолдолд энэ гэрээг шинэчлэгдсэн ажлын графикийн хугацаагаар сунгана.

**Дөрөв. Ерөнхий туслан гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

4.1. Барилгын ажил эхлэх зөвшөөрөл, улаан шугам тавьсан акт, хийх ажлын зураг болон бусад холбогдох баримт бичгийг гэрээ байгуулсан өдөр гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.
4.2. Гэрээт ажлын явц, чанарт холбогдох мэргэжлийн инженер, зургийн зохиогч, захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөгчөөр хяналт тавиулж, далд ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна.
4.3.Техникийн нөхцлийн хугацаа дуусах буюу өөрчлөгдвөл түүнийг дахин шинэчилж зураг төсөлд тусгуулах, угсралтанд хэрэглэх материал, суурилагдах технологийн тоног төхөөрөмжийг ажлын хугацааны графиктай уялдуулан нийлүүлнэ.
4.4.Ажлыг далдлах талаар туслан гүйцэтгэгчээс өгсөн мэдэгдлийг авсанаас хойш нэг хоногийн дотор ерөнхий гүйцэтгэгч, захиалагчийн хамт газар дээр нь очиж үзэж далд ажлын актыг баталгаажуулна.
4.5. Зураг төсөл, барилгын норм ба дүрэм, стандартыг зөрчсөн, чанарын гологдол гаргасан, санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, материал, тээвэр, механизмын зардал, үнийн зөрүүг буруу тооцсон зэрэг тохиолдолд Ерөнхий туслан гүйцэтгэгч нь эрх бүхий байгууллагаар хяналт хийлгэх, торгууль ногдуулах,

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

гарсан хохирол, зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээг цуцлах эрхтэй.
4.6 Тухайн үе шатны ажлын гүйцэтгэл тус бүрийг хянаж, ажлын гүйцэтгэлийн акт бичилцэж хүлээлцэх, ажлын явцад угсралтын ажлыг технологийн дагуу чанартай гүйцэтгэж байгаад хяналтын инженер болон тухайн үед томилсон ажилтнаар дамжуулан хяналт тавиулж шаардуулах эрхтэй.
4.7 Зураг төслийн норм ба барилгын ажлын технологи зөрчсөн, чанарын гологдол гаргасан тохиолдолд алдааг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, засахгүй бол ажлыг зогсоох, гэрээт ажлыг гүйцэтгэх боломжгүй болсонг нотолсон тохиолдолд гэрээг дангаар цуцалж талбайд оруулахгүй байх, гүйцэтгэгчийн машин механизм, тоног төхөөрөмжийг хохиролд суутгах зориулалтаар ажлын талбайгаас гаргахгүй байх эрхтэй.
4.8 Зураг төслийн норм ба барилгын ажлын технологи зөрчсөн, чанарын гологдол гаргасан түүнийгээ анхны шаардлагаар засаагүй тохиолдолд эрх бүхий байгууллагаар экспертиз хийлгэх, торгууль ноогдуулах, гарсан хохирол, зардлыг гүйцэтгэгчээр төлүүлнэ.

**Тав. Туслан гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

5.1 Гэрээт ажлыг баталгаажсан зураг төсөл, барилгын норм ба дүрэм, стандартын дагуу чанартай барьж энэхүү гэрээнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан ашиглалтад оруулан улсын комисст хүлээлгэн өгнө.
5.2.Буруу буюу дутуу хийсэн ажлаа тухай бүр өөрийн хөрөнгөөр засч гүйцээн, ажлын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгахын хамт угсарсан бүх ажилд туршилт тохируулга хийж найдвартай ажиллагааг нь хангана.
5.3.Гэрээт ажлаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5.4. Гэрээт ажилд нийлүүлэгдэж байгаа материал, тоног төхөөрөмжийн чанарын баталгаа, сертификатыг бүрэн байлгах ба үе шатны ажил бүрд хэрэглэж байгаа материал, бетоны маркийг мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэн актаар баталгаажуулна.
5.5.Барилга, байгууламжийн чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад өөрийнх нь буруутай үйл ажиллагааны улмаас зөрчил илэрвэл түүнийг өөрийн хөрөнгөөр засна.
5.6.Гэрээт ажлын гүйцэтгэлийн зургийг үнэн зөв гаргаж, ажлын үе шат бүрээр ил далд ажлын актуудыг баталгаажуулж, гүйцэтгэлийн ажлын явцыг видео болон фото зургаар баталгаажуулна.
5.7. Далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон бусад холбогдох бичиг баримтыг ерөнхий гүйцэтгэгчид бүрэн гүйцэд хүлээлгэн өгнө.
5.8. Гүйцэтгэж байгаа объект дээрхи хөдөлмөр зохион байгуулалт, талбайн зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалалт, аюулгүй ажиллагааг бүрэн хариуцана.
5.9. Гүйцэтгэгч одоо байгаа байгууламжаар дайруулан өнгөрүүлэх, зам болон үерийн хамгаалалтын байгууламж сэтлэх, цахилгаан холбоо,дулаан, цэвэр, бохир усны шугам огтлох зэрэг ажил гүйцэтгэхэд шаардагдах бүх төрлийн тусгай зөвшөөрлийг өөрийн зардлаар авна.
Энэ заалтад ажиллаж байгаа бүх төрлийн шугам сүлжээг түр таслах, түр зам гаргах, ажиллаж байгаа албан газруудын эзэмшлийн талбайд ажил гүйцэтгэх зөвшөөрлүүд хамаарна.

СЗХ БҮРТГЭВ №01

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРИН ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

5.10. Барилга угсралтын явцад зам, талбай, гүүр, хаалт, хашаа барьж байгуулах зардал болон тухайн үед түр хэрэглэх цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч, ус болон бусад бүх зардлуудыг бүрэн хариуцна.
5.11. Туслан гүйцэтгэгч нь Ерөнхий туслан гүйцэтгэгчээс нийлүүлэх бараа материал, тоног төхөөремжийг Ерөнхий туслан гүйцэтгэгчийн складнаас өөрийн тээврийн хэрэгслэл, кран, машин механизмыг ашиглан хүлээн авч тэр мөчөөс эхлэн уг бараа материал, тоног төхөөремжийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.
5.12.Энэхүү гэрээгээр тохирсон үнэ болон хугацаа нь эцсийн байх бөгөөд гүйцэтгэсэн ажлын өртөг нь энэ үнээс давсан нөхцөлд дутагдах хөрөнгийг гүйцэтгэгч өөрөө хариуцан санхүүжүүлнэ.
5.13. Гэрээнд тусгагдаагүй ажил гарсан тохиолдолд тухай ажлыг гүйцэтгэх төсвийг гарган захиалагчаар хянуулан санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлнэ.
5.14. Барилгын ажлын журналыг баталгаажуулан өдөр бүр тэмдэглэл хийж ажлын явцад өгсөн үүрэг, биелэлтийг гаргаж баталгаажуулах үүрэгтэй.

**Зургаа. Ерөнхий туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн харилцан хүлээх үүрэг**

6.1. Гэрээний талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гарах зардлыг аль буруутай тал хариуцна.

6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлж чадаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0.3 хувиар буруутай талдаа алданги ноогдуулна.

Гэхдээ нийт алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

Алданги төлсөн нь үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөх үндэс болохгүй.

6.3. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон маргаантай асуудлыг аль болох эвийн хэлцлийн аргаар шийдвэрлэх ба энэ нь эцсийн шийдвэрт хүрч чадахгүй бол уг асуудлыг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ. Шүүхийн шийдвэр нь талуудын баримтлах эцсийн шийдвэр байх болно.

6.4. Чанарын баталгаат хугацаа ашиглалтад орсноос хойш – 3 жил байна.

**Долоо. Бусад зүйл**

7.1. Энэхүү гэрээ нь гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7.2. Энэхүү гэрээг 2012 оны 03 дугаар сарын 07 -ны /ний/ өдөр хоёр хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч тус бүр нэг нэг хувийг хадгална.

7.3. Талууд энэхүү гэрээний нэмэлт, гэрээний тусгай нөхцлүүдийг тухайн үед хийгдэх ажлын тоо хэмжээ, ажлын график зэргээс хамааран нэмэлт хийнэ.
7.4. Талуудын харилцах хаяг:

| | | | |
|---|---|---|---|
| Утас: | 88114799, 99994497 | Утас: | 99114904 |
| Факс: | | Факс: | 342336 |
| Цахим шуудан: | ganzorig.t@encc.mn | Цахим шуудан: | Magnai.nb@erchim.mn |

ХУВЬЦААТ КОМПАНИ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

7.5. Гэрээний хавсралтууд :

Хавсралт 1- Ажлын тоо хэмжээ,
Хавсралт-2- Ажил гүйцэтгэх график
Хавсралт-3- Ажлын төсөв

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ЕРӨНХИЙ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛЖ: | ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| "ENCC" ХХК-ны Ерөнхий нягтлан бодогч | "Эрчим инженеринг"ХХК-ийн Гүйцэтгэх захирал |
| ......................./ Л. Анхбаяр / | ........................./Н.Баярмагнай/ |
| | Хангамжийн менежер |
| | ......................../Б.Цолмон/ |

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР

СЭХ
БҮРТГЭВ

Хавсралт-2 МҮОНРТ хороололд төсөл хэрэгжүүлэх ажлын ерөнхий график

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Ажлын тоо хэмжээ хувиар (%) | 2012 онд хийгдэх ажлын хувь хэмжээ (%) | 2013 онд хийгдэх ажлын хувь хэмжээ (%) |
|---|---|---|---|---|
| 1 | МҮОНРТ 110кВ-ын ЦДАШ | | | |
| | Фундаментын нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Фундаментын угсралт | 100 | 85-90 | 10-15 |
| | Тулгуурын нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Тулгуурын угсралт | 100 | 85-90 | 10-15 |
| | Утас, холбох хэрэгслийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Утас, холбох хэрэгслийн угсралт | 100 | 0 | 100 |
| 2 | МҮОНРТ 110/35/10кВ-ын "Телевиз хороолол" дэд станц | | | |
| | Анхдагч хэлхээний цахилгаан тоноглолын нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Анхдагч хэлхээний цахилгаан тоноглолын угсралт | 100 | 80 | 20 |
| | Хоёрдогч хэлхээ ба реле хамгаалалтын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 20 |
| | Хоёрдогч хэлхээ ба реле хамгаалалтын тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 80 | 20 |
| | Диспетчерийн холбооны тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 80 | 20 |
| | Диспетчерийн холбооны тоног төхөөрөмжийн нийлүүлэлт угсралт | 100 | 80 | 20 |
| | ХХБ 110кВ-ын байрны барилгын ажил | 100 | 90 | 10 |
| | ХХБ 110кВ-ын байрны цахилгаан тоног төхөөрөмжийн нийлүүлэлт угсралт | 100 | 90 | 10 |
| | ХХБ 10, 35кВ-ын болон удирдлагын байрны барилгын ажил | 100 | 100 | 0 |
| | ХХБ 10, 35кВ-ын болон удирдлагын байрны тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | ХХБ 10, 35кВ-ын болон удирдлагын байрны тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 10 | 90 |
| | Байгууламжийн жижүүрийн байрны барилгын ажил | 100 | 100 | 0 |
| | Ус хангамж, ариутгах татуургын барилгын ажил | 100 | 100 | 0 |
| 3 | МҮОНРТ 10кВ-ын хуваарилах байгууламжийн барилгын ажил | 100 | 0 | 100 |
| | МҮОНРТ 10кВ-ын хуваарилах байгууламжийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | МҮОНРТ 10кВ-ын хуваарилах байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 10 | 90 |
| 5 | МҮОНРТ 2x1000кВА 10/0.4кВ-ын дэд өртөөний барилгын ажил | 100 | 10 | 90 |
| | МҮОНРТ 2x1000кВА 10/0.4кВ-ын дэд өртөөний тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | МҮОНРТ 2x1000кВА 10/0.4кВ-ын дэд өртөөний тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 10 | 90 |
| 7 | МҮОНРТ 2x800кВА 10/0.4кВ-ын дэд өртөөний барилгын ажил | 100 | 10 | 90 |
| | МҮОНРТ 2x800кВА 10/0.4кВ-ын дэд өртөөний тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | МҮОНРТ 2x800кВА 10/0.4кВ-ын дэд өртөөний тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 10 | 90 |
| 11 | МҮОНРТ 10кВ-ын кабель шугамын трассын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 50 | 50 |
| | МҮОНРТ 10кВ-ын кабелийн шугамын трассын барилга угсралтын ажил | 100 | 50 | 50 |
| | | | | |

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

| 7-р хороолол төсөл хэрэгжүүлэх ажлын ерөнхий график | | | | |
|---|---|---|---|---|
| № | Гүйцэтгэх ажлын нэр | Ажлын 100 хэмжээ хувиар (%) | 2012 онд хийгдэх ажлын хувь хэмжээ (%) | 2013 онд хийгдэх ажлын хувь хэмжээ (%) |
| 1 | 7р хороолол 220/110/35кВ "Улаанбаатар" дэд станцын өргөтгөл | | | |
| | Анхдагч холхозний цахилгаан тоноглолын нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Анхдагч холхозний цахилгаан тоноглолын угсралт | 100 | 80 | 20 |
| | Хоёрдогч холхоо ба реле хамгаалалтын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Хоёрдогч холхоо ба реле хамгаалалтын тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 100 | 0 |
| | Ил хуваарилах байгууламжийн барилгын хийцүүдийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Ил хуваарилах байгууламжийн барилгын хийцүүдийн угсралт | 100 | 80 | 20 |
| 2 | 7р хороолол 110/35/10кВ-ын "7р хороолол" дэд станц | | | |
| | Анхдагч холхозний цахилгаан тоноглолын нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Анхдагч холхозний цахилгаан тоноглолын угсралт | 100 | 80 | 20 |
| | Хоёрдогч холхоо ба реле хамгаалалтын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Хоёрдогч холхоо ба реле хамгаалалтын тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 80 | 20 |
| | Диспетчерийн холбооны тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Диспетчерийн холбооны тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 80 | 20 |
| | ХХБ 10кВ-ын болон удирдлагын байрны барилгын ажил | 100 | 100 | 0 |
| | Байгын жижүүрийн байрны барилга угсралтын ажил | 100 | 100 | 0 |
| | Ус хангамж, ариутгах татуургын барилгын ажил | 100 | 100 | 0 |
| 3 | 7р хороолол 110кВ-ын ЦДАШ | | | |
| | Фундаментын нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Фундаментын угсралт | 100 | 90 | 10 |
| | Тулгуурын нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Тулгуурын угсралт | 100 | 90 | 10 |
| | Утас, холбох хэрэгслийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | Утас, холбох хэрэгслийн угсралт | 100 | 0 | 100 |
| 4 | 7р хороолол 10кВ-ын хуваарилах байгууламжийн барилгын ажил | 100 | 30 | 70 |
| | 7р хороолол 10кВ-ын хуваарилах байгууламжийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | 7р хороолол 10кВ-ын хуваарилах байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 30 | 70 |
| 5 | 7р хороолол 2х630кВА, 10/0.4кВ-ын дэд өртөөний барилгын ажил | 100 | 20 | 80 |
| | 7р хороолол 2х630кВА, 10/0.4кВ-ын дэд өртөөний тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 100 | 0 |
| | 7р хороолол 2х630кВА, 10/0.4кВ-ын дэд өртөөний тоног төхөөрөмжийн угсралт | 100 | 20 | 80 |
| 6 | 7р хороолол 10кВ-ын кабель шугамын трассын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт | 100 | 50 | 50 |
| | 7р хороолол 10кВ-ын кабель шугамын трассын угсралтын ажил | 100 | 10 | 90 |
| 7 | ОССК-н 10кВ-н кабель шугам | 100 | 0 | 100 |
| 8 | 29-р сургуулийн 10кВ-н STDАБН буулгах ажил | 100 | 0 | 100 |

Тайлбар: Хэрэв захиалагчийн зүгээс газар чөлөөлөлтийг бүрэн шаардлагын хэмжээнд хийхгүй бол энэхүү график өөрчлөгдөх болно

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЕРӨНХИЙ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ
"ENCC"ХХК-ийн Ерөнхий Ня-Бо

........................ / Л. Анхбаяр /

ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"Эрчим инженеринг"ХХК-ийн Гүйцэтгэх захирал

........................ /Н Баярмагнай/

Хангамжийн менер ........................ /Б Цолмон/

Хавсралт-3

Гэрээний ерөнхий төсөв, үнийн задаргаа

| № | Гүйцэтгэх ажил | Дүн (ам.дол) |
|---|---|---|
| 1 | МҮОНРТ- хорооллын 10кВ-н цахилгаан хангамж | 7 675 879.36 |
| 2 | YII- хорооллын 10кВ-н цахилгаан хангамж | 8 720 837.45 |
| 3 | МҮОНРТ- хорооллын 110кВ-н цахилгаан хангамж | 6 778 143.38 |
| 4 | YII- хорооллын 110кВ-н цахилгаан хангамж | 5 435 085.96 |
| | ДҮН: | 28 609 946.15 |

Тайлбар:

1. Гэрээний үнийн дүнд НӨАТ (10%) орсон болно.
2. Энэхүү гэрээ нь санхүүгийн 2-3 жил дамжин хэрэгжих томоохон хэмжээний төсөл тул гадаад болон дотоодод үйлдвэрлэгдэх томоохон тоног төхөөрөмж, бараа материалуудыг худалдан авахад зориулж Ерөнхий туслан гүйцэтгэгч талаас гарсан урьдчилгаа төлбөрийг санхүүгийн тайланд тусгахдаа урьдчилж гарсан зардал, туслан гүйцэтгэгч тал дансанд орсон урьдчилгаа төлбөрийг урьдчилж олсон орлого гэж бүртгэх ба гадаадаас орж ирэх тухайн тоног төхөөрөмж, бараа материалыг бүрэн хэмжээгээр нь хилээр оруулж хүлээлгэн өгсөн үед нь, дотоодод үйлдвэрлэгдсэн бараа материал, тоног төхөөрөмжийг бүрэн тоо хэмжээгээр нь хүлээлцсэн үед нь харилцан бараа материал хүлээн авсан, хүлээлгэн өгсөн акт үйлдэж талууд худалдан авалт болон борлуулалтыг харилцан хүлээн зөвшөөрч санхүүгийн тайлан балансдаа нэгэн зэрэг тусгана.
3. Гэрээгээр хийж гүйцэтгэх ажлын тоо хэмжээ нь ерөнхий гүйцэтгэгчийн захиалагчтай хийсэн гэрээний тоо хэмжээ, энэхүү гэрээний хавсралт-1 д заасан зураг төслийн дагуу хийгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ENCC" ХХК-ны
Ерөнхий нягтлан бодогч
.................... / Л. Анхбаяр /

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Эрчим инженеринг"ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
.................... /Н.Баярмагнай/

Хангамжийн менежер
.................... /Б.Цолмон/

СЗХ
№ сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

БАТЛАВ "ENCC" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.ГАНЗОРИГ

БАТЛАВ: "ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ"ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
М.БАТБОЛД

**УБ ХОТЫН УБ-220/110/35кВ-н ДЭД ӨРТӨӨНИЙ ӨРГӨТГӨЛ, 7-Р ХОРООЛОЛ, МҮОНРТ-ИЙН 110/35/10кВ-ЫН ДЭД ӨРТӨӨ, 110кВ-н ЦДАШ, ХОРООЛОЛ ДУНД ОРШИХ 10кВ-н ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЕРӨНХИЙ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН БЗА-2010/55-ИШС/ТГ-05 ТООТ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ**

Дугаар: БЗА-2010/55-ИШС/ТГ-05 Нэм-1

2014 оны 06 дугаар сарын 20 -ны өдөр — Улаанбаатар хот

Нэг талаас 5404894 тоот регистрийн дугаар, 9011252023 тоот улсын бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээтэй Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо Алтайн гудамжны Start төвд байрлах "ENCC" ХХК-ийг төлөөлж Ерөнхий нягтлан бодогч Л.Анхбаяр /цаашид Ерөнхий туслан гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 2571676 тоот регистрийн дугаар 9011023073 тоот улсын бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээтэй "Эрчим инженеринг" ХХК-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Н.Баярмагнай /цаашид Туслан гүйцэтгэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээний нэмэлтийг байгуулав.

**Нэг: Гэрээний ерөнхий нөхцөл**

1.1 Энэхүү гэрээний нэмэлтийн зорилго нь УБ хотын **УБ ХОТЫН УБ-220/110/35кВ-н ДЭД ӨРТӨӨНИЙ ӨРГӨТГӨЛ, 7-Р ХОРООЛОЛ, МҮОНРТ-ИЙН 110/35/10кВ-ЫН ДЭД ӨРТӨӨ, 110кВ-н ЦДАШ, ХОРООЛОЛ ДУНД ОРШИХ 10кВ-н ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ** /цаашид гэрээт ажил гэх/-ыг Захиалагч (Барилга хот байгуулалтын Яам) ерөнхий гүйцэтгэгч (Бээжин констракшн инженеринг групп ХХК) нарын хооронд байгуулсан анхны гэрээнд тусгагдсан хугацаандаа хэрэгжиж дуусаагүй тул төслийн ажлыг хийж гүйцэтгэх хугацааг сунгаж төслийг үргэлжлүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээний нэмэлтэд захиалагч ерөнхий гүйцэтгэгч нарын хооронд 2010 оны 11 сарын 05 ны өдөр байгуулсан №БЗА-2010/55-ИШС, 2011 оны 11 дүгээр сарын 11 ны өдөр байгуулсан №БЗА-2010/55-ИШС-нэмэлт өөрчлөлт, тэдгээрийн тусгай нөхцөл, 2014 оны 06 сарын 13 ны өдөр байгуулсан №БЗА-2010/55-ИШС-2 нэмэлт өөрчлөлт, 2011 оны 11 сарын 01 ны өдөр Бээжин констракшн инженеиринг групп ХХК тай ENCC ХХК –н байгуулсан №БЗА-2010/55-ИШС/Т2 тоот гэрээ болон ENCC Эрчим Инженеринг ХХК –н хооронд байгуулсан БЗА-2010/55-ИШС/ТГ-05тоот гэрээнүүдийн бүх заалтууд хүчин төгөлдөр хэрэгжинэ.

**Хоёр. Гэрээний үнэ, хугацаа**

2.1 Төслийг хэрэгжүүлэх газар чөлөөлөлтийн ажил саатсанаас болж гэрээ хэрэгжих хугацааг 2015 оны 07 сарын 31 хүртэл сунгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ... ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

2.2 Туслан гүйцэтгэгч нь захиалагч болон ерөнхий гүйцэтгэгч нарын хооронд 2014 оны 06 сарын 13 ны өдөр байгуулсан **№БЗА-2010/55-ИШС-2 нэмэлт өөрчлөлтийн 8-д** заасны дагуу гэрээ хэрэгжих хугацааг сунгах эрхтэй бөгөөд захиалагчийн өмнө хариуцлага хүлээхгүй.

**Гурав. Долоо. Бусад зүйл**

3.1. Энэхүү гэрээний нэмэлтэд нь гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

3.2. Энэхүү гэрээг 2014 оны 06 дугаар сарын 20 -ны /ний/ өдөр хоёр хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч тус бүр нэг нэг хувийг хадгална.

3.3. Талуудын харилцах хаяг:

| | | | |
|---|---|---|---|
| Утас: | 88114799, 99994497 | Утас: | 99114904 |
| Факс: | | Факс: | 342336 |
| Цахим шуудан: | ganzorig.t@encc.mn | Цахим шуудан: | Magnai.n@erchim.mn |

**ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ ХИЙСЭН:**

| | |
|---|---|
| **ЕРӨНХИЙ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:** | **ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
| "ENCC" ХХК-ны Ерөнхий нягтлан бодогч | "Эрчим инженеринг"ХХК-ийн Гүйцэтгэх захирал |
| ......................./ Л. Анхбаяр / | ................../Н.Баярмагнай/ |

СЭХ
СЯО ... өлөр
БҮРТГЭВ
№ 01

И ЭН СИ СИ ХХК
БСИЖМН ХХК

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК
Чингисийн өргөн чөлөө, Гутал ХК-ны байр
3-р давхар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: (976) 11 343256, Факс: (976) 11 343255
Email: info@erchim.mn; www.erchim.mn

2015/05/27 № 142/2015

танай ________ -ны № __________ -т

Төлбөрийн тооцоо

СЯ болон БХБЯ дээр хуралдсан хурлуудын шийдвэрийн дагуу 2015 оны БУА-г эхлүүлэх санхүүжилтыг олгож ажил эхлүүлсэнд талархаж байгаагаа илэрхийлж байна.

Олгосон санхүүжилтээр ажил эхлэхэд шаардлагатай гадаад болон дотоодын үйлдвэрлэгч нараас худалдан авах тоног төхөөрөмж, бараа материалын урьдчилгаа төлбөрүүдийг хийж үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд үүний үр дүнд төсөл амжилттай хэрэгжиж эхэллээ.

Манай байгууллагад олгогдсон 250 000.00 ам.долларын санхүүжилтын тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Ажил эхлүүлэхээр олгогдсон дээрх санхүүжилт дууссан тул 220/110кВ –н "Улаанбаатар" дэд өртөө, YII болон МҮОНРТ хорооллын 110кВ-н ЦДАШ, YII хороолол МҮОНРТ 110/35/10кВ дэд өртөө, YII хорооллын 10кВ-н цахилгаан хангамжийн ажлыг бүрэн дуусгаж улсын комисст хүлээлгэн өгөхөд шаардлагатай байгаа 840 000,00 ам.долларын санхүүжилтыг яаралтай шийдвэрлэж өгөхийг хүсье?

Хүндэтгэсэн

Ерөнхий захирал М.БАТБОЛД

Хавсралт-1

## 250 000.00 ам долларын зарцуулалт

| № | Огноо | Зардлын нэр | Ханш | Орлого | Зарлага | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 7-May | Цахилгааны шугамын шонг ахлуулах | 1,952.93 | 250,000 | | 250,000.00 |
| 2 | 7-May | НӨАТ төлөв | 1,952.93 | | 21,800.00 | 228,200.00 |
| 3 | 7-May | ZTT Нэмэлт утас холбох хэрэгсэл захиалгын төлбөрийн урьдчилгаа | 1,947.56 | | 25,222.79 | 202,977.21 |
| 4 | 8-May | ZTT Нэмэлт утас холбох хэрэгсэл захиалгын гааль НӨАТ газар | 1,947.56 | | 4,500.00 | 198,477.21 |
| 5 | 15-May | Цементийн урьдчилгаа | 1,952.93 | | 9,216.00 | 189,261.21 |
| 6 | 20-May | 4 ш Нейтраль газардуулгын хутга, ХТ, DC панель ны үнэ урьдчилгаа | 1,940.60 | | 19,195.00 | 170,066.21 |
| 7 | 20-May | Утас баригчийн үнэ | 1,940.60 | | 7,720.00 | 162,345.21 |
| 8 | 20-May | Утас баригчийн гааль нөат | 1,940.60 | | 1,189.00 | 161,156.21 |
| 9 | 26-May | Орос Тоолуур гэрээний урьдчилгаа 30% төлөв | 1,952.93 | | 12,587.00 | 148,569.21 |
| 10 | 26-May | Тэжээлийн блок, Завсрын реле урьдчилгаа 30% | 1,952.93 | | 27,594.00 | 120,975.21 |
| 11 | 28-May | Гүүрэн байгууламж урьдчилгаа 60% | 1,927.88 | | 33,186.00 | 87,789.21 |
| 12 | 28-May | Эгс хайрга урьдчилгаа | 1,927.89 | | 400.00 | 87,389.21 |
| 13 | 28-May | Цахилгааны дотор монтажийн тоноглол | 1,927.88 | | 2,689.46 | 84,699.75 |
| 14 | 28-May | Гар багаж хэрэгсэл урьдчилгаа | 1,927.89 | | 2,969.80 | 81,729.95 |
| 15 | 28-May | Хар цаас | 1,927.89 | | 2,134.00 | 79,595.95 |
| 16 | 28-May | Ажлын хувцас | 1,927.89 | | 2,134.97 | 77,460.98 |
| 17 | 28-May | Тос тосолгооны үнэ | 1,927.89 | | 741.74 | 76,719.24 |
| 18 | 28-May | Багаж, сэлбэг хэрэгсэл | 1,927.89 | | 2,569.00 | 74,150.24 |
| 19 | 30-May | 5 сарын [illegible] цалин | 1,927.89 | | 36,309.00 | 37,841.24 |
| 20 | 30-May | НДШ төлөв 4-5 сар | 1,927.89 | | 18,153.90 | 19,687.34 |
| 21 | 30-May | ХХОАТ төлөв 4-5 сар | 1,927.89 | | 7,469.30 | 12,218.04 |
| 22 | 30-May | ТБ,7-Р хорооллын цахилгааны төлбөр төлөв | 1,927.89 | | 1,244.36 | 10,973.68 |
| 23 | 30-May | ТБ,7-Р хорооллын харуул хамгаалалтын төлбөр | 1,927.89 | | 3,034.00 | 7,939.68 |
| 24 | 30-May | ЦДҮС ТӨҮТ 205-206 ЦДАШ угсралтын урьдчилгаа | 1,927.89 | | 5,187.00 | 2,752.88 |
| 25 | 30-May | Тоосгоны урьдчилгаа | 1,927.89 | | 1,037.00 | 1,715.88 |
| 26 | 30-May | Машин механизмын Шатахууны зардал | 1,927.89 | | 1,700.00 | 15.88 |

Тайлан гаргасан: Нягтлан бодогч Б.Шинэзаяа

## 3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДҮРМИЙН ХУУЛБАР

СЗХ БҮРТГЭВ №01

**Үүсгэн байгуулагчийн 2015 оны 05 сарын 15-ны өдрийн 01/2015 тоот шийдвэрийн 1 дүгээр хавсралтаар батлав.**

**"Эрчим Инженеринг" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Компанийн оноосон нэр (монголоор)
- а) Бүрэн нэр: **"Эрчим Инженеринг"** ХХК /цаашид энэхүү дүрэмд "Компани" гэх/
- б) Товчилсон нэр: -

1.2.Компанийн оршин байгаа газар:
- Улсын нэр: **Монгол улс**
- Аймаг, нийслэлийн нэр: **Улаанбаатар хот**
- Сум, дүүргийн нэр: **Баянгол дүүрэг**
- Баг, хороо, хорооллын нэр: **6-р хороо**
- Гудамж, гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: **10-р хороолол**
- Хашаа, байшин, хаалганы дугаар: **15-р байр, 16 тоот**
- Харилцах утасны дугаар: **99114227**
- Факсын дугаар:
- И-мэйл хаяг: **info@erchim.mn**

1.3.Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн нэр

1.3.1.Иргэний тухайд:
- Иргэний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр: **Махбалын Батболд**
- Регистрийн дугаар: **УС59041357**
- Гэрийн хаяг: **Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, 15-р байр, 16 тоот**
- **Харилцах утасны дугаар: 99114227**

1.4.Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.

1.5.Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг энэ заалтад хамааруулахгүй.

**1.5.1. Гадаад худалдаа**

1.6.Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах дараах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

**1.6.1. Эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, угсралт, туршилт, тохируулга**

1.7.Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: **Хугацаагүй**

1.8.Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР

1.9.Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

**Хоёр. Компанийн эрх**

2.1.Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

2.2.Компани нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

2.3.Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.4.Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.5.Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

**Гурав. Компанийн үүрэг**

3.1.Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.

3.2.Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.

3.3.Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.

3.4.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.

3.6.Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу **Ерөнхий захирал**-г компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

3.7.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

**Дөрөв. Компанийн хариуцлага**

4.1.Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

4.2.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Энэхүү бондын бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10.8.1, Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 2014/05 тоот тогтоолоор баталсан "Бүртгэлийн журам" болон Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "МХБ ТӨХК-ийн арилжааны журам"-ын дагуу явагдана. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 7/3201тоот албан бичгээс үзвэл "Бондын баталгааны даатгал"-ын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь энэхүү бондыг худалдан авах хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн шинэлэг алхам болж байна.

Бид хууль зүйн дүгнэлт гаргах зорилгоор "ЭИ" ХХК-аас түүний гэрчилгээ, дүрэм, Хувьцаа эзэмшигчийн шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг эх хувиар болон хуулбарыг тулган шалгаж, судалсан болно. (ХАВСРАЛТ 3 Хууль зүйн дүгнэлт гаргахтай холбогдуулан судалсан компанийн бичиг баримтын жагсаалт). Түүнчлэн компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно (ХАВСРАЛТ 4 Шүүх болон төрийн холбогдох 15 байгууллага болон банкуудаас гаргуулсан бичгүүд).

Бид нийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, дүгнэлт гаргахдаа (а) үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, (б) бидэнд ирүүлсэн бүх бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн, зөв; (в) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг бодит, зөв; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (д) бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй гэж үзсэний үндсэн дээр, дор дурдсан асуудлаар, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн энэхүү хууль зүйн дүгнэлт гаргаж байна:

1. **Компани хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх**

"Эрчим инжиниринг" ХХК нь "Нөхөрдөл Компаний тухай" хуулийн дагуу 1999 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн шийдвэрээр нэг гишүүнтэйгээр үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн. /Улсын бүртгэлийн дугаар: 9011023073, Регистрийн дугаар: 2571676/.

Тус компани нь нэг үүсгэн байгуулагчтай, үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн М.Батболд (Регистрийн дугаар: УС 59041357).

Компанийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг Компанийн хувьцаа эзэмшигчийн 2015 оны 5-р сарын 15-ны өдрийн 01/2015 тоот шийдвэрээр баталсан дүрэмд зааснаар "Гадаад худалдаа" болон "Эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, угсралт, туршилт, тохируулга" гэж заасан байна. Тус компанийн Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамнаас 2012 оны 5-р сарын 7-ны өдөр 3 жилийн хугацаатайгаар олгогдсон "Дулааны шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг", "Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг", "Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220кв хүртэл/", "Усны барилга байгууламжийн зураг төсөл", болон "Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн



ЭРЧИМ ИНЖИНИРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

зураг төсөл" боловсруулах тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 5-р сарын 7-нд дууссан байна. Уг асуудлаар Барилгын хөгжлийн төвөөс лавлагаа авахад 2015 оны 6-р сарын 17 ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд одоогоор сунгуулах хүсэлтээ өгөөгүй байна гэсэн хариу өгсөн. Гэвч тус компаниас 2015 оны 5-р сарын 14 ны өдрийн 130/2015 тоот албан бичгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар хандсан байна.

Компани нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

2. **Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдал**

"ЭИ" ХХК"-ийн Захирал, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийг удирдах чадвар, дадлага туршлага хангалттай байна гэж үзэж байна. (ХАВСРАЛТ 3.5 удирдах албан тушаалтнуудын намтар).

3. **Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх**

Компанийн дүрэм болон дотоод журмууд нь дор дурдсан зүйлсээс бусад нь хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-д нийцэж байна гэж үзэж байна:

"Монголын компанийн засаглал кодекс"-н Дөрөвдүгээр бүлгийн 4.1.1-н а/ хэсэгт "...компанийн гүйцэтгэх удирдлагын бие даан шийдвэрлэж болох хөрөнгийн хэмжээг өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарлан тогтоох нь зүйтэй бөгөөд уг хэмжээний хөрөнгийн асуудлыг холбогдох төлөвлөгөөнд тусгасан тохиолдолд шийдвэрлэх эрхтэй байх нь зүйтэй. Компанийн холбогдох төлөвлөгөөнд тусгагүй, эсхүл компанийн өөрийн хөрөнгийн 5 хувиас дээш хэмжээний хөрөнгийн талаар аливаа захирган гаргуулах шийдвэрийг ТУЗ шийдвэрлэдэг байвал зохино" гэж заасан байдаг. Гэвч "Эрчим инженеринг" ХХК-н Захирлаар хувьцаа эзэмшигч М.Батболд бүртгэлтэй байдаг бөгөөд Гүйцэтгэх удирдлагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилладаг байна. (ХАВСРАЛТ 3.6 Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээ).

4. **Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх**

Чингис хаан банк ХХК-тай 2014 оны 8-р сарын 04-ны өдөр байгуулсан 565,000,000 төгрөгийн Зээлийн шугам нээх гэрээ, болон Барьцааны гэрээ, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтүүд нь одоо хэрэгжих шатандаа байгаа бөгөөд эдгээр нь хэрэгжих боломжтой, зээл нь хэвийн ангилалд байна.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Улаанбаатар хотын VII хороолол, Монголын үндэсний радио телевизийн орчмын хорооллын инженерингийн шугам сүлжээний угсралтын ажлын хүрээнд "Зам, гүүр, барилга, хот байгуулалтын яам",

4

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

түүнийг төлөөлж тус яамны төрийн нарийн бичгийн дарга болон "Бээжин контракшн инженеринг групп" ХХК нар 2010 оны 11-р сарын 5-ны өдөр БЗА-2010/55-ИШС дугаар бүхий "Улаанбаатар хотын VII хороолол, Монголын үндэсний радио телевизийн хэрэг эрхлэх газар орчмын орон сууцны хорооллуудын инженерийн шугам сүлжээ барьж байгуулах угсралтын ажлын гэрээ" байгуулсан. "Бээжин контракшн инженеринг групп" ХХК нь туслан гүйцэтгэгчээр "Инженерийн шугам сүлжээний барилга угсралт" ХХК-ийг сонгож барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ерөнхий туслан гүйцэтгэгчийн 2011 оны 11-р сарын 1-ны өдөр БЗА-2010/55-ИШС/Т2 тоот гэрээг байгуулж, 2012 оны 4-р сарын 12-ны өдөр талууд БЗА-2010/55-ИШС/Т2 тоот гэрээний тусгай нөхцлийг тохирсон.

Ерөнхий туслан гүйцэтгэгч "Инженерийн шугам сүлжээний барилга угсралт" ХХК нь 2012 оны 3-р сарын 7-ны өдөр туслан гүйцэтгэгчээр "ЭИ" ХХК-г сонгож "УБ хотын УБ-220/110/35кВ-ы дэд өртөөний өргөтгөл, 7-р хороолол, МҮОНТ-ийн 110/35/10кВ-ын дэд өртөө, 110кВ-ы ЦДАШ, хороолол дунд орших 10кв-н цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлын ерөнхий туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч ("ЭИ")-ийн БЗА-2010/55-ИШС/ТГ-05 тоот гэрээг байгуулж, 2014 оны 6-р сарын 20-ны өдөр гэрээнд нэмэлт оруулж хугацааг 2015 оны 7-р сарын 31-ны өдөр хүртэл сунгасан байна. Эдгээр гэрээний дагуу төслийг хэрэгжүүлэхэд Захиалагчаас төлбөр орж ирэх хүртэл барилгын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор бонд гаргаж байгаа бөгөөд эдгээр гэрээ нь үнийн дүнгийн хувьд хангалттай, хуульд нийцсэн байна.

5. **Сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх**

Компанийн тухай хуулийн 87.4-т зааснаар Компани нэг өмчлөгчтэй бөгөөд уг этгээд гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх тохиолдолд энэ хуулийн арваннэгдүгээр бүлэг (Их хэмжээний хэлцэл)-ийн заалт хамаарахгүй гэж заасан бөгөөд тус компани нь нэг үүсгэн байгуулагчтай, үүсгэн байгуулагч М.Батболд нь тус компанийн Ерөнхий захирлаар ажиллаж байгаа тул хууль зүйн дүгнэлтийн энэ хэсэг нь тус компанийн хувьд хамааршгүй байна.

Мөн хуулийн 92.8-д Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай энэ хуулийн арванхоёрдугаар бүлэг (Сонирхлын зөрчилтэй хэлцэл)-т тогтоосон журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах тухай энэ хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална гэж заасан бөгөөд тус компанийн дүрэмд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг тусгайлан зохицуулаагүйг Компанийн тухай хуулийг зөрчсөн гэж үзэхгүй. Мөн гүйцэтгэх захиралтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тодорхой зүйл заалт байхгүй.

**6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх;**

"ЭИ" ХХК нь Эрчим хүчний яамнаас олгогдсон "0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга,

5

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

дагалдах ажил үйлчилгээ" болон "0,7–40,0 кгх/см$^2$ даралттай шугам хоолой, ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээний" тусгай зөвшөөрлүүдийг 2013 оны 6-р сарын 19-ны өдөр 3 жилийн хугацаатайгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрөл өнөөдрийн байдлаар хүчинтэй байгаа эсэх, одоогийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүссэн эсэх талаарх тодорхойлолт гаргуулахаар Эрчим хүчний яаманд албан бичгээр хандсан. Эрчим хүчний яамны 2015 оны 6-р сарын 15-ны өдрийн к/1848 тоот албан бичгээр өгсөн тодорхойлолтод дурдсанаар дээрх 2 төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь 2013 оны 6-р сарын 19-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгогдсон бөгөөд 2015 оны 6-р сарын 15-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл үүсээгүй байна.

Барилга хот байгуулалтын яамнаас олгогдсон "Дулааны шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг", "Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг", "Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220кв хүртэл/", "Усны барилга байгууламжийн зураг төсөл", болон "Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл" боловсруулах тусгай зөвшөөрлийн лавлагааг авахаар Барилга хот байгуулалтын яаманд хандсан. Барилга хот байгуулалтын яам лавлагааг гаргуулахаар "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-т 2015 оны 6-р сарын 11-ны өдрийн 8/1893 тоот албан бичгээр хандсан. Барилгын хөгжлийн төвөөс 2/1391 тоот албан бичгээр өгсөн тодорхойлолтод дээрх 5 төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 5-р сарын 7-ны өдөр дууссан бөгөөд 2015 оны 6-р сарын 17-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл өгөөгүй байгаа талаар дурдсан байна. Гэвч тус компаниас 2015 оны 5-р сарын 14 ны өдрийн 130/2015 тоот албан бичгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар хандсан байна.

"ЭИ" ХХК нь ямар нэгэн лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмшдэггүй болно.

6. **Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа;**

"ЭИ" ХХК нь нийт 500,000,000 төгрөгний үнийн дүн бүхий 50,000 ширхэг бондыг 6 сарын хугацаатайгаар гаргана. Бонд нэг бүр 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18,50 хувийн хүүтэй байна. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна. Энэ тухай ХАВСРАЛТ 3.4–өөс үзнэ үү.

7. **Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох**

"ЭИ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагааг 2015 оны 6 дугаар сарын 5-ны байдлаар "Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн төв архив"-аас гаргуулан судлав ( ХАВСРАЛТ 4-ын 1.Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа). 2015 оны 6-р сарын 5-ны өдрийн байдлаар "ЭИ" ХХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэн М.Батболд 100 хувь эзэмшиж байна. "ЭИ" ХХК-ийн хувьцаа



ЭРЧИМ ИНЖИНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

эзэмшигч бөгөөд Ерөнхий захирал М.Батболд нь тус компанийн хяналтыг хэрэгжүүлэгч мөн.

8. Нэмэлт шинжилгээ, судалгаа

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэж зарим нэмэлт шинжилгээ судалгаа (Due diligence) хийж, шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, доор дурдсан дүгнэлт хийв. Үүнд:

- "ЭИ" ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд Хан-Уул дүүргийн шүүхийн 2013 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 1489 тоот шийдвэртэй, "Пролог солюшн" ХХК-ийн нэхэмжлэлтэй 34,023,479 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан бөгөөд 2015 оны 6-р сарын 4-ны байдлаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тодорхойлолт дээр ямар нэгэн өр төлбөргүй гэж тодорхойлогдсон тул дээр дурдсан шийдвэрийг биелүүлж, нэхэмжлэгчид төлбөрийг төлсөн байна. Захиргааны шүүх, арбитрт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаагүй.

- Нийслэлийн татварын газраас ирүүлсэн мэдээллээр 14,187,556.8 төгрөгийн татварын илүү төлөлттэй, Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр гаалийн татварын өргүй, Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн мэдээллээр нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байна.

- Тус компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэлд тусгаснаар өөрийн данс байршуулсан Голомт банк болон Худалдаа хөгжлийн банкны зээлийн албан ёсны мэдээллээр тус банкинд зээлийн болон зээлийн хүүгийн өр төлбөргүй байна. Чингис хаан банкинд 2015 оны 6-р сарын 9-ны байдлаар 565,000,000 (таван зуун жаран таван сая) төгрөгийн зээлийн шугамын үлдэгдэлтэй байна.

- Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн мэдээллээр "ЭИ" ХХК нь Өрсөлдөөний тухай хуульд заасан зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоолгож байгаагүй бөгөөд тус компани нь 2015 оны 6-р сарын 23-ны өдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хуулийг зөрчиж байгаагүй ба Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас торгууль, шийтгэвэр оногдуулж байгаагүй байна.

- Эрчим хүчний яамнаас "0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ" болон "0,7-40,0 кгх/см$^2$ даралттай шугам хоолой, ЦТХ-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах үйлчилгээний" тусгай зөвшөөрлүүдийг 2013 оны 6-р сарын 19-ны өдөр 3 жилийн хугацаатайгаар авсан. Эрчим хүчний яамнаас ирүүлсэн мэдээллээр 2015 оны 6-р сарын 15-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл үүсээгүй байна.

7

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭИ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

- Барилга хот байгуулалтын яамнаас "Дулааны шугам, сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг", "Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг", "Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технилогийн ажлын зураг /220кв хүртэл/", "Усны барилга байгууламжийн зураг төсөл", болон "Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл" боловсруулах тусгай зөвшөөрлийг авсан. Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн мэдээллээр "уг тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 5-р сарын 07-ны өдөр дууссан бөгөөд 2015 оны 6-р сарын 17-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдөл өгөөгүй байна" гэж мэдэгдсэн. Гэвч тус компаниас 2015 оны 5-р сарын 14 ны өдрийн 130/2015 тоот албан бичгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар хандсан болох нь нотлогдож байна. ( ХАВСРАЛТ 3.8 "ЭИ"-ээс БХБЯ-нд өгсөн Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт). Тус компанийн одоогийн хэрэгжүүлж байгаа төслүүд нь Эрчим хүчний яамнаас 2013 оны 6 дугаар сарын 19-ний өдөр 3 жилийн хугацаагаар олгогдсон 165\13 дугаартай "0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ" болон "0,7-40,0 кгх/см² даралттай шугам хоолой, ЦТХ-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах үйлчилгээний" тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэгжиж байгаа тул Барилга хот байгуулалтын яамнаас дээр дурдсан тусгай зөвшөөрөл сунгахаар хүлээгдэж буй нь бонд эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөргүй байна.

## 8. Дүгнэлт

"ЭИ" компанийн Бонд гаргах танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн байна. Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн тухай дүгнэлтийг (ХАВСРАЛТ 5)-аас үзнэ үү.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН,
ХУУЛЬЧ Д.ДУГЭРЖАВ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

## 3.6. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК**



# ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Захиалагчийн нэр:**

"ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ" ХХК

**Улсын бүртгэлийн дугаар:** 9011023073

**Регистрийн дугаар:** 2571676

**Үйлчлүүлэгчийн хаяг:**

Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 3-р хороо, Ажилчдын гудамж, Чинтайх ХХК-ийн байр, 2 давхар

**Хөрөнгийн үнэ цэнэ:**

**6,252,723,222 төгрөг** ***/Зургаан тэрбум хоёр зуун тавин хоёр сая долоон зуун хорин гурван мянга хоёр зуун хорин хоёр/***

**Улаанбаатар хот**
**2015.06**

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА


НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ОБЪЕКТЫН ТАНИЛЦУУЛГА, ҮНЭЛГЭЭНИЙ ....................2

ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ ....................2

*1.1 Үнэлгээний объектын талаарх товч мэдээлэл* ....................2

*1.2 Үнэлгэдэж буй компанийн товч танилцуулга* ....................3

*1.3 Үнэлгэдэж буй компанийн зорилго, хэрэглэсэн арга зүй.* ....................5

ХОЁР. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ ....................9

2.1. Эргэлтийн хөрөнгийн тодорхойлолт, дүгнэлт ....................9

*2.1.1. Мөнгөн хөрөнгө* ....................9

*2.1.2 Авлага* ....................10

*2.1.3 Урьдчилж төлсөн зардлын тооцоо* ....................12

*2.1.4 Бараа материал* ....................13

2.2 Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ дүгнэлт ....................16

*2.2.1 Машин, тоног төхөөрөмжийн тодорхойлолт, үнэлгээ* ....................16

*2.2.2 Тоног төхөөрөмжийн үнэлгээ* ....................21

*2.2.3 Тээврийн хэрэгслийн тодорхойлолт , үнэлгээ* ....................25

*2.2.4 Тавилга эд хогшил, компьютер түүний дагалдах хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгийн тодорхойлолт, үнэлгээ* ....................30

*2.2.5 Биет бус хөрөнгийн тодорхойлолт, үнэлгээ* ....................31

ГУРАВ. ХӨРӨНГИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ ДҮГНЭЛТ ....................34

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХИ ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА ....................35

ТАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД ....................36




ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01



# “ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ” ХХК-ИЙН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | | |
|---|---|---|
| 2015оны 06 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 04/15 | Улаанбаатар хот |

## НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ОБЬЕКТЫН ТАНИЛЦУУЛГА, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

“Эрчим инженеринг”ХХК-ийн захиалгаар 2014 оны 12-р сарын 31-ний байдлаарх тус компанийн нийт хөрөнгийн үнэлгээг хийлээ.

### *1.1 Үнэлгээний объектын талаарх товч мэдээлэл*

| | |
|---|---|
| Аж ахуйн нэгжийн нэр | *"Эрчим Инженеринг" ХХК* |
| Улсын бүртгэлийн дугаар | *9011023073* |
| Регистрийн дугаар | *2571676* |
| Захирал /эзэн/-ын нэр | *МахбалынБатболд* |
| Гэрээний огноо | *2015-06-09* |
| Одоогийн эрхэлж байгаа үйл ажиллагаа | *Эрчим хүчний тоног төхөөрөмж, засвар угсралт, тохируулга, туршилт* |
| | *Гадаад худалдаа* |
| Хаяг, байршил | *Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ажилчдын гудамж, Чинтайк ХХК-ийн байр, 2 давхар* |
| Захиалагчийннэр | *"Эрчим Инженеринг" ХХК* |



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01



### 1.2 Үнэлэгдэж буй компанийн товч танилцуулга

Эрчим Инженеринг ХХК-нь 1999 онд байгуулагдан эрчим хүчний тоног төхөөрөмжийн зураг төсөл, засвар үйлчилгээ, угсралт, туршилт тохируулгын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл Эрчим хүч, Уул уурхай, Нийтийн аж ахуй, Барилгын чиглэлд өөрийн үйл ажиллагаагаа явуулж Дэлхийн банк, Азийн Хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн төслүүд болон орон нутаг, тухайн байгууллагын санхүүжилтээр хийгдсэн 100 гаруй төсөл, гэрээт ажлыг хийж гүйцэтгээд байна.

Эрчим Инженеринг ХХК нь дараах үндсэн чиглэлээр ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд цаашид өөрийн үйл ажиллагааны чиглэлийг өргөтгөхөөр ажиллаж байна. Үүнд:

- 0,4-220кВ н ЦДШ, дэд станцын зураг төсөл, засвар, угсралтын ажил
- 80кгх/см2 с дээш даралттай зураг төсөл, зуухны засвар, угсралтын ажил
- 80кгх/см2 с дээш даралттай зураг төсөл, даралтат савны засвар, угсралтын ажил
- 80кгх/см2 с дээш даралттай шугам хоолойн зураг төсөл, засвар, угсралтын ажил\
- Туршилт тохируулгын ажил\
- Хаягдлын болон усан сангийн барилга угсралт

Тус байгууллагын мэргэшсэн инженерүүд Монгол улсын хамгийн чухал объектууд болох Дулааны цахилгаан станцууд, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ, Улаанбаатар хотын цахилгаан түгээх сүлжээ, Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээ, Үндэсний диспечерын төв зэрэг олон байгууллагуудад ажил үйлчилгээ үзүүлж Монгол улсын Эрчим хүчний найдвартай ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Хэрэгжүүлж байсан томоохон төсөл ажлуудаас дурьдвал:

- Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцын шинэчлэлийн төслийн 1-р шатанд оролцож 1-4 зуухны тоосон систем, Кип-А болон зуухнуудыг шинэчлэн, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг угсрахад гар бие оролцон ажилласан билээ.
- Жил бүр Дулааны шугам сүлжээний сальникан компенсаторыг орчин үеийн дэвшилтэт технологиор хийгдсэн сильфон компенсатороор солих ажлыг зохион байгуулж өнөөдрийн байдлаар 300-800 диаметр бүхий 120 гаруй компенсаторыг нийлүүлж угсарсан байна.



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ УЛААНБААТАР ХОТ

өртөөний зураг төслийг гүйцэтгэж өнөөдрийн байдлаар 7-р хороолол болон Радио Телевизийн хорооллын 110/35/10кВ-н 2х40 000кВА-н 2 дэд өртөөний барилга угсралтын ажлыг 26 км ЦДАШ н хамт хийж гүйцэтгэж байна. Энэ дэд өртөөнд урьд нь Монгол улсад ашигладаж байгаагүй 110кВ-н GIS (Хийн тусгаарлагч бүхий таслуур)-тай компакт тоног төхөөрөмжийг суурилуулах юм.

- Хөвсгөл аймгийн Мөрөн хотын нэгдсэн дулаан хангамжийн төсөл болох "Мөрөн хотын дулааны станц, дулааны шугам сүлжээ" төслийн ТЭЗҮ болон ажлын зураг төсөл боловсруулсан болно.
- Гашуун Сухайт - Оюу Толгой чиглэлийн 220кВ-н 330кВ-н габарит бүхий ЦДАШ-н зураг төсөл ийг хийж гүйцэтгэн баоилга угсралтын ажлыг хийж гүйцэтгээд байна. Уг ажилд Монгол анх удаа 2 давхар утсыг тата машин тоног төхөөрөмж оруулж ирж барилга угсралтын шинэ арга барилыг нэвтрүүллээ.
- Монголд анх удаан ашиглахаар баригдаж байгаа 50МВТ чадал бүхий "Салхит" салхин паркын зураг төслийг хийж барилга угсралтын ажлыг гүйцэтгээд байна. Энэхүү салхин паркад Монголд анх удаа эрчим хүчний чанарыг олон улсын норм хэмжээнд хүргэн барьж чадах SVC (Synchronic Var Compensator) тавьсан нь ирээдүйд эрчим хүчний чанарын асуудлыг дээшлүүлэхэд авах анхны арга хэмжээ болж өгсөн нь бусад дэд өртөөний хувьд авч хэрэгжүүлэх анхны туршлага болж байна.
- БНХАУ болон Монгол улсын засгийн газрын хооронд байгуулсан хөнгөлттэй зээлийн хүрээнд "МУОНРТ" ба "VII" хорооллын дэд бүтцийг барьж байгуулах төслийн туслан гүйцэтгэгчээр ажиллаж байна.
- Эрчим хүчний зураг төслийн чанарыг олон улсын шаардлагын хэмжээнд хүргэхийн тулд АНУ-н PLS CAD, Tower, ETAP ОХУ-н Model Studio LEP зэрэг шинэ программ хангамжуудыг авч ашиглаж эхлээд байна.

### *1.3 Үнэлгээж буй компанийн зорилго, хэрэглэсэн арга зүй*

1.3.1 Үнэлгээний энэхүү гэрээт ажлын зорилго нь "Эрчим Инженеринг" ХХК-ийн хөрөнгийн өнөөгийн бодит үнэ цэнийг хөрөнгийн зах зээл дээр шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг гаргах зориулалтаар тодорхойлоход оршино.

1.3.2 Хөрөнгийн үнэлгээг аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, компанийн дүрэм, хууль эрх зүйн акт, 2011-2014 оны санхүүгийн тайлан зэрэг материалыг үндэслэн 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тодорхойллоо.



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01



1.3.3 Үнэлгээний ажлын гэрээг захиалагчийг төлөөлж Эрчим Инженеринг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Баярмагнай, гүйцэтгэгчийг төлөөлж "Эвиденсе Аудит" ХХК-ийн захирал С.Бадамгарав нар баталж, гэрээгээр харилцан хүлээх үүрэг хариуцлага, ажлын хамрах хүрээ, хугацаа, төлбөр тооцоог урьдчилан тохиролцож ажилласан болно.

1) *Хөрөнгө, түүнийг хүлээн зөвшөөрөх:* Өнгөрсөн үйл явцын үр дүнд бий болсон, ирээдүйд ашиг авчрахаар хүлээгдэж байгаа тухайн аж ахуйн нэгжийн хяналтанд байгаа нөөц. Аж ахуйн нэгжид хөрөнгөөс орж ирэх ирээдүйн ашиг нь бодитой болсон бөгөөд өртөг, үнэ цэнийг нь бодитойгоор хэмжих боломжтой болсон үед түүнийг балансад хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 3.4., 3.4.2)

2) *Үл хөдлөх хөрөнгө:* Биет байдлаараа газар, газраас салгаж үл болох хүний бүтээсэн эд зүйлс. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 3.1)

3) *Үл хөдлөх өмч:* Үл хөдлөх хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрх, ашиг сонирхол, өгөөжийг агуулсан ойлголт бөгөөд өмчлөлийн баталгаа (өмчлөлийн гэрчилгээ)-аар илэрхийлэгдэнэ. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 3.2)

4) *Үнэ:* Бараа үйлчилгээнд хүссэн, санал болгосон буюу төлсөн мөнгөн дүн. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 4.2)

5) *Өртөг:* Бараа үйлчилгээнд төлсөн үнэ эсвэл бараа үйлчилгээг үйлдвэрлэн бүтээхэд шаардагдах дүн. Бараа үйлчилгээнд төлсөн дүн нь худалдан авагчийн хувьд өртөг болно. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 4.3)

6) *Үнэ цэнэ:* Бараа үйлчилгээний арилжаанд оролцогч талуудаар тогтоогдсон үнэтэй холбоо бүхий эдийн засгийн ухагдахуун. Үнэ цэнэ нь бараа үйлчилгээний зарагдаж болох үнийн тооцоо/үнэлгээ юм. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 4.5)

7) *Бодит үнэ цэнэ:* Холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд мөнгө солилцох эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүнг хэлнэ (НББОУС 16. 6, 17, 4, ОУҮС-2, 3.2 ).



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР

8) *Боломжит үйлчилгээ:* Аж ахуйн нэгжийн зорилгын дагуу хөрөнгийн бараа үйлчилгээ нийлүүлэх чадавхи. (ОУҮСХ 3, 3.9)

9) *Үнэлгээний хандлага:* Ерөнхийдөө нэг буюу түүнээс дээш тооны үнэлгээний хандлагуудыг ашиглан үнэ цэнийг тогтоох арга зам. Үнэлэгдэх хөрөнгийн мөн чанар, зориулалтаас хамаарч үнэлгээний 3 хандлагыг хэрэглэнэ. Үүнд: зах зээлийн жишиг үнийн хандлага, орлого капиталжуулалтын хандлага, өртгийн хандлага зэрэг орно. Эдгэр хандлагууд нь үнэлгээчинд зах зээлийн үнэ цэнийг эсвэл зах зээлийн бус үний цэнийг тодорхойлох боломж олгоно. (ОУҮС-ын ХЗ 4, 3.23, ХЗ 5, 3.20, ХЗ 6, 3.38)

10) *Зах зээлийн жишиг үнийн хандлага:* Ижил төстэй болон орлуулагч хөрөнгийн борлуулалт ба холбогдох зах зээлийн мэдээллийг харгалзан харьцуулалт хийх замаар үнэ цэнэ тогтоодог хандлага. Ерөнхийдөө үнэлэгдэж буй хөрөнгө нь зах зээл дээр арилжаалагдаж байгаа ижил төстэй хөрөнгийн борлуулалттай жишигдэнэ. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 9.2.1.1)

11) *Орлого капиталжуулалтын хандлага:* Үнэлэгдэж буй өмчтэй холбоотой орлого, зарлын мэдээг судлан капиталжуулах үйл явцаар үнэ цэнэ тогтоодог хандлага. Энэ хандлагад цэвэр орлого болон хорогдуулах хувийн харилцан уялдааг авч үздэг. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 9.2.1.2)

12) *Өртгийн хандлага:* Тодорхой өмчийн худалдан авалтыг нэг бол ижил төрлийн өөр хөрөнгөөр эсвэл яг адил ашигт чанар бүхий хөрөнгөөр орлуулах боломжит өртгөөр үнэ цэнэ тогтоодог хандлага. Энэ хандлагаар үнэлэх үнэлгээчний үнэлгээ нь хуримтлагдсан элэгдлийг хассан тухайн хөрөнгийн нөхөн үйлдвэрлэлтийн эсвэл нөхөн орлуулалтын өртөгт үндэслэнэ. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 9.2.1.3)

13) *Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг.* Хөрөнгийн тухайн үеийн адил хөрөнгөөр орлуулан биет болон бүх төрлийн элэгдэл хоцрогдол болон оновчлолыг хассан өнөөгийн өртөг. (ОУҮСХэрэглээ 3, 3.1)

14) *Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг* нь зах зээлийн шууд нотолгоо хязгаарлагдмал үед санхүүгийн тайлагналын зориулалтаар тусгай хөрөнгийг үнэлэхэд хэрэглэгддэг өртгийн хандлагын хэрэглээ юм. Өртгийн хандлагын хэрэглээ болохын хувьд энэ нь орлуулалтын зарчимд нийцдэг. (ОУҮС-ын ХЗ 8, 1.2)



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

15) *Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг:* зах зээлийн нотолгоо хангалтгүй үед зах зээлийн үнэ цэнийг тооцоход хэрэглэнэ. (ОУҮС-ын ХЗ 8, 4.1)

16) *Дээд зэргийн үр ашигтай хэрэглээ:* Биет байдлаараа боломжтой, зохих ёсны үндэслэлтэй, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх, өндөр үнэ цэнээр үнэлэгдэх өмчийн хамгийн боломжит ашиглалт. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 6.3)

17) *Түүхэн өртөг:* Хөрөнгөнд төлсөн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүн. (НББОУС, Үзэл баримтлал, 100(а))

18) *Зах зээлийн түрээсийн төлбөр:* үнэлгээний өдрөөр бэлэн байгаа түрээслэгч, түрээслүүлэгчийн хооронд аль ч тал нь хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэг шахалтгүйгээр хандсан гэж үзсэнээр зүй зохистой маркетинг хийсний дараах холбоогүй талуудын ажил гүйлгээгээр өмч эсвэл өмчийн доторх орон зайг түрээслүүлэх төлбөрийн тооцоолсон дүн. (ОУҮС-ын ХЗ 2, 3.1.10.1)

19) *Ашигтай хугацаа:* Хөрөнгийг ашиглахаар тооцоолж буй хугацаа. (НББОУС 16. 6, 36.6, СТОУС 17.13)

20) *Үнэлгээний тайлан:* Үнэлгээний үндэслэл, зорилго болон үнэ цэнийн санал хүргэдэг судалгаа, шинжилгээний үр дүн, ажлын заавarчилгаа, удирдамжуудыг тусгасан баримт бичиг. Тайлангийн агуулга, төрөл, хэлбэр хэмжээ нь хэрэглэгч, эрх зүйн шаардлага, ажлын шинж чанар, нарийн төвөгтэй байдал зэргээс хамаарна. (ОУҮС 3, 3.5)

*Хөрөнгийн үнэлгээ хийхдээ дээрх шаардлага, тодорхойлолтуудыг удирдлага болгосон.*



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ

## ХОЁР. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

### 2.1. Эргэлтийн хөрөнгийн тодорхойлолт, дүгнэлт

"Эрчим Инженеринг" ХХК-ийн эргэлтийн хөрөнгө 2014 оны 12-р сарын 31-нээр 5,126.7 сая төгрөгийн дансны үнэтэй байсан ба шинэчилсэн үнэлгээ 5,039.4 сая төг болж үнэлэгдлээ. Эргэлтийн хөрөнгийн үнэлгээг санхүүгийн тайлангийн зориулалттай бус хөрөнгийн бирж дээр шинэ бүтээгдэхүүн гаргах зориулалтаар хийсэн бөгөөд зөвхөн бизнес үнэлгээнд ашиглаж болно.

#### *2.1.1. Мөнгөн хөрөнгө*

Мөнгөн хөрөнгөд кассболон харилцахад байгаа бэлэн төгрөг болон валют бүртгэгдсэн болно. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байгаа дүн нь банкны баталгаа, бэлэн мөнгөний тооллогын баримтаар тус тус баталгаажсан учраас үнэ цэнэд ямар нэгэн хорогдуулга хийгдээгүй болно. Хүснэгт 2.1

"Эрчим Инженеринг" ХХК-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн задаргаа

Хүснэгт 2.1

| Дансны зориулалт | Банкны нэр | Дансны дугаар | Валют нэр | 2013.12.31 байдлаар | | 2014.12.31 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төгрөг | Валют | Төгрөг | Валют |
| Касс | Бэлэн | - | MNT | 1,612,486 | - | 23,973,094 | - |
| Касс | Бэлэн | - | USD | 9,499,645 | 5,743 | 2,444,578 | 1,478 |
| Харилцах | Голомт | 1102026278 | MNT | 262,982,566 | - | 13,422,412 | - |
| Харилцах | Голомт | 1102107226 | USD | 89,510,315 | 54,114 | 2,828,412 | 1,710 |
| Харилцах | Голомт | 1102769255 | EUR | 22,975,170 | 10,096 | 51,270 | 23 |
| Харилцах | ХХБ | 495054595 | MNT | 15,373,768 | - | 24,533 | - |
| Харилцах | ХХБ | 495054596 | USD | 147,049 | 89 | 387,853 | 234 |
| Харилцах | Чингис | 3920010197 | MNT | 506,093,002 | - | 16,513,266 | - |
| Харилцах | Чингис | 3920040197 | USD | 227,628,409 | 137,615 | 1,104,674 | 668 |
| Харилцах | Чингис | - | MNT | 13,000,000 | - | - | - |
| **Бүгдийн дүн** | - | - | - | **1,148,822,411** | **207,657** | **60,750,092** | **4,113** |



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ТТН320 2571676 УЛААНБААТАР ХОТ

*2.1.2 Авлага*

Авлага нь бараа бүтээгдэхүүн борлуулж, ажил үйлчилгээ үзүүлсэний төлөө худалдан авах мөнгөний дүнг илэрхийлсэн ба тус компани авлагыг бодит үнэ цэнээр бүртгэдэг. Авлага нь бараа бүтээгдэхүүн борлуулж, ажил үйлчилгээ үзүүлсний төлөө худалдан авах мөнгөний дүнг илэрхийлсэн ба тус компани авлагыг бодит үнэ цэнээр бүртгэдэг. Авлагыг үнэлэхдээ харилцагч нэг бүрээр хариуцсан нягтлан бодогчоор гаргуулан насжилтын тайланг бэлтгүүлэн авч авлагын үнэ цэнийн бууралтын хувиар элэгдүүлж үнэлсэн. Авлагын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо авлагын насжилтанд суурилсан ба дараах хувийг ашигласан. Хүснэгт 2.2-оос харна уу.

Хүснэгт 2.2

| Авлагын насаар | Авлагын үнэ цэнийг бууруулсан хувь |
|---|---|
| **1 жил хүртлэх настай авлага** | **10%** |
| **1-2 жилийн настай авлага** | 25% |
| **3-5 жилийн настай авлага** | **50%** |
| **5-аас дээш жилийн настай авлага** | 100% |

Дээрхи арга зүйгээр авлагыг насжуулахад бодит авлагад байгуулах найдваргүй авлага нь дараах байдалтай байна гэж тооцоолж үнэлсэн.Хүснэгт 2.3-аас харна уу.

Авлагын үнэлгээ

Хүснэгт 2.3

| № | Нэр | Зориулалт | 12/30/2014 | Хорогдуулах хувь | Хорогдуулсан мөнгөн дүн | Үнэлэгдсэн дүн төгрөг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Анун Интернэйшнл ХХК | Авлага | 98,318,000 | - | - | 98,318,000 |
| 2 | ХХБ | Авлага | 188,995 | - | - | 188,995 |
| 3 | И Эн Си Си ХХК | Авлага | 108,340,000 | - | - | 108,340,000 |
| 4 | Инвекс ХХК | Авлага | 13,472,204 | 50 | 6,736,102 | 6,736,102 |
| 5 | Нийслэл Өргөө ХХК | Авлага | 49,500,000 | 50 | 24,750,000 | 24,750,000 |
| 6 | СММС ХХК | Авлага | 10,000,000 | | - | 10,000,000 |
| 7 | Мөнхбат Буурал | Авлага | 5,757,500 | 50 | 2,878,750 | 2,878,750 |
| **Нийт дүн** | | | **285,576,699** | **150** | **34,364,852** | **251,211,847** |

Мөн дараа тайлан гаргахаар авсан болович тайлант хугацаанд хаагдаагүй авлагыг насжуулаагүй болно.Хүснэгт 2.4-аас харна уу.

Хүснэгт 2.4

| № | Нэр | Зориулалт | 12/30/2014 | Хорогдуулах хувь | Хорогдуулсан мөнгөн дүн | Үнэлгээн дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баярмагнай Ням-Ишчий | дараа тайлан | 11,612,664 | - | - | 11,612,664 |
| 2 | Цолмон Батболд | дараа тайлан | 5,100,000 | - | - | 5,100,000 |
| 3 | Энхтөр Дашдэмбэрэл | дараа тайлан | 1,100,000 | - | - | 1,100,000 |
| 4 | Бадамгэрэл Халзан | дараа тайлан | 1,229,934 | - | - | 1,229,934 |
| 5 | Даваасүрэн Зоригтбаатар | дараа тайлан | 5,038,938 | - | - | 5,038,938 |
| **Нийт дүн** | | | **24,081,536** | **-** | **-** | **24,081,536** |



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ

*2.1.3 Урьдчилж төлсөн зардлын тооцоо*

Компани энэ дансанд ирээдүйд авах хөрөнгө болон үйлчилгээний төлөө төлсөн мөнгөн хөрөнгийг бүртгэсэн байна. Үүнд нэг ба хэд хэдэн тайлант үед хорогдуулан бүртгэх зардлын шинжтэй зүйлсийг 100 хувь хорогдуулж үнэлсэн, харин ирээдүйд хөрөнгө болох зүйлсийг өртгөөр нь үнэлсэн.Хүснэгт 2.5-аас харна уу

Урьдчилж төлсөн зардлын үнэлгээ

Хүснэгт 2.5

| № | Нэр | Зориулалт | 12/30/2014 | Хорогдуулах хувь | Хорогдуулсан мөнгөн дүн | Үнэлэгдсэн дүн /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сибэлектротехком | Материал УТТ | 79,058,949 | - | - | 79,058,949 |
| 2 | Liaoning-Efacec Electrical Equipment Co.Ltd | Материал УТТ | 163,290,682 | - | - | 163,290,682 |
| 3 | Hongyuan Import and Export Trading Co.,Ltd | Материал УТТ | 1,863,200 | - | - | 1,863,200 |
| 4 | Xilong cable Co.,Ltd | Материал УТТ | 1,476,276,130 | - | - | 1,476,276,130 |
| 5 | Буянт Ухаагийн гаалийн газар | Материал УТТ | 52,762 | 100 | 52,762 | - |
| 6 | Мандал женерал даатгал ХХК | Материал УТТ | 6,279,863 | 100 | 6,279,863 | - |
| 7 | Монголын барилгын үндэсний ассоциаци | Материал УТТ | 3,010,000 | - | - | 3,010,000 |
| 8 | Ди Эйч Эл | Материал УТТ | 130,600 | 100 | 130,600 | - |
| 9 | Мобинэт ХХК | Материал УТТ | 162,000 | 100 | 162,000 | - |
| 10 | Монгол керамик ХХК | Материал УТТ | 900,000 | - | - | 900,000 |
| 11 | Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ | Урьдчилж төлсөн тооцоо | 4,800,000 | 100 | 4,800,000 | - |
| 12 | Эм Жи Эл Энержи ХХК | Урьдчилж төлсөн зардал | 17,500,000 | 100 | 17,500,000 | - |
| 13 | Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн | Урьдчилж төлсөн зардал | 24,500,000 | 100 | 24,500,000 | - |
| 14 | Чимэд Мөнхдорж | УТЗ түрээс | 19,800,000 | 100 | 19,800,000 | - |
| 15 | ДЦС-4 ТӨХК | Бараа материалын авлага | 8,109,000 | - | - | 8,109,000 |
| 16 | МСЭЛ ХХК | Бараа материалын авлага | 468,586,920 | - | - | 468,586,920 |
| 17 | Гутал ХК | Барьцаа | 1,909,642 | 100 | 1,909,642 | - |
| 18 | Мобиком корпораци | Барьцаа | 1,320,000 | 100 | 1,320,000 | - |
| 19 | Юнител ХХК | Барьцаа | 200,000 | 100 | 200,000 | - |
| | Нийт дүн | | 2,277,749,747 | - | 76,654,866 | 2,201,094,881 |



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

2.1.4 Бараа материал

Компанийн хэвийн үйл ажиллагааны явцад гэрээт ажилд хэрэгдэгдэх бараа материал, багаж хэрэгслэлийг балансад өртгөөр нь бүртгэсэн бөгөөд уг бараа материалууд нь тухайн захиалгат ажлын зураг төсөвт заагдсан хэмжээнээс илүүгүй, хоцрогдолын болон үнийн өөрчлөлт багатай зэрэг шалтгаануудыг үндэслэн үнэлгээчин дахин үнэлэх шаардлагагүй гэж үзлээ.Хүснэгт 2.6-аас харна уу.

Хүснэгт 2.6

| № | Бараа материалын нэр | Хэмжих нэгж | Тоо/ш | Эцсийн үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Нэгж өртөг | Нийт өртөг /төгрөгөөр/ |
| 1 | Гарнитурын тусгаарлагч | шир | 30 | 45,000 | 1,350,000 |
| 2 | Цавуу нөхөөс | кг | 447 | 15 | 6,739 |
| 3 | шланк / Компрессорын хуванцар/ | м | 1 | 9,876 | 9,876 |
| 4 | Нөхөөс хаймар ф170 | шир | 6 | 1,125 | 6,751 |
| 5 | Нөхөөс хаймар ф75 | шир | 8 | 1,122 | 8,976 |
| 6 | Нөхөөс хаймар ф70 | шир | 4 | 377 | 1,508 |
| 7 | Бахь том | шир | 9 | 13,481 | 121,328 |
| 8 | Бахь жижиг | шир | 10 | 11,973 | 119,733 |
| 9 | Бахь нарийн | шир | 29 | 16,452 | 477,117 |
| 10 | Электрод 4.0 | кг | 59 | 2,596 | 153,188 |
| 11 | Электрод 3.0 | кг | 138 | 2,596 | 358,304 |
| 12 | Электрод 2.5 | кг | 110 | 2,795 | 307,395 |
| 13 | Дугуй задлах багаж Н1.2 | шир | 1 | 45,887 | 45,887 |
| 14 | Дугуй задлах багаж Н0.6 | шир | 1 | 41,139 | 41,139 |
| 15 | Лац | шир | 45 | 456 | 20,521 |
| 16 | Нөхөөс хаймар Ф75 | шир | 5 | 14,989 | 74,943 |
| 17 | Нөхөөс дугуйны Ф75 | шир | 20 | 528 | 10,553 |
| 18 | Дрилл | шир | 1 | 209,545 | 209,545 |
| 19 | YJY-1kV 3*6+1*4мм2 1kV | м | 1,000 | 5,402 | 5,401,644 |
| 20 | YJY-1kV *10+1*6мм2 1kV кабель | м | 1,000 | 7,391 | 7,390,763 |
| 21 | YJY-1kV 1*12мм2 1kV кабель | м | 1,000 | 50,853 | 50,852,507 |
| 22 | YJY-1kV 2*1.5мм2 кабель | м | 30 | 1,924 | 57,711 |
| 23 | YJY-1kV 4*1.5мм2 кабель | м | 60 | 2,504 | 150,237 |
| 24 | WDZB-BYJ 1.5мм2 кабель | м | 200 | 1,157 | 231,406 |
| 25 | YJY 2*2.5мм2 кабель | м | 120 | 2,312 | 277,479 |
| 26 | Biosko /дэд өртөөны бетон хийц/ | шир | 2 | 19,000,000 | 38,000,000 |
| 27 | YJLY-23 10кВ 3 фаз, Ф400 кабель | м | 8,000 | 64,523 | 516,181,642 |
| 28 | YJLY-23 ,1кВ, 1фаз,Ф*240 кабель | м | 500 | 49,930 | 24,965,053 |
| 29 | Тогтоогч NLS-10/3.4 | шир | 51 | 123,542 | 6,300,631 |
| 30 | Тогтоогч NLS-10/3.3 | шир | 155 | 109,742 | 17,010,030 |
| 31 | Тогтоогч NLS-10/3.2 | шир | 153 | 101,890 | 15,589,233 |
| 32 | Тогтоогч JLS-10/3.4 | шир | 112 | 443,311 | 49,650,824 |
| 33 | Тогтоогч JLS-10/3.3 | шир | 39 | 435,430 | 16,981,774 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 34 | Тогтоогч NLS-35/1.2 | шир | 8 | 137,260 | 1,098,079 |
| 35 | Тогтоогч WLS-35/1.2 | шир | 8 | 154,923 | 1,239,380 |
| 36 | Даравч төмөр Q345B | кг | 13 | 15,152 | 189,401 |
| 37 | Газардуулгын зэс утас 30*5мм | кг | 12 | 42,360 | 508,324 |
| 38 | Бүрээс ТМҮ100*10мм | кг | 24 | 13,586 | 326,064 |
| 39 | Бүрээс ТМҮ60*8-6мм | кг | 26 | 15,924 | 414,027 |
| 40 | Зэс шин ТМҮ80*8мм | кг | 7,921 | 11,385 | 90,184,469 |
| 41 | Зэс шин ТМҮ6*60мм | кг | 1,410 | 5,700 | 8,036,911 |
| 42 | Бүрээс ТМҮ60*6мм | кг | 9 | 13,821 | 124,388 |
| 43 | Гаргалгааны вакум таслуур бүхий үүр KYN28A-12 10kV | шир | 3 | 10,748,179 | 32,244,537 |
| 44 | Оруулгын автомат таслуур бүхий үүр GGD2-0.4kV | шир | 75 | 10,749,281 | 806,196,058 |
| 45 | Гаргалгааны автомат таслуур бүхий үүр GGD2,250A/3-0.4kV | шир | 3 | 5,755,720 | 17,267,160 |
| 46 | Секц хоборчийн үүр GGD2 0.4kV | шир | 1 | 13,902,875 | 13,902,875 |
| 47 | Зэс шин 100*10 | кг | 999 | 16,416 | 16,400,009 |
| 48 | Тогтоогч SYG-400/A 80*80мм | шир | 139 | 17,054 | 2,370,459 |
| 49 | Тогтоогч SYG-240/A 80*80мм | шир | 234 | 12,238 | 2,863,594 |
| 50 | Хавчаар SBG-1-M12 | шир | 229 | 13,324 | 3,051,126 |
| 51 | Хүрз | шир | 45 | 4,896 | 220,305 |
| 52 | Бахь Тажима | шир | 20 | 6,009 | 120,172 |
| 53 | Таслагч ир 1000 | шир | 2,800 | 431 | 1,206,757 |
| 54 | Электрод | шир | 230 | 2,148 | 494,021 |
| 55 | Торцов 05107 | шир | 15 | 16,853 | 252,793 |
| 56 | Торцов 05108 | шир | 25 | 17,439 | 435,976 |
| 57 | Торцов 05113 | шир | 10 | 20,956 | 209,561 |
| 58 | Түлхүүр задгай амтай 05125 | шир | 10 | 6,741 | 67,411 |
| 59 | Түлхүүр задгай амтай 05127 | шир | 10 | 7,767 | 77,670 |
| 60 | Түлхүүр задгай амтай 05129 | шир | 10 | 12,163 | 121,634 |
| 61 | Түлхүүр задгай амтай 0531 | шир | 10 | 15,827 | 158,270 |
| 62 | Түлхүүр нагтнаа 05151 | шир | 10 | 16,706 | 167,063 |
| 63 | Түлхүүр нагтнаа 05152 | шир | 10 | 18,611 | 186,114 |
| 64 | Түлхүүр нагтнаа 05156D | шир | 6 | 35,171 | 211,027 |
| 65 | Түлхүүр нагтнаа 05156F | шир | 6 | 46,455 | 278,731 |
| 66 | Иш торцовны төмөр LJB-B3-3 | шир | 2 | 138,486 | 276,973 |
| 67 | Иш торцовны төмөр LJB-BX4-3 | шир | 5 | 150,943 | 754,714 |
| 68 | Төмөр таслагч багаж QY1-30 | шир | 1 | 241,802 | 241,802 |
| 69 | Төмөр цоологч багаж YC300 | шир | 1 | 813,333 | 813,333 |
| 70 | Дамар утас ороогч SHL3GN | шир | 10 | 124,564 | 1,245,644 |
| 71 | Кабель үзүүрлэгч цахилгаан DDJ110 | шир | 1 | 1,329,176 | 1,329,176 |
| 72 | Өргүүр дамартай утас өргөх LBNX- | шир | 1 | 8,042,466 | 8,042,466 |
| 73 | Insulator | шир | 18 | 606,339 | 10,914,102 |
| 74 | Хэв хашмал 500*1200 | шир | 200 | 39,900 | 7,980,000 |



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 75 | Хэв хашмал 450*1200 | шир | 30 | 37,900 | 1,137,000 |
| 76 | Хэв хашмал 300*1200 | шир | 140 | 32,900 | 4,606,000 |
| 77 | Хэв хашмал 200*1200 | шир | 30 | 30,900 | 927,000 |
| 78 | Гадна булан 1200*63,5 | шир | 22 | 18,500 | 407,000 |
| 79 | Дотор булан 1200*100*200 | шир | 80 | 31,500 | 2,520,000 |
| 80 | Дотор булан 1200*100*100 | шир | 40 | 27,000 | 1,080,000 |
| 81 | Богино дэгээ | шир | 700 | 350 | 245,000 |
| 82 | Хэв хашмал 600*1200 | шир | 800 | 40,900 | 32,720,000 |
| 83 | Хэв хашмал 400*1200 | шир | 150 | 34,900 | 5,235,000 |
| 84 | SEL-93106X | шир | 4 | 950,302 | 3,801,207 |
| 85 | ZF10-126G /хуваарлах байгууламж | шир | 3 | 170,153,698 | 510,461,093 |
| 86 | GW4-126D вакум таслагч | шир | 1 | 8,899,830 | 8,899,830 |
| 87 | 1000KVA 10/0.4KV трансформатор | шир | 2 | 22,281,243 | 44,562,486 |
| 88 | Халуун үлээгч | шир | 1 | 3,700,000 | 3,700,000 |
| 89 | Халуун үлээгч B18 | шир | 1 | 1,100,000 | 1,100,000 |
| 90 | Халуун үлээгч B22 | шир | 1 | 900,000 | 900,000 |
| 91 | Холбох хэрэгсэл PTK020T-24T | шир | 102 | 5,146 | 524,913 |
| 92 | Дулаан хадаглагч тень | шир | 17 | 33,636 | 571,818 |
| 93 | Багажны иж бүрдэл | шир | 3 | 108,147 | 324,442 |
| 94 | Халаагуур 500ВТ ETC-85 | шир | 4 | 165,330 | 661,320 |
| 95 | Халаагуур 1000ВТ ETC-85 | шир | 230 | 178,200 | 40,986,000 |
| 96 | Халаагуур 1500ВТ RRH-SR | шир | 16 | 198,000 | 3,168,000 |
| 97 | Халаагуур 2000ВТ ETC-170 | шир | 60 | 202,500 | 12,150,000 |
| 98 | Кабель терминалNLS-10/3.2,3.3 | шир | 2 | 783,132 | 1,566,264 |
| 99 | Талбайн вибратор | шир | 1 | 130,000 | 130,000 |
| 100 | Катанг мэдрэгч | шир | 1 | 54,545 | 54,545 |
| 101 | Полоса 54 | м | 6 | 2,455 | 14,727 |
| 102 | Нивелер | шир | 2 | 425,000 | 850,000 |
| 103 | Таслагч дискэн Тажима | шир | 1 | 60,500 | 60,500 |
| **Нийт дүн** | | | - | - | **2,467,951,156.30** |



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

## 2.2 Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ дүгнэлт

"Эрчим Инженеринг" ХХК-ийн үндсэн хөрөнгийн үнэлгээг биет үзлэг, тооллогын мэдээлэл дээр тулгуурлан хийж гүйцэтгэлээ. Үнэлгээнд Олон улсын үнэлгээний стандарт 1-ийг баримталсан ба хэрэглэх заавар 1, 3, 4, 5-ийг ашигласан болно. Үнэлгээний тасалбар болгосон өдрөөр дансны үнэ 1,074.9 сая байсан нь үнэлгээгээр 1,213.3 сая төгрөг болж, 138,4 сая төгрөгөөр нэмэгдэж үнэлэгдсэн байна.Тус компанийнтээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж,тавилга эд хогшилын зэрэг үндсэн хөрөнгийн үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалт болон хөрөнгийн бирж дээр шинэ бүтээгдэхүүн гаргах зориулалтаар тус тус хийлээ.

### *2.2.1 Машин, тоног төхөөрөмжийн тодорхойлолт, үнэлгээ*

"Эрчим Инженеринг" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй машин, тоног төхөөрөмжүүдтэй биет үзлэг тооллого хийж үнэллээ.

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар "Эрчим Инженеринг" ХХК-ийн балансад 28 нэр төрлийн 71 ширхэг тоног төхөөрөмж бүртгэлтэй байна. Тоног төхөөрөмжийн фото зураг болон бусад мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 2.1*

**Тоног төхөөрөмжийн мэдээлэл (зураг)**

| Д/д | Хөрөнгийн код | МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 0145 | Adopter connector PL259 | Ширхэг | 5 |  |
| 2 | 0146 | Extension Rod 30" HS4240.2 | Ширхэг | 1 |  |



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 0147 | Magnet Mount PL 259 | Ширхэг | 5 |  |
| 4 | 0148 | Mobile Antenna Diamond | Ширхэг | 5 |  |
| 5 | 0149 | Mobile Radio Motorola GM 33 | Ширхэг | 5 |  |
| 6 | 0150 | Penetr Static Cone 30"HS | Ширхэг | 1 |  |
| 7 | 0151 | Portable radio Motorola | Ширхэг | 15 |  |
| 8 | 0152 | Power Supply Unit AV 220V | Ширхэг | 3 |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 0153 | Pramac Generator S6500 | Ширхэг | 1 |  |
| 10 | 0156 | Алкохол | Ширхэг | 1 |  |
| 11 | 0159 | Гагнуурын аппарат MMA | Ширхэг | 1 |  |
| 12 | 0160 | Генератор | Ширхэг | 2 |  |
| 13 | 0161 | Генератор | Ширхэг | 1 |  |
| 14 | 0162 | Геодизын хэмжилтын багаж | Ширхэг | 2 |  |

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | 0164 | Дугуй задлагч машин | Ширхэг | 1 |  |
| 16 | 0167 | Усны насос | 5 | 1 |  |
| 17 | 0175 | Гагнуурын аппарат | Ширхэг | 1 |  |
| 18 | 0176 | Геодизын хэмжилтын багаж | Ширхэг | 1 |  |
| 19 | 0181 | Спарк тестер PPM MK 3 | Ширхэг | 1 |  |
| 20 | 0184 | Тенсиометр EXAMO 300F | Ширхэг | 1 |  |

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | 0187 | Хуванцар гагнуурын аппарат | Ширхэг | 1 |  |
| 22 | 0192 | Электрон тахеометр S68738 | Ширхэг | 1 |  |
| 23 | 0212 | total station 352R | Ширхэг | 1 |  |
| 24 | 0213 | Total station 372R | Ширхэг | 1 |  |
| 25 | 0262 | Димократ | Ширхэг | 4 |  |
| 26 | 2016 | 58-CO181/N1 | Ширхэг | 2 |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 27 | 2025 | Даггаршуулагч | Ширхэг | 6 |  |
| 28 | 2045 | Ус зайлуулах насос шланк | Ширхэг | 1 |  |
| **Нийт тоо ширхэг** | | | | **71** | |

*2.2.2 Тоног төхөөрөмжийн үнэлгээ*

ОУҮС-н дагуу "Эрчим Инженеринг" ХХК-ийн тоног төхөөрөмж дээд зэргийн үр ашигтай ашиглагдаж болохуйц хөрөнгө байна. Тоног төхөөрөмжийг үнэлэхдээ орлогын хандлага болон нөхөн орлуулах өртгийн хандлагыг ашигласан болно.

А. Тоног төхөөрөмжийн орлогын хандлагаарх үнэлгээ:

"Эрчим Инженеринг" ХХК-ийн тоног төхөөрөмжийг орлогын хандлагаар үнэлэхдээ тухайн тоног төхөөрөмжөөр бүтээж буй баялагаас тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дуусах хүртэл ирээдүйд олох орлогыг капиталжуулдаг. Орлогын хандлагаарх хөрөнгийн үнэ цэнийг тооцоололбол:

*Хүснэгт 2.2*

**Тоног төхөөрөмжинд хувиарлах орлогын тооцоолол**

| | |
|---|---|
| **Дундаж борлуулалтын орлого /2010-2014/** | **7,400,876,045** |
| Цалин хөлс хөдөлмөрийн зардал /2010-2014/ | 3,347,045,897 |
| **Капиталжуулах орлого** | **4,053,830,147** |
| Тоног төхөөрөмжийн үндсэн хөрөнгөд эзлэх хувь | 7.68% |
| Тоног төхөөрөмжийн ашиглалтийн борлуулатын орлого | 311,334,155 |
| Тоног төхөөрөмжийн дундаж ашиглах хугацаа | 6.41 |
| Нэг удаагийн хүчин зүйл | **0.62** |
| Хувиарлах орлого | 193,898,912 |

Тоног төхөөрөмжийн ашиглалтын дундаж хугацаан дахь капиталжуулсан үнэ цэнэ нь 193,898,911.11 болж байна. Үүнийг тоног төхөөрөмж тус бүрт нь хувиарлавал:

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

*Хүснэгт 2.3*

**Тоног төхөөрөмжийн орлогын хандлагаарх үнэлгээ**

| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Ашиглах жил | Ашиг/эхлэх огноо | Тоо хэмжээ | Үлдэх өртөг | Орлогын хандлагаарх үнэ цэнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Adopter connector PL259 | Ширхэг | 10 | 3/10/2011 | 5 | 23,052 | 47,969 |
| 2 | Extension Rod 30" HS4240.2 | Ширхэг | 10 | 3/10/2011 | 1 | 359,225 | 747,534 |
| 3 | Magnet Mount PL 259 | Ширхэг | 10 | 3/10/2011 | 5 | 149,709 | 311,538 |
| 4 | Mobile Antenna Diamond | Ширхэг | 10 | 3/10/2011 | 5 | 330,184 | 687,099 |
| 5 | Mobile Radio Motorola GM 33 | Ширхэг | 10 | 3/10/2011 | 5 | 1,554,692 | 3,235,252 |
| 6 | Penetr Static Cone 30"HS | Ширхэг | 10 | 3/10/2011 | 1 | 1,146,551 | 2,385,928 |
| 7 | Portable radio Motorola | Ширхэг | 10 | 3/10/2011 | 15 | 4,088,147 | 8,507,273 |
| 8 | Power Supply Unit AV 220V | Ширхэг | 10 | 3/10/2011 | 3 | 506,691 | 1,054,404 |
| 9 | Pramac Generator S6500 | Ширхэг | 10 | 10/21/2011 | 1 | 2,781,774 | 5,788,763 |
| 10 | Алкохол | Ширхэг | 10 | 7/25/2011 | 1 | 129,492 | 269,467 |
| 11 | Гагнуурын аппарат MMA | Ширхэг | 10 | 8/20/2010 | 1 | 212,168 | 441,512 |
| 12 | Генератор | Ширхэг | 10 | 4/14/2011 | 2 | 12,195,235 | 25,377,807 |
| 13 | Генератор | Ширхэг | 10 | 4/14/2011 | 1 | 6,508,825 | 13,544,610 |
| 14 | Геодизын хэмжилтын багаж | Ширхэг | 10 | 7/28/2011 | 2 | 9,817,863 | 20,430,587 |
| 15 | Дугуй зүлгэгч машин | Ширхэг | 10 | 5/27/2011 | 1 | 1,220,946 | 2,540,741 |
| 16 | Усны насос | Ширхэг | 10 | 11/4/2011 | 1 | 1,117,132 | 2,324,709 |
| 17 | Гагнуурын аппарат | Ширхэг | 10 | 11/28/2011 | 1 | 2,374,798 | 4,941,862 |
| 18 | Геодизын хэмжилтын багаж | Ширхэг | 10 | 10/18/2011 | 1 | 5,369,790 | 11,174,324 |
| 19 | Спарк тестер PPM MK 3 | Ширхэг | 10 | 10/10/2008 | 1 | 894,107 | 1,860,602 |
| 20 | Тенсиометр EXAMO 300F | Ширхэг | 10 | 10/28/2008 | 1 | 2,789,643 | 5,805,139 |
| 21 | Хуванцар гагнуурын аппарат | Ширхэг | 10 | 9/25/2009 | 1 | 5,735,093 | 11,934,504 |
| 22 | Электрон тахеометр S68738 | Ширхэг | 10 | 2/28/2011 | 1 | 2,789,869 | 5,805,609 |
| Нийт дүн | *8,062,263,554.54* | 4,570,320,571.79 | (3,491,942,982.75) |
| Эзэмшигчийн өмч | | | - |
| Төрийн өмч | | | - |
| Хувийн өмч | 10,000,000.00 | 10,000,000.00 | - |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | | - |
| Нэмж төлөгдсөн капитал | | | - |
| Эздийн өмчийн бусад хэсэг | | | - |
| Хуримтлагдсан ашиг | *1,753,987,808.30* | 1,767,270,104.89 | 13,282,296.59 |
| Дүн | *1,763,987,808.30* | *1,777,270,104.89* | 13,282,296.59 |
| ***Нийт дүн*** | **9,826,251,362.84** | **6,347,590,676.68** | **(3,478,660,686.16)** |

"Эрчим инженеринг" ХХК нь 2014 оны жилийн эцэст нийт хөрөнгийн дүн нь 6,347,590,676.68 төгрөг болж өмнөх оноос 3,478,660,686.16 төгрөгөөр буурсан байна. Үүнийг задлан үзвэл эргэлтийн хөрөнгө 3,366,942,585.26 төгрөгөөр, эргэлтийн бус хөрөнгө 111,718,100.90 төгрөгөөр тус тус буурсан байна. Эргэлтийн хөрөнгийн бууралт нь мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал тооцоо буурснаас эргэлтийн бус хөрөнгийн бууралт элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 51,552,538.90 төгрөгөөр өссөний дотор НДШ-ийн өглөг 15,873,727.18 төгрөг ХХОАТатварын өглөг 15,565,182.52 төгрөг болсон байна. Тайлант онд 770,000,000 төгрөгийн шугамын зээл авсан.

*График №1*




*График №2*




Хувийн өмч өмнөх оноос өсөөгүй.
Хуримтлагдсан ашиг 1,767,270,104.89 төгрөг ба тайлант жилд 13,282,296.59 төгрөгийн ашигтай ажилласан байна.

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ТТД320 ... 2571676
УЛААНБААТАР ХОТ

| А.Борлуулалт | 2014 он | Коэфф |
|---|---|---|
| 1.Цэвэр борлуулалт | 13,318,130,465.99 | |
| 2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 11,368,404,238.86 | |
| ***Нийт ашиг*** | ***1,949,726,227.13*** | |
| | | *Босоо шинжилгээ 2014 он* |
| 3.Үйл ажиллагааны зардал | ***2,284,296,759.07*** | ***100.00*** |
| Цалингийн зардал | 1,057,024,843.00 | 46.27 |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | 126,346,105.74 | 5.53 |
| Засвар үйлчилгээний зардал | 21,872,501.37 | 0.96 |
| Ашиглалтын зардал | 64,715,034.57 | 2.83 |
| Албан томилолтын зардал | 72,478,564.04 | 3.17 |
| Бичиг хэргийн зардал | 3,803,564.59 | 0.17 |
| Элэгдлийн зардал | 211,656,032.91 | 9.27 |
| Түрээсийн зардал | 108,482,785.58 | 4.75 |
| Зар сурталчилгаа, сурталчилгааны зардал | 19,153,411.82 | 0.84 |
| Шуудан холбооны зардал | 14,428,889.29 | 0.63 |
| Шатахууны зардал | 183,492,177.25 | 8.03 |
| Тээврийн зардал | 79,591,493.17 | 3.48 |
| Түүхий эд материалын зардал | 9,955,480.95 | 0.44 |
| Хангамжийн зардал | 14,304,166.16 | 0.63 |
| Даатгалын зардал | 19,256,261.60 | 0.84 |
| Бусад зардал | 277,735,453.03 | 12.16 |
| Үндсэн үйл ажиллагааны ашиг | **(334,570,531.94)** | |
| 4.Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 472,828,861.32 | |
| 5.Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 119,036,812.10 | |
| Ердийн үйл ажиллагааны ашиг | **19,221,517.28** | |
| 6. Хүүгийн орлого | 2,722,686.36 | |
| 7.Онцгой зардал | | |
| Татварын өмнөх ашиг | **21,944,203.64** | |
| Орлогын татварын зардал | 8,661,907.05 | |
| Цэвэр ашиг | **13,282,296.59** | |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | | |

Тайлант хугацаанд 11,318,130,465.99 төгрөгийн борлуулалтын орлого олж 11,368,404,238.86 төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг шингээж 2,284,296,759.07 төгрөгийн борлуулалт маркетингийн зардал гаргаж үндсэн үйл ажиллагаанаас алдагдалтай ажилласан байна.
Зардлыг босоо шинжилгээ хийвэл цалингийн зардал 46.27 %, НДШ-ийн зардал 5.53 %, шатахууны зардал 8.03 %, элэгдлийн зардал 9.27%, бусад зардал 12.16 % ийг эзэлж байна.

*График №3*




| Эзний өмчийн тайлан | 2014 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл | |
|---|---|---|
| Эзний үлдэгдэл | | **1,763,987,808.30** |
| Эзний өмчийн бусад хэсэг | | - |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| Нэмэгдлийн дүн | - | - |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | | |
| Тайлант үеийн ашиг /алдагдал/ | 13,282,296.59 | |
| Хуримтлагдсан ашиг эцсийн үлдэгдэл | | ***13,282,296.59*** |
| Эзний өмчийн дүн | | **1,777,270,104.89** |

Тайлант онд 13,282,296.59 төгрөгийн ашигтай ажиллаж аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 8,661,907.05 төгрөгийн татвар төлөхөөр ажилласан.
Төлбөрийн чадварын шинжилгээ: Эргэлтийн харьцааны боломжит түвшин 2 байдаг. Тус байгууллагын хувьд өмнөх оноос 0.07пунктээр өссөн боловч 1.12 байгаа нь эргэлтийн хөрөнгөөрөө эргэлтийн өр төлбөрөө төлөх чадвар төдийлөн сайн биш байгааг харуулж байна. Түргэн борлогдох хөрөнгийн харьцаа зохистой түвшингээс 0.35 пунктээр доогуур байна.

| Шинжилгээний үзүүлэлтүүд | 2013 он | 2014 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Эргэлтийн харьцаа= Эргэлтийн хөрөнгө/ Эргэлтийн өр төлбөр 2 | 1.05 | 1.12 | (0.07) |
| Түргэн борлогдох хөрөнгийн харьцаа=(Эргэлтийн хөрөнгө-БМ)/Эргэлтийн өр төлбөр=0.8-1 | 0.93 | 0.58 | 0.35 |
| **2. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ** | | | |
| Бие даах чадварын коэфф=Өөрийн капитал/Балансын дүн | 0.18 | 0.28 | (10.05) |
| Өрийн харьцаа=Нийт өр төлбөр/Нийт хөрөнгө | 0.82 | 0.72 | 10.05 |
| Өр эзэмшигчийн харьцаа=Урт хугацаат өр/Эзэмшигчийн өмч | - | - | - |
| Гадны капиталын хувийн жин=Гадны капитал/Нийт хөрөнгө | 0.82 | 0.72 | 10.05 |
| *Альтманы индекс:* | | | |
| $K_1$=Хүү+ТӨА/Нийт хөрөнгө | 0.00 | | |
| $K_2$=Борлуулалтын орлого/Нийт хөрөнгө | 2.10 | | |
| $K_3$=Өөрийн капитал/Гадны капитал | 0.39 | | |
| $K_4$=Цэвэр ашиг/Нийт хөрөнгө | 0.00 | | |
| $K_5$=Өөрийн эргэлтийн капитал/Нийт хөрөнгө | 0.81 | | |
| $Z=3.3*K_1+1*K_2+0.6*K_3+1.4*K_4+1.2*K_5$ (Z>2.675 муу, 2.675<Z тогтвортой) | 3.31 | | |
| **3. Эргэлтийн шинжилгээ** | | | |
| АЭ(өдөр)=360/(Бор.ор/Ав. Дун Үлд) | 22.46 | | |
| НЭ(өдөр)=360/(БББӨ/БМҮБЗ дун.үлд) | 31.94 | | |
| Эрг. Хөр эргэц(өдөр)= 360/(Бор.ор/Ав. Дун үлд) | 138.58 | | |
| Нийт хөрөнгийн ачаалал=Бор.ор/Баланс дүн | 2.10 | | |
| Өглөг эргэц=360/(Тэлэхүүрх хулдалдан авалт/Өглөг дундаж дүн) | 1,421.11 | | |
| Санхүүгийн цикл=АЭ+НЭ-АЭ | 192.98 | | |
| **4. Үндсэн хөрөнгийн шинжилгээ** | | | |
| ҮХ хувийн жин=Нийт ҮХ өртөг/Балансын дүн | 0.19 | | |
| **5. Ашигт ажиллагааны шинжилгээ** | | | |
| Бор.А.А=Цэвэр ашиг/Бор.орлого | 0.00 | | |
| Хөр.А.А=Цэвэр ашиг/Балансын дүн | 0.00 | | |
| Өөрийн капитал А.А=Цэвэр ашиг/өөрийн капитал | 0.01 | | |

График №4




Бие даах чадварын коэффициент өмнөх оноос өссөн байна
Нийт өр төлбөрийн нийт хөрөнгөтэй харьцсан харьцаа буурсан

График №5




Альтманы индексээр санхүүгийн байдал 2.675 -аас дээш байвал тогтвортой гэж үздэг. Тус байгууллагын хувьд 3.31 байгаа нь санхүүгийн байдал тогтвортой байгааг харуулж байна

Санхүүгийн эргэц 192.98 хоног 1 эргэдэг гэж байгаа эргэлтийн хөрөнгийн эргэц удаан байгаагаас шалтгаалсан байна

Ашигт ажиллагааны шинжилгээ: 1 төгрөгийн борлуулалтанд, нийт хөрөнго, өөрийн хөрөнгөнь түн бага буюу 0.001 хувиар өссөн байна

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

4.Бүтээмжийн шинжилгээ

Хүснэгт № 4

| Шинжилгээний үзүүлэлтүүд | 2013 он | 2014 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Э 3 тогтвортой өсөлт коэфф=(цэвэр ашиг-ногдол ашиг)/өөрийн капитал | 0.01 | 0.00 | 0.01 |
| 5.Үндсэн хөрөнгийн шинжилгээ | | | |
| ҮХ хувийн жин=Нийт ҮХ ийн өртөг/Балансын дүн | 0.13 | 0.18 | (5.31) |
| ҮХ үйлдвэрийн зориулалт=үйлдвэрийн зориулалт/Нийт ҮХ өртөг | | | |
| ҮХ элэгдлийн коэфф=ҮХ хур элэгдэл/ҮХ балансын үнэ | | | |
| 6.Ашигт ажиллагааны шинжилгээ | | | |
| Бор ашигт ажиллагаа=Цэвэр ашиг/Бор Орлого | 0.00 | 0.001 | - |
| Хөрөнгийн ашигт ажиллагаа=Цэвэр ашиг/Балансын дүн | 0.001 | - | 0.00 |
| Өөрийн капитал А.А=Цэвэр ашиг/өөрийн капитал | 0.01 | - | 0.01 |
| 7.Мөнгөн урсгалын шинжилгээ | | | |
| АК ба бор харьцаа=АК/Бор ор | 0.03 | 0.04 | (0.01) |
| АК ба хөр харьцаа=АК/Балансын дүн | 0.04 | 0.09 | (0.04) |

График № 6




Нийт хөрөнгийн 5.31 хувийг үндсэн хөрөнгө эзэлж байна.

Ажлын капитал борлуулалтын орлогын харьцаа нь 0.01 пункт

[...]гээр, ажлын капитал нийт хөрөнгийн харьцаа нь 0.04 пунктээр тус тус өссөн байна.

Санхүүгийн тайланд шинжилгээ хийсэн:

Аудитор: /Т.Энхмаа /

СЗХ
Он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 3.8.8 АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

GOLOMT BANK
Committed to and Investing in Excellence

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД

Head Office Of Golomt Bank,
Great Chinggis Khaan's Square 5, P.O Box 22,
Ulaanbaatar 15160, Mongolia
Phone: +(976)-7011-1646, 1800-1646, Fax: +(976) 11 313155
E-mail: mail@golomtbank.com, Web: www.golomtbank.com

2015.07.06 № 01/179

### "ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ" ХХК-ИЙН ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ БОНДОД ӨГӨХ АНДЕРРАЙТЕРЫН ДҮГНЭЛТ

"Эрчим Инженеринг" ХХК /цаашид "Үнэт цаас гаргагч" гэх/ нь тендерийн төслийн ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор "Голомт Банк" болон "Голомт Секюритиз ҮЦК"- /цаашид "Андеррайтер" гэх/-тай 2015 оны 5 дугаар сард "Соёмбо Даатгал" ХХК /цаашид "Даатгагч" гэх/-ийн хамтаар анхны уулзалтыг хийсний дагуу Голомт Банк нь Эрчим Инженеринг ХХК болон Соёмбо Даатгал компанийг тус тусад нь судлан, банкны журмын дагуу холбогдох эрсдлийн түвшинг дүгнэж үзсэн болно. Судалгааны үр дүнд үнэт цаас гаргагчид богино хугацаат өрийн бичиг буюу бондыг даатгалтайгаар гарган эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, Даатгагч нь уг бондыг 100 хувь даатган баталгаажуулах боломжтой гэж үзсэн.

Бондыг даатгагч Соёмбо Даатгал ХХК нь 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос "Бондын баталгааны даатгал"-ын бүтээгдэхүүнээ бүртгүүлсэн бөгөөд энэ дагуу Эрчим Инженеринг ХХК болон Соёмбо Даатгал ХХК-ийн хооронд "Бондын даатгалын гэрээ" (дугаар:10С1500089) байгуулагдсан. Мөн Эрчим Инженеринг ХХК болон Голомт Банкны хооронд мөн "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ" (дугаар: ГБ-41) байгуулагдсан. Голомт Банк нь энэхүү бондыг гаргах үйл ажиллагаанд Үндсэн Андеррайтераар, мөн Голомт Секюритиз ҮЦК нь туслах андеррайтераар ажиллалаа

Голомт Банк болон Эрчим Инженеринг ХХК-ийн хооронд байгуулагдсан "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ"-нд бондын анхдагч зах зээл дээр арилжигдсанаас үлдсэн хэсгийг Андеррайтер өөрөө худалдан авахаар тусгагдсан болно.

Энэхүү бондын бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10.8.1, Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 2014/05 тоот тогтоолоор баталсан "Бүртгэлийн журам" болон Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ын 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "МХБ ТӨХК-ийн арилжааны журам"-ын дагуу явагдана.



000118

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ТТД 320 2571676
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Олон нийтэд үнэт цаас санал болгон хөрөнгө оруулалт татах бэлтгэл ажлын хүрээнд Үнэт цаас гаргагч нь дараах бэлтгэл ажлуудыг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч нь хэрэгжүүлж буй тендерийн ажлын БЗА-2010/55-ИШС/ТГ-05 дугаартай гэрээнд заасан ажил үйлчилгээний үлдэгдэл төлбөрийг холбогдох талаас нэхэмжилсэн байгаа ба уг төлбөрөөс энэхүү бондын эргэн төлөлтийг хийхээр төлөвлөсөн.

2. Үнэт цаас гаргагч нь мөн дээрх төлбөрийн орж ирэх цаг хугацааны эрсдлийг Соёмбо Даатгал ХХК-аар даатгуулж, "Бондын даатгалын гэрээ"-г байгуулсанаар бондын эргэн төлөлтийг бүрэн баталгаажуулсан.

3. Үнэт цаас гаргагч нь өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХНН хуулийн компанитай гэрээ байгуулан энэхүү бондыг анхдагч зах зээлд санал болгоход хууль зүйн шинжилгээ (due diligence) хийх, үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хууль зүйн дүгнэлт гаргах, үйлчлүүлэгчийн дүрэм, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, бонд гаргахтай холбоотой гэрээ хэлцэл, шаардлагатай бичиг баримт хуульд нийцсэн эсэхийг хянах зэрэг ажил үйлчилгээг хийж гүйцэтгүүлсэн.

4. Үнэт цаас гаргагч нь Ай Жэй Эйч ХХК болон Эвиденс Аудит ХХК-уудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж Үнэт цаас гаргагчийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргуулж, мөн компанийн нийт хөрөнгийн үнэлгээг хийлгэсэн.

Энэхүү бондыг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжих ажлын хүрээнд Андеррайтер нь дараах үндсэн чиглэлүүдээр холбогдох судалгаа шинжилгээний ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

1. Компанийн бизнесийн тухай болон өнөөгийн байдлын судалгаа, танилцуулга
2. Салбарын өнөөгийн байдал болон хууль эрх зүйн орчин
3. Компанийн санхүүгийн байдлын талаар нарийвчилсан дүгнэлт, шинжилгээ
4. Даатгалын компанийн санхүүгийн байдал, холбогдох эрсдлийн шинжилгээ
5. Бондын үнийг тогтоох, түүнтэй холбоотой судалгаа шинжилгээ
6. Бондын борлуулалтын төлөвлөгөө боловсруулж, хөрөнгө оруулагчдыг олж тогтоох
7. Бондыг гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, үр ашгийн тооцоо
8. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн хүчин зүйлсийн шинжилгээ

Дээрх судалгаа, шинжилгээнд тулгуурлан Андеррайтер нь энэхүү "Эрчим бонд" –ын нийтэд танилцуулах үнэт цаасны танилцуулгыг бэлтгэн гаргалаа.

Мөн боломжит хөрөнгө оруулагчдын талаар судлан, урьдчилсан танилцуулга хийсэн бөгөөд томоохон багцыг худалдан авах сонирхолоо илэрхийлсэн хөрөнгө оруулагчтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулаад байна. Тухайлбал, Тэтгэврийн Ууган Сан ТББ нь энэхүү бондоос 200 сая төгрөг хүртэлх хэмжээгээр худалдан авах сонирхолоо илэрхийлж, Андеррайтертай санамж бичиг байгуулсан.

СЗХ
оч сар
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаас гаргагчийн энэхүү бондыг гаргах төсөл дээр үндсэн андеррайтерийн зүгээс Голомт банкны Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал Ж.Хишигжаргал, Бүтцэт санхүүжилтийн хэлтсийн захирал О.Оч, тус хэлтсийн аналист Б.Тэнгис, Б.Уянгаа, Байгууллагын санхүүжилтийн хэлтсийн хөрөнгө оруулалтын менежер Б.Мядагмаа, Б.Сугарсүрэн нар, туслах андеррайтерын зүгээс Голомт Секюритиз ҮЦК-ийн Гүйцэтгэх захирал Э.Амарбаясгалан, хөрөнгө оруулалтын менежер Д.Мөнхбат, хөрөнгө оруулалтын менежер О.Уянга нар ажилласан болно.

**Андеррайтерын үйлчилгээний хүрээнд хийсэн судалгаа шинжилгээнүүдээс бид дараахь дүгнэлтүүдийг гаргалаа. Үүнд:**

*Компанийн бизнес, үйл ажиллагааны талаар*

"Эрчим-Инженеринг" ХХК нь 1999 оноос хойш эрчим хүчний салбарт зураг төсөл, зөвлөх үйлчилгээ, ЦДАШ, дэд станцын барилгын угсралтын ажлыг амжилттайгаар хийж гүйцэтгэж байна. Тус компанийн үндсэн үйл ажиллагаа нь нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн бөгөөд үйл ажиллагаа эрхэлж буй эрчим хүчний салбар нь төрийн зохицуулалттай салбар тул хийгдэж буй ажлууд нь ихэнхдээ улсын захиалгатай, улсын төсвөөс тендерийн санхүүжилтээр хийгдэх ажлууд байдаг.

"Эрчим-Инженеринг" ХХК-ийн хувьд ЦДАШ, ЦДШ, дэд станц барилга угсралтын ажлуудыг идэвхтэй явуулах тохиромжтой цаг үе нь жил бүрийн 4 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл байдаг ба энэ үеэр тендерийн ажлын санхүүжилт тасралтгүй байх шаардлагатай байдаг. Гэвч жил бүр улсын төсвийн алдагдлаас хамааран тухайн оны тендерийн ажлын санхүүжилт 12 дугаар сар хүртэл хойшлох, цаашлаад дараа оны 1 дүгээр сар хүртэл хойшлох магадлалтай байдаг.

Дээрх болзошгүй асуудлуудаас урьдчилан сэргийлэх, үүссэн ч түүний үзүүлэх нөлөө, үр дагаврыг бага байлгах арга зам нь бүтээн байгуулалтын ажлыг эрчимтэй хэрэгжүүлэх цаг үеийг алдалгүйгээр хүлээгдэж буй санхүүжилтийг богино хугацаатай компанийн өрийн бичгийг даатгалтайгаар гаргах замаар шийдвэрлэх боломжтой байна.

*Салбарын өнөөгийн байдал ба хууль эрхзүйн орчны талаар*

Эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх дунд хугацааны эрчим хүчний үндэсний хөтөлбөрт их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан мега төслүүд, дунд хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан орон нутгийн чанартай эх үүсвэр, түгээх шугам сүлжээ, дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлтийн төслүүд, бага хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан судалгаа тооцоо, гэрээ хэлэлцээр, сургалт сурталчилгаа зэрэг зохион байгуулалтын төсөл арга хэмжээ багтаж байна.

Эрчим хүчний салбарт 2030 он гэхэд 10.26 тэрбум ам.доллар хөрөнгө оруулалт шаардагдах урьдчилсан тооцоо гарч байгаа бөгөөд үүнд (i) Төвийн эрчим хүчний системд нэмэгдэх цахилгаан, дулаан хосолсон үйлдвэрлэлийн чадал 4.0 тэрбум ам.доллар, (ii) Улаанбаатарын



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

зардлын 46.3 хувийг цалингийн зардал, 5.5 хувийг нийгмийн даатгалын зардал эзэлж байна. Энэ нь хүч их ихээхэн шаардсан барилга угсралтын гүйцэтгэлийн ажил үйлчилгээ үзүүлж байгаатай холбоотой юм. Мөн элэгдлийн зардал нь нийт үйл ажиллагааны зардлын 9.3 хувь, шатахууны зардал 8 хувь, бусад зардал 12.2 хувь байгаа нь үйл ажиллагааны зардал дотроо томоохон хувийг эзэлж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан болон зардлын тухай дэлгэрэнгүй задаргааг үнэт цаасны танилцуулгаас үзэх боломжтой.

*Үнэт цаас гарган хуримтлуулах хөрөнгийн зарцуулалтын талаар*

"Эрчим-Инженеринг" ХХК нь олон нийтэд нээлттэй арилжих замаар бонд гарган хямдруулсан үнээр худалдан 450 сая орчим төгрөг босгох төлөвлөгөөтэй байгаа ба уг бондын хөрөнгөөр тендерийн ажлыг тохиромжтой улиралыг алдалгүй хэрэгжүүлэх, ажилчдын цалин зэрэг төслийн гүйцэтгэлтэй холбогдон гарах зардлуудаа санхүүжүүлэх зорилготой. Тус компани нь 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр төслийн ерөнхий гүйцэтгэгч "Бээжин констракшин ХХК", туслан гүйцэтгэгч "ENCC" ХХК–руу 840 мянган ам.долларын төслийн санхүүжилтийг авах хүсэлтээ өгсөн. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээс уг төслийн санхүүжилтийн орж ирэх хугацаа одоогоор тодорхойгүй байгаа учраас бондын санхүүжилтээр тендерийн төслийн барилга угсралтын ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх боломжтой байна.

*Бондын эргэн төлөлтийн талаар*

Бонд гаргагч нь холбогдох тендерийн санхүүжилт нь бондын хугацааны туршид орж ирнэ гэж үзэж байгаа ба энэхүү бондын эргэн төлөлтийн хугацаа хоцрох эрсдлийг даатгагч компани болох Соёмбо Даатгал ХХК нь 100 хувь батлан дааж байгаа болно.

Бид тус компанийн 2015 оны эцэс хүртэлх борлуулалт, ашгийн таамаглалыг хийсэн бөгөөд ингэхдээ 2015 оны 11 дүгээр сард урьдчилгаа төлбөрийг орж ирнэ гэсэн хүлээлттэйгээр тооцооллыг хийж, бондын хугацааны туршид компанийн мөнгөн гүйлгээнд гарах өөрчлөлтүүдийг тооцон гаргасан. Бидний тооцооллоор бонд гаргагч "Эрчим Инженеринг" ХХК нь бондын төлбөрийг бондын хугацаа болох үед төлөх боломжтой харагдаж байна. Таамаглал тооцоог үнэт цаасны танилцуулгаас үзнэ үү.

*Компанийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн хүчин зүйлсийн талаар*

Макро болон Микро эдийн засгийн нөлөөлөлд аж ахуйн үйл ажиллагаагаа буруу тооцоолох, макро орчны хүчин зүйлсийг дутуу үнэлэх нь компанийн үйл ажиллагаанд эрсдэлийг учруулна. Тус компанийн аж ахуйн үйл ажиллагаанд дараах төрлийн эрсдэл учирч болзошгүй. Зах зээлийн эрсдэлийг урьдчилан таамаглах төвөгтэй учир үнэ, макро орчны судалгаа, үнэ ханшийн талаар тогтмол судалгаа хийж байх шаардлагатай.

- Макро эдийн засгийн нөлөөллийн хүчин зүйлс



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Макро эдийн засгийн нөлөөллийн хүчин зүйлсэд инфляци, татвар, тоног төхөөрөмжийн үнэ ханшийн эрсдэл, валютын ханшийн тогтворгүй байдал, харилцагч байгууллагуудын ажлын уялдаа холбооноос шалтгаалсан хүндрэл, улс орны эдийн засгаас шалтгаалж төсвийн санхүүжилт хойшлох зэрэг эрсдэлүүд багтаж байна.

- Байгаль, цаг уураас хамааралтай эрсдэл

Монгол улс нь эрс тэс уур амьсгалтай орон юм. Үүний улмаас барилга угсралт, ЦДАШ, дэд станцын барих зэрэг бүтээн байгуулалт нь хавар 4 дүгээр сараас намар 11 дүгээр сарын хооронд үргэлжлэх боломжтой юм. "Эрчим-Инженеринг" ХХК-ийн үйл ажиллагаа нь зуны улиралд эрчимтэй байдаг ба өвөл улирлын нөлөөнөөс шалтгаалж сул зогсолттой байдаг. Мөн зуны улиралд байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас ажлын төлөвлөгөө хойшлох, цаг хугацаа алдах эрсдэлүүд үүсэж болзошгүй.

- Компанийн үйл ажиллагааны эрсдэл

*Ажлын гүйцэтгэлийн чанарын эрсдэл*

Компанийн ажлын гүйцэтгэлийг захиалагч нь ажлын явцын дунд болон ажлын гүйцэтгэлийг бүрэн хийгдсэн үед үнэлэн санхүүжилтийг гүйцэтгэл дээр тулгуурлан өгдөг. Компани нь 19 жилийн турш үйл ажиллагаагаа явуулж буй туршлагатай компани юм. Дотоодын үйл ажиллагаа болоод ханган нийлүүлэгчийн тоног төхөөрөмжийн чанар, тээвэрлэлтийн үеийн гэмтэл зэрэг гадаад хүчин зүйлсээс хамааран ажил, үйлчилгээний гүйцэтгэлд чанарын эрсдэл учирах боломжтой.

*Компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл*

Салбарын нийтлэг сул тал болох эцсийн захиалагч буюу тендер зарлагч эсвэл ерөнхий гүйцэтгэгчээс шалтгаалан санхүүжилт хойшлогдох, цаг хугацаандаа төлбөрөө төлөхгүй байх зэргээс үүдэлтэй өрийн сүлжээ үүсэх, үйл ажиллагаа доголдох эрсдэл бий.

**Мөн ажил үйлчилгээ захиалагч, хүлээн авагч нь ихэнх тохиолдолд бараа, үйлчилгээ худалдан авах тендер зарлан, нээлттэй сонгон шалгаруулалт хийх журмаар ажил, үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулдаг. Энэ нь компанид өрсөлдөөний улмаас ажил, үйлчилгээний хөлсийг бууруулах, улмаар төлөвлөсөн борлуулалтын хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлийг бий болгодог.**

Валютын ханшны тогтворгүй байдал нь санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөөлж байна. Импортын бараа, тоног төхөөрөмжийн үнэ валютын ханшийн өсөлтийн улмаас компанийн санхүүгийн төлөвлөгөө, төсөв гэнэтийн алдагдалд орох эрсдэлтэй. Мөн сэлбэг материалын үнэ огцом өсснөөс төсөвлөсөн зардал хэтэрч, ашиг буурах, үүнээс үүдээд зардлын өсөлт бий болж үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийн дутагдалд орох эрсдэл бий.



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

*Хүний нөөц, удирдлагын үйл ажиллагааны эрсдэл*

Мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулж, удирдлагаар хангах нь харилцагч, худалдан авагч, захиалагч нараа алдахгүй байх, улмаар зах зээл дээрх нэр хүндээ алдахгүй байх нөхцлийг бүрдүүлж байдаг. Удирдлагын ажлын чиг, баг бүрдүүлэлт хүний нөөцийн асуудлаас шалтгаалан компанийн борлуулалт, мөнгөн урсгалд эрсдэл үүсэх боломжтой.

- Улс төрийн бодлого, шийдвэрийн эрсдэл

Засгийн газрын нийгэм эдийн засаг хэрэгжүүлж буй бодлого шийдвэрүүд компанийн үйл ажиллагаа , тендерийн ажил, борлуулалтанд нөлөөлөх магадлалтай. Тухайлбал төр засгийн тогтворгүй байдлаас шалтгаалж салбарын хууль эрх зүйн орчинд өөрчлөлт орох, байгуулагдсан тендер, концессийн гэрээ цуцлагдах, эдийн засгийн хямралын улмаас төрөөс хийх салбарын хөрөнгө оруулалт буурах, санхүүжилт зогсох, улс төрийн шалтгаанаар улсын төсвийн зардал нэмэгдэх, ингэснээр төсвийн алдагдал нэмэгдэж, тендерийн санхүүжилтэнд нөлөөлөх зэрэг багтана.

Татварын орчинд гарсан аливаа өөрчлөлт нь мөн хөрөнгө оруулагчдад очих цэвэр өгөөжид нөлөөлөх боломжтой. Гэвч энэхүү бондын хугацаа болох 6 сарын туршид дээрх эрсдлүүд, ялангуяа татварын эрсдэл гарах магадлал харьцангуй бага гэж үзэж байна.

- Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбогдон үүсэж болох эрсдэл

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2005 оноос хойш нийт 8 компанийн бондыг нээлттэй арилжаагаар Монголын хөрөнгийн бирж дээр гарган нийт 7.01 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнээс сүүлийн 3 жил буюу 2012 оноос хойш компанийн бонд арилжигдаагүй байна. Компанийн үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр гадаад, дотоодын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлаас үүдэн шинээр гаргаж буй бондын үнэ ханш буурах, борлогдохгүй байх эрсдэлтэй. Гэвч энэхүү бонд нь урьд өмнө гарч байсан тэдгээр бондуудаас ялгаатай бөгөөд 100 хувь даатгагдсан, үнийн хувьд ижил төстэй санхүүгийн хэрэгслүүдээс өндөр учраас хөрөнгө оруулагчдын дунд эрэлттэй байх боломжтой.

- Төлбөрийн чадварын эрсдэл .

Бонд гаргагч нь энд дурьдагдсан эрсдлийн хүчин зүйлсээс шалтгаалан бондын үндсэн төлбөрийг цаг хугацаанд нь төлөх боломжгүй байх эрсдэл бий. Гэвч энэхүү эрсдэлийг даатгалын гэрээгээр шийдвэрлэж байгаа болно. Энэхүү эрсдлийг даатгаж байгаа даатгалын компани болох Соёмбо Даатгал нь уг эрсдэл үүсэх нөхцөл байдал бий болсон тохиолдолд холбогдох нөөцийн санг бүрдүүлж ажиллана.

- Бусад эрсдэл



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Мөнгөний үнэгүйдлээс шалтгаалж хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй бондын бодит үнэ цэнэ, хүүгийн бодит орлого буурах эрсдэл байдаг. Энэхүү эрсдэлийг таамаглах, бууруулах, зайлсхийхэд хүндрэлтэй байдаг.

Дээр дурдсан бүх эрсдэлүүд нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөнөөс хамааран учирч болох эрсдэлүүд юм.

**ДҮГНЭЛТ**

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 7\3201 тоот албан бичгээр "Бондын баталгааны даатгал"-ын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн шинэлэг алхам болж байгаа бөгөөд энэхүү "Эрчим Бонд" нь даатгалаар баталгаажсан гэдгээрээ Монголын Хөрөнгийн зах зээлд анх удаа гарч буй шинэ бүтээгдэхүүн болж байна.

Бид андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн дээрх болон бусад судалгаа шинжилгээ, тооцоо, мөн үнэт цаас гаргахтай холбогдуулан бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлтүүдэд үндэслэн "Эрчим Инженеринг" ХХК-ийн энэхүү бондыг даатгалын баталгаатайгаар олон нийтэд санал болгох боломжтой гэж үзсэн бөгөөд энэхүү "Эрчим Бонд"-ыг анхдагч зах зээлд нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэйгээр 50,000 ширхэгийг 6 сарын хугацаатай, жилийн 18.50 хувийн хүүтэй, хямдруулсан үнэтэйгээр олон нийтэд санал болгох нь тохиромжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

**Дүгнэлтийг гаргасан:**

ГОЛОМТ БАНК
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ГАЗАР
ЗАХИРАЛ — Ж. ХИШИГЖАРГАЛ

**Хянаж баталгаажуулсан:**

**ГОЛОМТ БАНК**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ** — Л. ОЮУН-ЭРДЭНЭ



ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ТТД 2571676
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 3.10. БОНДЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

БАТЛАВ :

СОЁМБО ДААТГАЛ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.БАТТУЛГА

(Гарын үсэг)

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ М.БАТБОЛД

(Гарын үсэг)

**БОНДЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ**

2015 оны 6 дугаар сарын
25-ны өдөр

Дугаар 1001500089 Улаанбаатар хот

Энэхүү Даатгалын гэрээ (цаашид 'Гэрээ' гэх)-г Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг тус тус баримтлан нэг талаас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 хороо, Ажилчны гудамж, Чин тайх ХХК-ийн байр, 2 давхар хаягт орших төсөл хэрэгжүүлэгч Эрчим инженеринг ХХК (цаашид 'Даатгуулагч' гэх), нөгөө талаас Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль тогтоомжийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Улаанбаатар хот 14240, Олимпийн гудамж, Гранд оффис 2 тоот хаягт орших Соёмбо Даатгал ХХК (цаашид 'Даатгагч', хамтад нь 'Талууд' гэх) нар дараах нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Гэрээний зорилго нь Даатгагч нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажил, үйлчилгээ хийж гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтанд шалгарсан болон бусад төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй Даатгуулагчид төслийн хэрэгжилтэнд шаардлагатай эх үүсвэр татах үүднээс Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргасан бондод Сангуулийн баталгаа гаргаж, түүнд учирч болзошгүй эрсдлүүдээс Хөрөнгө оруулагч буюу бонд худалдан авагчийг хамгаалж, даатгал хийлгүүлэнтэй холбогдон үүсэх бусад харилцаа болон талуудын эрх, үүргийг зохицуулна

1.2 Энэхүү гэрээнд холбогдох даатгалын харилцаа нь Иргэний хуулийн 441 дүгээр зүйлд заасан Бусад этгээдэд ашигтайгаар даатгах даатгалд хамаарах бөгөөд Даатгуулагч өөрийн нэрийн өмнөөс Хөрөнгө оруулагчид ашигтайгаар Бондын баталгааны даатгалын гэрээ байгуулах бөгөөд энэхүү гэрээний үндсэн дээр даатгалын тохиолдол үүсч, даатгалын нөхөн төлбөр хийгдэх тохиолдолд түүнийг хүлээн авах эрхийг ашиг сонирхол нь даатгагдсан этгээд буюу Хөрөнгө оруулагч эдлэх боловч Иргэний хуулийн 433 дугаар зүйлд заасан даатгалын баталгаа олгохыг гагцхүү Даатгуулагч шаардах эрхтэй байна. Энэ тохиолдолд Хөрөнгө оруулагчид олгосон даатгалын нөхөн төлбөрийг Даатгагч энэ гэрээнд заасны дагуу Даатгуулагчаас шаардах эрхтэй байна

1.3 Талууд нь энэхүү гэрээнд заасан Бондын даатгалын нөхцлийг мөрдөж ажиллана

**Хоёр. Хэрэглэгдэх нэр томьёо**

2.1 Энэхүү гэрээнд хэрэглэгдэх дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1 **'Бондын даатгал'** гэж Монгол Улсын 'Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажил, үйлчилгээ хийж гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтанд шалгарсан этгээд, түүнд гэрээний үндсэн дээр туслан гүйцэтгэгчээр ажил үйлчилгээ үзүүлж буй этгээд болон бусад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч Даатгуулагчид төслийн хэрэгжилтэнд шаардлагатай эх үүсвэр төвлөрүүлэх

СЗХ
Он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

хүлээж гаргасан бондыг Санхүүгийн баталгаа гаргах хууль, үнэт бололцоогүй эрсдлүүдээс хамгаалахыг;

2.1.2 **'Захиалагч'** гэж Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 3.1.5-д заасан төсөл хэрэгжүүлэгч, төслийг гүйцэтгэгч авч ажиллуулж буй тендерт шалгарсан этгээд;

2.1.3 **'Бондын төлбөр'** гэж Бондын үндсэн төлбөр болон хүүний нийлбэр, хамруулсан бондын хувьд Бондын хугацааны эцэст төлөгдөх Бондын нэрлэсэн дүн;

2.1.1 **'Даатгагч'** гэж МУ-ын Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан Соёмбо Даатгал компанийг;

2.1.2 **'Даатгуулагч'** гэж төсөл хэрэгжүүлэгч буюу бонд гаргагч бондын баталгаа гаргуулж буй хуулийн этгээд болох Эрчим инженеринг ХХК-ийг;

2.1.3 **'Даатгалын зүйл'** гэж Бондийн даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг;

2.1.4 **'Даатгалын тохиолдол'** гэж Даатгуулагч нь Хөрөнгө оруулагчдад төлөх бондын төлбөрийг хугацаанд нь төлж чадахгүй болсныг;

2.1.5 **'Даатгалын үнэлгээ'** Бондийн баталгааны үнийн дүн буюу энэхүү гэрээний 2.1.3-т заасан бондын төлбөр болон түүнийг Хөрөнгө оруулагчдад олгохтой холбогдон гарах бусад зардлуудын нийлбэрийг;

2.1.6 **'Даатгалын хураамж'** гэж Даатгуулагч даатгалын даатгуулсны төлөө даатгагчид төлөх энэхүү гэрээний 3.3-т заасны дагуу тодорхойлсон Бондийн баталгааны даатгалын хураамжийг;

2.1.7 **'Даатгалын нөхөн төлбөр'** гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүсэн нөхцөлд Даатгагчаас Хөрөнгө оруулагчдад олгох зорилгоор Даатгуулагчийн ҮЦТТТХТ дах дансанд шилжүүлэх мөнгөн хөрөнгө буюу даатгалын тохиолдол бий болсон өдрийн байдлаарх төлөгдөөгүй байгаа бондын төлбөрийг;

2.1.8 **'Хөрөнгө оруулагч'** гэж бонд эзэмшигч буюу даатгалын тохиолдол үүсэхэд даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авах эрх бүхий этгээдийг;

2.1.9 **'Андеррайтер'** гэж Даатгуулагчийн гаргаж буй бондыг нийтэд санал болгон арилжаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй этгээд болох Голомт банк, түүний хамтран гүйцэтгэгчийг;

2.1.10 **'Даатгалын хугацаа'** гэж энэ гэрээний 4.2-т заасан бондийн баталгааны даатгалын хугацааг;

2.1.11 **'ҮЦТТТХТ'** гэж Үнэт Цаасны Төлбөр Тооцоо, Төвлөрсөн Хадгаламжийн Төвийг хэлнэ.

**Гурав. Даатгалын эрсдэл, үнэлгээ, хураамж**

3.1 Бонд гаргагч буюу Даатгуулагч нь Хөрөнгө оруулагчдад бондын нөхцлийн дагуу бондын төлбөрийг хугацаанд нь төлж чадахгүй болсныг даатгалын эрсдэл буюу даатгалын тохиолдол гэж тооцно. Үүнд:

3.1.1 Захиалагчийн талаас графикт санхүүжилтыг хугацаанд нь шилжүүлэхгүй саатуулснаас үүдэн энэхүү гэрээний 4.2-т заасан хугацаа болох үед Даатгуулагч бондын төлбөрийг төлөх боломжгүй болох;

3.1.2 Бонд гаргагчийн талаас Захиалагчийн өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэж чадаагүйгээс энэхүү гэрээний 4.2-т заасан хугацаа болох үед Даатгуулагч бондын төлбөрийг төлөх боломжгүй болох.

3.1.3 Дээр дурьдсанаас бусад шалтгаанаар 'Force majeure' үүнд хамаарахгүй буюу Даатгуулагчийн буруутай (хариуцлагагүй) үйлдлээс үүдэн энэхүү гэрээний 4.2-т заасан хугацаа болох үед Даатгуулагч нь Бондын төлбөрийг төлөх боломжгүй байх.

3.2 Даатгуулагч нь Бондийн төлбөрийг төлж чадахгүй нөхцөл шалтгаан үүсэн тухай энэхүү гэрээний 4.2-т заасан хугацаа болохоос 15-аас доошгүй хоногийн өмнө Даатгагчид бичгээр мэдэгдсэнээр нөхөн төлбөр төлөх нөхцөл бүрдэнэ.

3.3 Бондийн даатгалын хураамж нь доор дурдсан хувь хэмжээгээр байх ба Даатгуулагч нь даатгалын хураамжийг 3.4-т заасан тухай бүр Даатгагчид төлнө.

2

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 31

Үнэт цаасны танилцуулга

| Даатгалын үнэлгээ | Даатгалын хураамж |
| --- | --- |
| Энэхүү гэрээний 2.1.5-д заасныар | [redacted] |

3.4 Хураамжийг дараах графикын дагуу төлнө
3.4.1 Урьдчилгаа төлбөр 30% гэрээ байгуулсанаас хойш ажлын 7 хоногийн дотор
3.4.2 2 дахь төлбөр 30% компанийн Бонд гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор,
3.4.3 3 дахь төлбөр 40% компанийн Бонд гарснаас хойш 3 сарын дотор

227

## Дөрөв. Даатгалын гэрээний хугацаа

4.1 Энэхүү гэрээ нь 2015 оны [redacted] дугаар сарын [redacted]-ны өдрөөс эхлэн [redacted] жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ
4.2 Бондын баталгааны даатгалын хугацаа нь бонд хөрөнгийн бирж дээр арилжигдсан үеэс эхлэн бондын төлбөр төлөх хүртэлх хугацаа байна
4.3 Энэхүү гэрээг Даатгагч, эсхүл Даатгуулагчийн санаачлагаар цуцлах боломжгүй
4.4 Даатгагч эсхүл Даатгуулагч төлбөрийн чадваргүй болох нөхцөл үүсвэл бол нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй
4.5 Энэхүү гэрээний 4.4-т заасан нөхцөл үүсч, Даатгагч, Даатгуулагчийн аль нэг нь дампуурсан бол Хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн талуудын үүрэг хүчин төгөлдөр хэвээр үргэлжлэх ба үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж буй тал нь Бондын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах үүрэг хүлээнэ

## Тав. Даатгагчийн эрх

5.1 Даатгуулагчаас бонд гаргах төсөлтэй холбоотой гэрээ болон шаардлагатай баримт бичгийг шаардах,
5.2 Даатгалын зүйлд даатгалын тохиолдол бий болох эрсдэл гэрээ байгуулагдах үеэс нэмэгдсэн, ийнхүү нэмэгдэх нөхцөл орчин бүрдсэн тохиолдолд даатгалын хураамжийн хувь хэмжээг өөрчлөх буюу нэмэлт баримт, шаардлагатай этгээдийн баталгаа гаргуулах,
5.3 Даатгалын тохиолдол бий болсон тохиолдолд түүний шалтгаан, нөхцөлийг судлах, гэрээний 9.3-т заасан шаардлагатай мэдээ, мэдээллийг Даатгуулагчаас гаргуулах, шаардах.
5.4 Нөхөн төлбөрийн талаар бүрэн дүүрэн үнэлэлттэй үнэн зөв мэдээллийг Даатгуулагчаас гаргуулан авах, шаардлагатай бол Даатгуулагчийн ажилтнуудаас тооцоолол ариглалтын талаар мэдээлэл, холбогдох баримт материалыг гаргуулан авах, мэргэжлийн зөвлөгөө, тайлбар авах
5.5 Даатгалын хураамжийг тогтоосон цаг хугацаанд гэрээнд заагдсан нөхцөл, хураамжийн хувь хэмжээгээр шилжүүлэхийг шаардах.
5.6 Даатгалын гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэхийг Даатгуулагчаас шаардах.
5.7 Даатгагч нь даатгалын тохиолдол бий болсны улмаас Хөрөнгө оруулагчдад олгосон нөхөн төлбөрийг даатгуулагчаас эргүүлэн нөхөн авах эрхтэй
5.8 Даатгагч бондоос төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг төлөвлөгөөний дагуу зарцуулагдаж байгааг хяналт тавих буюу тийнхүү хяналт тавихад биечлэн оролцох эрхтэй
5.9 Захиалагчаас төслийн санхүүжилт хугацаандаа олгогдсон нөхцөлд бондын төлбөрт шаардлагатай хангалттай хэмжээний мөнгийг царцаах буюу зарцуулахгүй байхыг Даатгуулагчаас шаардах, Голомт банкинд Эскроу данс нээлгэж, уг дансанд байршуулахыг Даатгуулагчаас шаардах.
5.10 Даатгагч нь Даатгуулагчийн нээсэн Эскроу дансанд хяналт тавих ба уг дансан дахь хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрлийг олгоно.



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ ... ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

...Даатгуулагч энэхүү гэрээний хугацаанд үүргээ зөрчсөн тохиолдолд үүргийг ... өөрөөр гүйцэтгэхийг шаардах, шаардлага тавих эрхтэй.

### Зургаа. Даатгагчийн үүрэг

6.1 Даатгалын зах зээл, хууль тогтоомж, даатгалын нөхцөл, өөрийн санхүүгийн чадавхийн талаархи бүрэн, үнэн зөв мэдээллийг Даатгуулагчид тухай бүрд нь өгөх.

6.2 Монгол Улсын хуульд заасанаас бусад тохиолдолд Даатгуулагчийн болон энэхүү гэрээтэй холбоотой мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах, бусдад дамжуулахгүй байх.

6.3 Даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээний 9.3-д заасан бичиг баримтад үндэслэн, 9 дүгээр зүйлд заасан нөхөн төлбөр олгох нөхцөлийн дагуу хүндрэл чирэгдэл учруулалгүйгээр, түргэн шуурхай үйлчилж, нөхөн олговрыг Даатгуулагчийн нэрийн өмнөөс ҮЦТТХТ дэх Даатгуулагчийн дансанд бондын төлбөрийг шилжүүлэх замаар Хөрөнгө оруулагчдад даатгалын нөхөн төлбөрийг төлөх бөгөөд харин Даатгуулагчийн өмнө аливаа нөхөн олговор олгох үүрэг хүлээхгүй.

6.4 Даатгагч нь нөхөн төлбөрийг даатгалын тохиолдол үүссэн тохиолдолд ҮЦТТХТ дэх Даатгуулагчийн дансанд бондын төлбөр хийгдэх хугацаанд нэн даруй байршуулах үүрэгтэй.

6.5 Энэхүү гэрээний 4.4-т заасны дагуу Даатгуулагч дампуурсан, татан буугдсан тохиолдолд Даатгагч бондын төлбөрийг төлж барагдуулах үүрэгтэй.

6.6 Гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон Даатгагчийн буруутай үйл ажиллагааны улмаас Даатгуулагчид учруулсан аливаа хохирол, хардлыг бүрэн хариуцаж барагдуулах;

6.7 Даатгуулагчийн Голомт банкинд нээсэн Эскроу дансны зарцуулалтын хяналт.

6.8 Энэхүү гэрээнд заагдсан бусад үүрэг, хариуцлага.

6.9 Даатгалын тохиолдолд үүсээгүй тохиолдолд энэхүү гэрээний 3.3-т заасан даатгалын хураамжийн 70 хувийг даатгагчид буцаан олгоно.

### Долоо. Даатгуулагчийн эрх

7.1 Даатгалын зах зээл, хууль эрх зүйн болон Даатгагчийн санхүүгийн чадавхийн талаархи бүрэн дүүрэн үнэн зөв мэдээлэл гаргаж өгөхийг Даатгагчаас шаардах.

7.2 Гэрээнд заагдсан даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд Даатгагчид нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах эрхтэй ба 9.3-т заагдсан баримт материалыг бүрдүүлэн 9 дүгээр зүйлд заасан нөхөн төлбөр олгох нөхцөлийн дагуу саад, чирэгдэлгүйгээр, бүрэн хэмжээгээр даатгалын нөхөн төлбөрийг Даатгуулагчийн нэрийн өмнөөс ҮЦТТХТ дэх Даатгуулагчийн дансанд нөхөн төлбөрийг байршуулах замаар Хөрөнгө оруулагчдад шилжүүлэхийг Даатгагчаас шаардах.

7.3 Даатгагчийн санхүүгийн чадвар муудсан гэж үзэх хангалттай үндэслэл бий болсон бол нэмэлт барьцаа, эсхүл гуравдагч этгээдийн баталгаа, батлан даалт гаргуулахыг Даатгагчаас шаардах;

7.4 Даатгагчийн буруутай үйл ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлыг бүрэн барагдуулахыг Даатгагчаас шаардах.

7.5 Гэрээний хүчин төгөлдөр хугацаанд зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд даатгалын нөхцөлийг дордуулахгүй, даатгалын хураамжийг нэмэгдүүлэхгүй байх, зах зээлийн өрсөлдөөний нөхцөлийг хангахуйц бүтээгдэхүүн үйлчилгээгээр хангахыг шаардах.

7.6 Энэ гэрээний 7.2-т заасны дагуу өөрийн дансанд Даатгагчийн шилжүүлсэн мөнгийг Хөрөнгө оруулагчдад бондын төлбөр болон хүүд олгох.

7.7 Даатгалын гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэхийг Даатгагчаас шаардах.

### Найм. Даатгуулагчийн үүрэг

8.1 Даатгалын гэрээ байгуулахаас өмнө төсөл болон компанитай холбоотой бүхий л мэдээлэл, гэрээ болон бусад баримт бичгийг Даатгагчид танилцуулах.

8.2 Бондын төлбөрийг бондын хугацаанд Хөрөнгө оруулагчдад төлөх, энэхүү үндсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг дэч хэрэгжүүлэх.

4



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 51

Даатгалын тохиолдол үүсэх нөхцөл байдал бий болохоос сэргийлэх өөрөөс хамаарах бүхий л арга хэмжээг авах.

8.4 Даатгалын хураамжийг энэхүү гэрээний 3.3, 3.4-т заасан хэмжээгээр хугацаанд нь Даатгагчид төлөх.

8.5 Даатгалтай холбоотой баримт бичиг болон даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээний дагуу даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт бичгийг өөрийн зардлаар Даатгагчид үнэн зөв, бүрэн гүйцэд, хуулийн дагуу бүрдүүлэн, нэхэмжлэл гарган хүлээлгэн өгөх.

8.6. Энэхүү гэрээний 5.8-д заасны дагуу Даатгагчаас Хөрөнгө оруулагчдад олгосон даатгалын нөхөн төлбөрийг Даатгагчид нөхөн төлөх .

8.7 Даатгуулагч нь гэрээ байгуулснаас хойш шинээр бий болсон нөхцөл байдал, эрсдэлийн орчны өөрчлөлтийн талаар тухай бүрд нь Даатгагчид мэдэгдэх.

8.8 Шаардлагатай нөхөн төлбөрийн баримтуудыг Даатгагчид гаргаж өгөх.

8.9 Энэхүү гэрээний 5.8-т заасны дагуу Даатгагч шаардсан бол Захиалагчаас төслийн санхүүжилтээр хугацаанд нь шилжүүлсэн мөнгөнөөс бондын төлбөрт шаардлагатай хэмжээгээр царцаах буюу зарцуулахгүй байх, энэ хүртэл Голомт банканд Эскроу данс нээлгэж Захиалагчаас олгогдсон санхүүжилтээс Бондын төлбөрт хүрэлцэхүйц хэмжээний мөнгийг байршуулах, уг мөнгөн хөрөнгийг зөвхөн Бондын хугацаа болох үед Бондын төлбөрт зарцуулах. Эскроу данстай холбоотой зардлыг хариуцах.

8.10. Даатгагчид Эскроу дансны зарцуулалтанд хяналт тавих боломжоор хангах;

8.11. Төслийн хэрэгжилтийн гүйцэтгэл, санхүүжилтийн графикийн тухай мэдээллийг даатгагчид гаргаж өгөх;

8.12. Даатгагчийн зүгээс бондын зарцуулалтад хяналт тавих боломжоор бүрэн олгож, зарцуулалттай холбоотойгоор тавьсан шаардлагыг биелүүлэх;

8.13. Даатгагчид даатгалын тохиолдол болох нөхцөл бүрдсэн шалтгаан нөхцөлийн тухай Энэхүү гэрээний 4.2-т заасан хугацаа болохоос 15-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх;

8.14. Энэхүү гэрээний 4.4-т заасны дагуу Даатгагч дамжуулсан тохиолдолд Даатгуулагч бондын төлбөрийг төлж барагдуулах үүрэгтэй.

8.15 Энэхүү гэрээнд заагдсан бусад хүлээсэн үүргийг хариуцана.

**Ес. Даатгалын нөхөн төлбөрийн ерөнхий нөхцөл**

9.1 Энэхүү гэрээний дагуу даатгалаар төлөгдсөн нөхөн төлбөрийг Даатгуулагчаас Даатгагч эргүүлэн нэхэмжлэх эрхтэй.

9.2. Даатгагч нь Даатгуулагчийн энэхүү гэрээний 3.2-т заасан мэдэгдэл бичгээр ирсэн даруй нөөц үүсгэх ба бондын төлбөрийг хугацаанд нь барагдуулах арга хэмжээ авч, хугацаа болмогц нөхөн төлбөрийг олгоно. Энэ задлаар үүсгэх нөөцийг Голомт банканд байршуулна.

9.3. Даатгалын нөхөн төлбөрийг дараах баримт бичгийг үндэслэн олгох ба эдгээр баримт бичгийн эх хувь болон нэхэмжлэлийн хамтаар Даатгагчид Даатгуулагч хүлээлгэн өгнө. Үүнд:

9.3.1 Мэдэгдэл албан бичиг;

9.3.2. Бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ болон санхүүжилтийн график;

9.3.3. Бондын төлбөр төлөх хугацаа болон төлбөрийн нийт хэмжээ;

9.3.4 Бусад шаардлагатай баримт материалууд.

9.4 Даатгалын тохиолдол бий болсон үед дээрх 9.3-т заасан бичиг баримтад үндэслэн Даатгагч нь Даатгуулагчийн нэрийн өмнөөс нөхөн төлбөрийг ҮЦТТТХТ дэх Даатгуулагчийн дансруу заасан хугацаанд нэн даруй шилжүүлэх буюу Голомт банканд байршуулсан нөөцийг шилжүүлнэ.

9.5 Хөрөнгө оруулагч тус бүрийн дансанд харгалзах нөхөн төлбөр шилжиж орсон талаарх мэдээллийг ҮЦТТТХТ-өөс Даатгагч болон Андеррайтер гаргуулан авах эрхтэй байна.

5

ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

**Арав. Гэрээний нууцлал**

10.1 Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн мэдэх боломжтой, эзэмшиж, ашиглаж байсан/байгаа байх, ашиглах боломжтой баримт бичиг, мэдээ, мэдээлэл болон талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн болоод харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, дансны хэмжээ, тайлбар, тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага, хувь хүний нууц, ноу-хауг хугацаагүй чанд хадгална. Олон нийтэд ил тод болсон мэдээлэл нь үүнд хамаарахгүй бөгөөд тэдгээр мэдээллийн нууцлалыг хадгалах талуудын үүрэг нь уг мэдээлэл олон нийтэд ил тод болох хүртэл хугацаанд хүчинтэй байна.

10.2 Гэрээнд заснаас бусад асуудлаар талууд өөр хоорондын ашиг сонирхлыг хөндсөн хөндлөнгийн аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.

10.3 Талууд эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн өөр хоорондын байгууллагын нууцыг чанд хадгална.

10.4 Талууд ажил, үүргийн дагуу олж мэдсэн өөр хоорондын болон харилцагчийн аливаа мэдээллийг бусдад дамжуулах, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэй.

**Арван нэг. Гэрээний хариуцлага**

11.1 Гэрээнд заснаас бусад асуудлаар талууд өөр хоорондын ашиг сонирхлыг хөндсөн хөндлөнгийн аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.

11.2 Гэрээний аль нэг тал энэхүү гэрээний 10 дугаар зүйлд заасан гэрээний нууцлалыг задруулсны улмаас гэрээний нөгөө талд хохирол учирсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

11.3 Гэрээний аль нэг тал энэхүү гэрээнээс татгалзах эрхгүй байна.

**Арван хоёр. Талуудын албан ёсны хаяг, холбоо барих ажилтнууд**

| | |
|---|---|
| **Соёмбо Даатгал ХХК** | |
| Даатгал хариуцсан ажилтны нэр | Д.Мандухай |
| Албан тушаал | Даатгалын менежер |
| Утас | 976-7722 0707, 9908 5898 |
| Факс | 976-7722 0606 |
| **Эрчим Инженеринг ХХК** | |
| Гэрээ хариуцсан ажилтны нэр | Н.Баярмагнай |
| Албан тушаал | Гүйцэтгэх захирал |
| Утас | 99114904 |
| Цахим шуудан | [illegible] |

**Арван гурав. Бусад зүйл**

13.1 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомжид заагдсан эрхийг эдлэж, үүрэг хүлээнэ.

13.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт, өөрчлөлтийг энэхүү гэрээнд бичгээр оруулан талууд харилцан тохиролцон зөвшөөрсөн нөхцөлд уг өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилнэ.

6

- Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү гэрээ болон гэрээний талуудын эрх тэгш байдлын үндсэн дээр эв болох эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ

13.4 Энэхүү гэрээнд хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно

13.5 Энэхүү гэрээг 7 хуудас бүхий 3 хувь үйлдэх бөгөөд гэрээний эх хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД :**

**ДААТГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :**

Дэд захирал О.Оюунтогс

______________________
(Гарын үсэг)

Даатгалын менежер Д.Мандухай

______________________
(Гарын үсэг)

Хуулийн зөвлөх Б.Арвинбаяр

______________________
(Гарын үсэг)

**ДААТГУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Гүйцэтгэх захирал Н.Баярмагнай

______________________
(Гарын үсэг)

Ерөнхий нягтлан бодогч Б.Шинэзаяа

______________________
(Гарын үсэг)

7